



2012 оны 11 дүгээр сар.
Дугаар 2

Энэ дугаарын товъёог:

- 1 Легас ХХК-ийн шинэ бүтээлүүдийн товч танилцуулга**
 - "Нотариатын гэрчлэлийн ач холбогдол" өгүүлэл
 - Үнэт цаасны эрх зүйн цуврал лекц
 - Гэрээний эрх зүйн цуврал лекц
 - Арбитрын эрх зүйн цуврал лекц
 - Эвлэрүүлэлтийн цуврал лекц
 - "Монгол улс: Эрх зүйн боловсрол, мэргэжил, мэргэшил" өгүүлэл
 - "Монгол улсад эрх зүйн актыг хэрхэн баталдаг вэ?" өгүүлэл
- 2 Эрх зүйн мэдээллийн албанаас мэдээлж байна**
 - 2012 оны 10 дугаар сард батлагдсан хууль, эрх зүйн актын жагсаалт
 - УИХ-ын зарим тогтоолын товч танилцуулга
 - ЗГ-ын зарим тогтоолын товч танилцуулга
- 3 Таны эрх зүйн мэдлэгийн санд**
Улс болон бусад улсын иргэн, байгууллагын хоорондын хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай конвенц
- 4 Таны хууль зүйн англи хэлний боловсролд**
UMBRELLA [ʌmˈbrel.ə] noun
- 5 Таны асуултад хариулъя**
 - Хувийн тэтгэврийн сангийн талаарх ойлголт
 - Мэргэжлийн хариуцлагын даатгалын талаарх ойлголт
- 6 Таны сонирхолд**
Халх журам хууль
- 7 Легас ХХК нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж байна**
Асрах төвийн хүүхдүүдэд зориулж хандивын данс нээлээ
- 8 Эрх зүйн салбар дахь ажлын байр**
 - Эрх зүйн салбарт ажилд авна
 - Эрх зүйн салбарт ажил хайж байна



Legal & Technical translation in Chinese, English, German, Mongolian and Russian languages

Англи, Герман, Монгол, Орос, Хятад хэлээр
Хууль зүй, техникийн орчуулга хийх үйлчилгээ



Легас ХХК-ийн Англи, Герман, Монгол, Орос, Хятад хэлээрх хууль зүй, техникийн орчуулгын үйлчилгээ нь чанар, найдвартай ажиллагаа, мэргэжлийн түвшний хувьд харьцуулшгүй өндөр.

Таны эх бичвэрийг бид бүрэн дүүрэн, алдаа мэдэгдгүй хөрвүүлнэ.

Улаанбаатар хот, СБД, 3-р хороо
Усны гудамж, 11-р цогцолбор
ЛОНГ Бизнес төв, Бадмаараг офис

+ 976 11 324587

office@legas.mn
legas@mongol.net
www.legas.mn

Эрх зүйн зөвлөх үйлчилгээ - Эрх зүйн мэдээллийн өөрийн гэсэн нэгдсэн сантай



Легас ХХК-ийн эрх зүйн багийн хамт олон та бүхэнд дор дурдсан чиглэлээр үндэсний болон олон улсын шинжтэй гэрээ, хэлцэл, хэрэг маргаанд холбогдох асуудлаар мэргэжлийн өндөр түвшинд судалгаа, шинжилгээ хийх, хууль зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг санал болгож байна. Үүнд:

- ☞ Уул уурхай, ашигт малтмалын эрх зүй буюу ашиглалтын эрх зүй
- ☞ Өв залгамжлалын эрх зүй
- ☞ Үнэт цаасны эрх зүй
- ☞ Компани, хөрөнгө оруулалтын эрх зүй
- ☞ Татварын эрх зүй
- ☞ Гэрээний эрх зүй
- ☞ Арбитр
- ☞ Эвлэрүүлэлт

Манай үйлчилгээний давуу тал:

- Мэргэжлийн өндөр ур чадвартай, дагнан мэргэжсэн хуульч, эрх зүй судлаачидтай.
- Үйлчилгээ бүрийг эрх зүйн цогц судалгаанд үндэслэн хүргэдэг тул эрх зүйн эрсдэл, хийдлийг урьдчилан харах, сэргийлэх оновчтой шийдэл болж чаддаг.
- Хууль зүй, техникийн орчуулгын өөрийн албатай.
- Англи, Хятад зэрэг улсын эрх зүйн орчны талаар хуримтлуулсан мэдлэг, туршлагатай.
- Эрх зүйн мэдээллийн өөрийн гэсэн нэгдсэн сантай.
- Үйлчлүүлэгчдийнхээ нууцыг өндөр түвшинд хадгалах мэргэжлийн ёс зүйтэй баг.



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АКТЫН БАТАЛГААЖСАН ОРЧУУЛГА

VERIFIED TRANSLATION OF LAWS AND LEGISLATIVE ACTS

Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, эрх зүйн акт, дүрэм, журмуудыг англи хэлээр, Легас ХХК-ийн Хууль зүй, техникийн орчуулгын албанаас баталгаажуулсан байдлаар авах боломжтой.

- Зээлийн мэдээллийн тухай хууль
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- Уурхайг түр болон бүр мөсөн хаах журам
- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах аргачлал ... гэх мэт.

Англи хэлээрх эрх зүйн актын жагсаалтыг манай вэбсайтаас үзнэ үү

Та бүхний бизнесийг тусламцаа үзүүлж хамтран ажиллахдаа бид үргэлж баяртай байх болно.

The laws, legislative acts, rules and procedures currently effective in Mongolia can be accessed in English language as verified by the Legal and technical translation office of Legas LLC.

- The law on credit information
- The law on monitoring the handling of explosives and blasting agents, and blasting tools
- The law on licensing for business activities
- The rules for temporary or permanent closure of a mine
- The methodologies for calculation of the percentage of mineral reserves usage fees and charging thereof, ... etc.

Visit our website to view a list of legislative acts in English

We are always happy to render assistance to your business and collaborate with you.

www.legas.mn
976 11 324587
law.database@legas.mn



“Нотариатын гэрчлэлийн ач холбогдол” өгүүлэл

Нийгэм, эдийн засаг бүх талаараа хурдацтай хөгжиж, өсч дэвжихийн хэрээр гэрээ, хэлцэл, баримт бичгийг нотлох, баталгаажуулах шаардлага, ач холбогдол улам бүр нэмэгдэж байна. Эрх зүйн харилцаанд оролцогчид нотариатын гэрчлэлийг түгээмэл хэрэглэж байгаа өнөө үед түүний талаар зөв ойлголт, өргөн мэдлэгтэй байх зайлшгүй хэрэгцээтэй нь харагдаж буй тул бид тус өгүүллээрээ уншигч танд гэрчлэлийн төрлүүд, тэдгээрийн дундаас нотариатын гэрчлэлийн ач холбогдол, нотариатч, нотариатчийн үүрэг гүйцэтгэгч, нотариатаар заавал гэрчлүүлэх гэрээ хэлцэл зэргийн тухай практик хэрэглээ, үр дагаврын талаас нь дэлгэрэнгүй хүргэхийг зорилгоо.

Энэхүү өгүүлэл маань таны эрх, ашиг сонирхлыг хамгаалах чухал хэрэгслүүдийн нэг болох нотариатын гэрчлэлийг ажил хэрэгтээ зөв ашиглаж хэвшихэд таны тодорхой хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

Үнэт цаасны эрх зүйн цуврал лекц

Үнэт цаасны эрх зүйн цувралын маань эхний дугаар болох “Үнэт цаасны эрх зүй, үнэт цаасны зах зээлийн тухай үндсэн ойлголт” сэдэвт лекц бэлэн боллоо.

Энэхүү цуврал лекцэд Монгол улс, АНУ, БНХАУ зэрэг улс орнуудын үнэт цаасны эрх зүй, үнэт цаасны зах зээлийн тухай үндсэн ойлголт, эрх зүйн зохицуулалтыг тоймлон оруулсан нь та бүхэнд үнэт цаасны эрх зүйн онол практикийн мэдлэг, ухамсар, төлөвшил олгож, үнэт цаасны эрх зүйн харилцаанд харилцан тэгш эрхтэйгээр оролцох, зөв шийдвэр гаргахад дөхөм болгох, маргаан үүссэн тохиолдолд хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах, үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагаанд хууль зүйн бодит дүгнэлт өгөх чадвар, дадал эзэмшүүлэх эхлэлийг тавьж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Гэрээний эрх зүйн цуврал лекц

Иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх, үүрэг үүсгэх, өөрчлөх, дуусгавар болгоход чиглэсэн харилцан тохиролцоог гэрээ гэж тоймлон ойлгодог билээ. Цаашид үүсч болох хууль зүйн үр дагавар, эрсдэл, ашиг, алдагдал, маргаан зэрэг асуудал нь энэхүү тохиролцооноос ихээхэн хамаарч байдаг тул гэрээг өргөн мэдлэг, туршлагад үндэслэн хуулийн хүрээнд байгуулахын ач холбогдол асар өндөр юм. Энэ л ач холбогдолд нь тулгуурлан, шимтэн боловсруулсан тус цувралынхаа эхний дугаарыг та бүхэнд толилуулж байна.

Гэрээний эрх зүйн цуврал лекцийн маань зорилго нь гэрээний эрх зүйн талаар цэгцтэй, тойм мэдлэг олгож, эрсдэл багатай хүчин төгөлдөр гэрээ боловсруулах, гэрээний харилцаанаас үүдэн гарах эрх зүйн аливаа асуудалд хууль зүйн зөв дүгнэлт хийх чадвар болоод гэрээ хэлцлийг учирч болох эрсдэлээс хамгаалах хэрэгсэл болгон ашиглах дадлыг тань улам бэхжүүлэхэд оршино. Энэхүү зорилгынхоо хүрээнд бид Монгол улс, БНХАУ, ОХУ болон ИБУИНВУ-ын гэрээний эрх зүйн зохицуулалт, онол, практикийн онцлог, ялгаатай талуудыг ерөнхийд нь харьцуулж тусгалаа.

Тус цуврал маань гадаад, дотоодын түншүүдтэйгээ хамтран ажиллах их үйлсэд тань жинтэй хувь нэмэр оруулна гэдэгт бид итгэлтэй байна.

Эрхэм уншигч та бидний бүтээлд санал, сэтгэгдлээ ирүүлвэл гүнээ талархах болно.

Олон улсын арбитрын эрх зүйн цуврал лекц

Олон улсын арбитрын эрх зүйн цуврал лекц маань уншигч танд олон улсын арилжааны арбитрын талаар ойлголт өгөх, онол, практикийн мэдлэг эзэмшүүлэх зорилготой. Уг зорилгыг биелүүлэхийн тулд арбитрын гэрээгээс эхлээд арбитрын ажиллагааны үр дүнд гарах арбитрын шийдвэрийг биелүүлэх хүртэл үргэлжлэх бүрэн цогц мэдээлэл бүхий арбитрын аяны богцыг задлах болно.

Тус цувралд олон улсын болоод харьцууллын үүднээс эх газрын эрх зүйт, эх газрын эрх зүйт социалист, англо-саксоны эрх зүйт системүүдийн төлөөлөл болохынх нь хувьд сонгосон Монгол, Эх газрын Хятад, Англи ба Уэльс улсуудын эрх зүйн тогтолцоог голлон авч үзнэ.

Цуврал лекцийн маань эхний дугаар арбитрын тухай ерөнхий тойм, арбитрын төрөл, арбитрын холбогдолтой бүсийн болон олон улсын хууль зүйн баримт бичгүүд, үндэсний хууль тогтоомж, арбитр ба шүүхийг харьцуулах нь, арбитраар маргаан шийдвэрлүүлэх тохиролцоо гэсэн үндсэн хэсгүүдээс бүрдэж байгаа.

Бизнесийн амжилт, цаг хугацаа болоод хөрөнгө мөнгөний зөв менежментийн үндэс нь мэдлэг билээ. Энэхүү бүтээл маань таны мэдлэгийн сан арвижихад бодит хувь нэмэр оруулж, олон улсын худалдааны гэрээндээ маргаан шийдвэрлэх тухай заалт заавал оруулах, оруулахдаа арбитрын шийдвэрийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөх, биелүүлэх эрх зүйн гол, нийтлэг үндэс суурь болох Нью-Йоркийн конвенцид¹ дэлхийн 147² улс нэгдэн ороод байгааг харгалзан үзэж, маргаанаа арбитраар шийдвэрлүүлэх тухай салаа утгагүй, хүчин төгөлдөр заалт оруулах эсхүл бие даасан арбитрын гэрээ байгуулах зэргээр бизнесийн үйл ажиллагаанд тань тусгалаа олно гэдэгт бид итгэлтэй байна.

¹ Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай 1958 оны конвенц http://www.uncitral.org/uncitral/en/uncitral_texts/arbitration/NYConvention.html

² http://www.uncitral.org/uncitral/en/uncitral_texts/arbitration/NYConvention_status.html (2012.10.30)

Олон улсын бизнесийн маргаан эвлэрүүлэлтийн цуврал лекц

Олон улсын бизнесийн маргаан эвлэрүүлэлтийн цуврал лекцийн маань зорилго нь эвлэрүүлэлтийг цаг хугацаа, хөрөнгө мөнгө хэмнэх, бизнесийн харилцаагаа үл тасалдуулах, улам бүр өргөжүүлэн тэлэх хэрэглүүр болгон ашиглах дадлыг бизнес эрхлэгчдэд хэвшүүлэх, мөн сонирхогчдод чадварлаг эвлэрүүлэгч болох бодит, үр бүтээмжтэй аян замынх нь анд байхын зэрэгцээ мэргэшсэн эвлэрүүлэгчдийг мэргэжлийн түвшний лавлагаа, мэдээллийн эх сурвалжаар хангахад оршино. Энэхүү цувралын “олон улсын бизнесийн маргаан эвлэрүүлэлт” хэмээх нэршил нь бизнесийн маргаанд, тэр дундаа хил дамнансан бизнесийн эрх зүйн маргаанд голчлон төвлөрөх агуулгыг нь илтгэж буй хэрэг юм.

Тус цувралд, 2012.5.22-нд батлагдсан, 2013.7.1-нээс даган мөрдөж эхлэх Эвлэрүүлэн зуучлалын тухай хуультай Монгол улс дахь эвлэрүүлэлтийн ажиллагааг голлон хамруулахын зэрэгцээ хэдэн зууны турш маргааныг эвлэрүүлэлтээр шийдвэрлэж ирсэн, дорнын соёлын төлөөлөл болох БНХАУ болон 2001 оноос хойш эвлэрүүлэлтийг сонгодог утгаар нь өргөн хүрээтэй, үр бүтээлтэй ашиглаж буй, өрнийн соёлын төлөөлөл болох ИБУИНВУ дахь эвлэрүүлэлтийн практикийг харьцуулан авч үзэх болно.

Цуврал лекцийнхээ эхний дугаарт эвлэрүүлэлтийн талаарх ерөнхий ойлголт, үзэл баримтлал, эвлэрүүлэлтийн онцлог шинж чанарууд, төрөл, зарчмууд болон эвлэрүүлэлтийн процессын тухай танилцуулна.

Эвлэрүүлэлт бол маргаан шийдвэрлэх шүүхийн бус арга; процедурын, сэтгэл зүйн болоод үр дүнгийн аль алиных нь хувьд сэтгэл хангалуун үлдэх боломжийг талуудад олгодог ур чадвар юм; эвлэрүүлэгчийн мэргэжлийн үр чадвараар тодорхойлогддог урлаг юм.

Таны бизнест өндөр амжилт хүсэхийн ялдамд ажил үйлс, ахуй амьдралын тань харгуй зам дардан, эв эе, эвлэрлээр дүүрэн байх болтугай хэмээн ерөөе.

"Монгол улс: Эрх зүйн боловсрол, мэргэжил, мэргэшил" өгүүлэл

Бид энэхүү өгүүлэлдээ Монгол улс дахь эрх зүйн боловсролын тогтолцоог тодорхойлохын зэрэгцээ хуульч хэмээх эрхэм хүндтэй мэргэжлийг эзэмшихэд туулах зам, давах давааны тухай өгүүлж, төр, нийгэм дэхь хуульч, эрх зүйчдийн үүрэг, оролцоо, байр суурийг тоймлон харууллаа.

Тус өгүүлээс та эрх зүйн боловсрол олгож буй улсын болон хувийн хэвшлийн их, дээд сургуулиуд, эрдмийн зэрэг олгох сургалт, тэдгээрийн төлбөр, суралцах хугацаа, мөн энэ чиглэлээр их, дээд сургууль төгсөгчид болон салбарын мэргэжилтнүүдийн ажиллаж болох байгууллага, албан тушаалын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой.

Эрх зүйн мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх албан ба албан бус, танхимын болон онлайн сургалт, хууль зүйн англи хэлний сургалтын талаарх цогц мэдээлэл нь хуульч таны болоод ирээдүйн хуульч хэн бүхний сонголт, оюуны чадал, чансааг сорьсон эрх зүйн салбарт мэргэших, мэргэжлээрээ ахиж дэвших боломжуудыг өргөжүүлэн тэлэхэд бага боловч хувь нэмэр оруулаад зогсохгүй эрх зүйн боловсролын бодлого боловсруулагчид, эрх зүйн боловсрол олгогчид ч мөн адил салбарын бодит байдал, хэрэгцээ шаардлагын дүр зургийг бүхэлд нь харж, улмаар тус салбарыг илүүтэй хөгжүүлэх, улам боловсронгуй болгоход шаардагдах өөрчлөлтүүдийг цаашдын үзэл баримтлал, ажил үйлсдээ тусгахад тус дөхөм болно гэдэгт бид итгэлтэй байна.

"Монгол улсад эрх зүйн актыг хэрхэн баталдаг вэ?" өгүүлэл

Энэхүү өгүүлэл маань эрх зүйн салбарынхан болоод эрх зүйн салбарыг сонирхогч хүн бүрт оюуны хөрөнгө оруулалт болно гэдэгт бид итгэлтэй байна.

Тус өгүүлээс та бүхэн Монгол улсын эрх зүйн тогтолцооны талаарх товч ойлголт, эрх зүйн актуудын ангилал, нэршил, тодорхойлолтыг мэдэж авахын зэрэгцээ Монгол улс дахь хууль тогтоох үйл ажиллагааны аргачлал, үе шат, дэс дараалал, дэг жаяг, хамрах хугацаа, мөн түүнчлэн хуулийн төсөл санаачлах, боловсруулах, өргөн мэдүүлэх, хэлэлцэх, хориг тавих эрх, үүрэг бүхий субъектууд, эрх зүйн мэдээллийн албан ёсны эх сурвалжууд, хууль эрх зүйн актыг нийтийн хүртээл болгох, нийтээр дагаж мөрдөхтэй холбоотой зохицуулалт, журмын талаар цогц мэдээлэлтэй болно.

Ардчилсан төр, нийгэм оршин тогтнох нэгэн үндэс суурь болсон хуулийг тогтоох ажиллагааны талаар үндсэн мэдлэг эзэмшиж, уг ажиллагаанд иргэний хувьд өөрийн оролцоог хэрэгжүүлэх, нэмэгдүүлэхэд ч мөн тус дөхөм болох нь лавтай.

Та бүхний нийгмийн идэвх өндөр байж, улс орны маань хуулийн тогтолцоо улам бүр батжин бэхжих болтугай.

Та эдгээр өгүүллийг бүрэн эхээр нь худалдаж авахыг хүсвэл legas@mongol.net хаягаар хандаарай.

ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ МЭДЭЭ

2012 оны 10 дугаар сард дараах хууль, эрх зүйн актууд тус тус батлагдлаа

УИХ-аас

- 2012.10.11-ний өдөр Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль;
- 2012.10.24-ний өдөр Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- 2012.10.25-ны өдөр Монгол Улсын нэгдсэн төсвийн 2013 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2014-2015 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Концессын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль;
- 2012.10.26-ны өдөр Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хуулиуд;

УИХ-аас

- 2012.10.4-ний өдөр Бүгд Найрамдах Панам Улстай дипломат харилцаа тогтоох тухай 38 тоот; Бутаны Вант Улстай дипломат харилцаа тогтоох тухай 39 тоот;
- 2012.10.5-ны өдөр Н.Лувсанжавыг СЕХ-ны гишүүн, СЕХ-ны даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай 40 тоот; Ч.Содномцэрэнг СЕХ-ны даргаар томилох тухай 41 тоот; Б.Алтанжаргалыг СЕХ-ны нарийн бичгийн даргаар томилох тухай 42 тоот; СЕХ-ны гишүүнээр Д.Дэлгэрцогтыг томилох тухай 43 тоот; Монголбанкны Дэд ерөнхийлөгчөөр Э.Батшугарыг томилох тухай 44 тоот;
- 2012.10.11-ний өдөр Ч.Раднааг Монгол Улсын Ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай 45 тоот; Монгол Улсын Ерөнхий аудитороор А.Зангадыг томилох тухай 46 тоот;
- 2012.10.12-ны өдөр ЗГ-аас 2012.9.29-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн "Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" УИХ-ын тогтоолын төслийг буцаах тухай 47 тоот;
- 2012.10.24-ний өдөр МУЗГ-аас 2012.9.29-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Банкин

- дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг буцаах тухай 48 тоот; Монгол Улсын 2011 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай 49 тоот; Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай 50 тоот;
- 2012.10.25-ны өдөр Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2013 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай 51 тоот; Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай 52 тоот тогтоолууд;

ЗГ-аас

- 2012.10.1-ний өдөр "Аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулах тухай" ЗГ-ын 2012.9.22-ны өдрийн 47 тоот; "Хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 2012.6.13-ны өдрийн 200 тоот тогтоолд тус тус өөрчлөлт оруулах тухай 73 тоот;
- 2012.10.6-ны өдөр "Биржийн нэр зарлах тухай" Засгийн газрын 2007.4.4-ний өдрийн 88 тоот тогтоолын 2 дугаар хавсралтад өөрчлөлт оруулах тухай 74 тоот; "Спортын бэлтгэлийн төв байгуулах тухай" ЗГ-ын 2012.9.15-ны өдрийн 34 тоот тогтоолд өөрчлөлт оруулах тухай 75 тоот; "Сайншанд" аж үйлдвэрийн цогцолбор байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай 76 тоот; Буудай үйлдвэрлэгч иргэн, хуулийн этгээдэд дотоодын гурилын үйлдвэр болон Тариаланг дэмжих санд нийлүүлсэн стандартын шаардлага хангасан хүнсний улаан буудайн нэг тонн тутамд олгох мөнгөн урамшууллын хэмжээг 100,000 төгрөгөөр тогтоох тухай 77 тоот;
- 2012.10.13-ны өдөр Засгийн газрын тохируулагч агентлаг-Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга О.Магнайд Улсын ерөнхий байцаагчийн эрх олгох тухай 85 тоот; Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай ЗГ-ын 2010.9.15-ны өдрийн 237 тоот тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 86 тоот; Дотоод хэргийн их сургуулийг Хууль сахиулахын их сургууль болгон өөрчлөн зохион байгуулах тухай 87 тоот; Монгол улсын Засгийн газар, гадаад улсын Засгийн газар хооронд байгуулсан худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийн бүрэлдэхүүний тухай 88 тоот; Иргэдийг орон сууцжуулах, ипотекийн зээлийн тогтолцоог бий болгох ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Үндэсний хороо байгуулах тухай 90 тоот; "Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв" улсын төсөвт үйлдвэрийн газар байгуулах тухай 91 тоот; Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн талаар авах арга хэмжээний тухай 92 тоот; БНСУ-д ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдэд үйлчилдэг "БНСУ дахь үйлчилгээний төв"-ийн бүтцийг өөрчлөх тухай 94 тоот;

- 2012.10.20-ны өдөр Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн буюу консулын газар, НҮБ, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газар, гадаад улс, олон улсын хэвлэл мэдээллийн төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэнийг бүртгэх журам батлах тухай 97 тоот; Дулааны IV цахилгаан станцын хүчин чадлыг нэмэгдүүлж 100 МВт-ын турбингенератор шинээр суурилуулах тухай 99 тоот;
- 2012.10.27-ны өдөр Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдийн үдийн цайны өдрийн зардал, цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардал болон ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлын хэмжээг тогтоох тухай 106 тоот; "Тэтгэмж, тусламж, хөнгөлөлтийн хэмжээг тогтоох тухай" ЗГ-ын 2012.5.30-ны өдрийн 184 тоот тогтоолыг хүчингүй болгох тухай 107 тоот; "Тэтгэмжийн хэмжээг тогтоох журам батлах тухай" ЗГ-ын 2012.7.4-ний өдрийн 228 дугаар тогтоолыг хүчингүй болгох тухай 108 тоот; Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16, 17 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлэх тухай 109 тоот; Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж шилжүүлэх өөрийн хөрөнгөөр гүйцэтгэн дараа төлөгдөх нөхцөлтэйгээр барих зарим авто замын жагсаалт батлах тухай 110 тоот; Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн талаар авах арга хэмжээний тухай ЗГ-ын 2012.10.13-ны өдрийн 92 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай 111 тоот тогтоолууд.

Бутаны Вант Улс болон Бүгд Найрамдах Панам Улстай дипломат харилцаа тогтоох тухай УИХ-ын 38, 39 тоот тогтоолуудын товч танилцуулга

Монгол улсын Үндсэн хуулийн 25.1.15 дахь заалтыг үндэслэн 2012.10.4-ний өдөр баталсан эдгээр тогтоолоор Монгол улс нь Бутаны Вант Улс болон Бүгд Найрамдах Панам Улстай дипломат харилцаа тогтоосныг тус тус баталгаажуулжээ.

Бутаны Вант Улс нь 47,000 км² газар нутагтай, хүн амын тоо нь 750,000 орчим, албан ёсны хэл нь зонха бөгөөд дэлхий дээрх ардчилсан хаант засаглалтай цорын ганц улс юм.¹ Шашны² эрх зүйн тогтолцоотой тус улсын хууль тогтоох

¹ <http://www.asia-planet.net/bhutan/information.htm>

² <http://www.judiciary.gov.bt/html/judiciary/legal.php>

дээд байгууллага нь Үндэсний Ассамблей³ ажээ.

Бүгд Найрамдах Панам Улс нь 74,177 км² газар нутагтай, хүн амын тоо нь 3,643,000, албан ёсны хэл нь испани, улс төрийн олон намын тогтолцоотой улс юм. Эх газрын эрх зүйн тогтолцоотой тус улсын хууль тогтоох дээд байгууллага нь нэг танхимтай Үндэсний Ассамблей юм байна⁴.

³ <http://www.nab.gov.bt/aboutus.php>

⁴ <http://law.wustl.edu/WUGSLR/CitationManual/countries/panama.pdf>

Энэ дашрамд дурдахад 2012.10.29-ний өдөр Ямайк улстай дипломат харилцаа тогтоох тухай хамтын ажиллагааны баримт бичгийг үзэглэснээр⁵ 2012.10.29-ний өдрийн байдлаар Монгол улс нийт 165⁶ улстай дипломат харилцаа тогтоогоод байна.

⁵ Гадаад хэргийн яамны мэдээлэл гадаад сурталчилгааны хэлтсийн даргаас утсаар авсан мэдээлэл (2012.10.30)

⁶ http://law.mfat.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=70&Itemid=83&lang=mn

Дотоод хэргийн их сургуулийг өөрчлөн зохион байгуулах тухай Засгийн газрын 87 тоот тогтоолын товч танилцуулга

Дээд боловсролын тухай хуулийн 6.3 дахь заалтыг үндэслэн Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор баталсан эл тогтоолд Хууль зүйн салбарын шинэчлэлийн хүрээнд Дотоод хэргийн их сургуулийг¹ Хууль сахиулахын их сургууль болгон өөрчлөн зохион байгуулахаар зааж, тус сургуулийн захирлыг 2012 оны 10 дугаар сард багтаан томилж,

¹ <http://www.uia.edu.mn/>

бүтэц, орон тооны хязгаар, дүрмийг батлан мөрдүүлж, сургалтын хөтөлбөр, агуулга, чанарыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, сургалтын орчныг сайжруулах, багш нарыг мэргэшүүлэх талаар төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллахыг Хууль зүйн сайд Х.Тэмүүжинд даалгажээ.

Мөн түүнчлэн Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэн,

Тусгай мэргэжлийн сургалтын төвийг Хууль сахиулахын их сургуульд нэгтгэхээр тогтоосны зэрэгцээ Засгийн газрын 2008.4.30-ны өдрийн "Гамшиг судлалын хүрээлэн байгуулах тухай" 156 тоот тогтоол, 2011.7.6-ны өдрийн "Дотоод хэргийн их сургууль байгуулах тухай" 229 тоот тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсон байна.

"Биржийн нэр зарлах тухай" ЗГ-ын 2007.4.4-ний өдрийн 88 тоот тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай ЗГ-ын 2012.10.6-ны өдрийн 74 тоот тогтоолын товч танилцуулга

Ашигт малтмалын тухай хуулийн 47.2.3¹ дахь заалтыг үндэслэн "Биржийн нэр зарлах тухай"

¹ "Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхайн эдэлбэрээс олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг ... дараахь журмаар тооцно: ... дотоод, гадаадын зах зээлд борлуулсан бүтээгдэхүүний зах зээлийн жишиг үнийг тодорхойлох боломжгүй тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдүүлсэн борлуулалтын орлогыг үндэслэн."

Засгийн газрын 2007.4.4-ний өдрийн 88 тоот тогтоолын 2 дугаар хавсралтын 6 дахь заалтыг "Нүүрс-Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нүүрс борлуулж, экспортод гаргах гэрээний үнэ." болгож өөрчлөн найруулахаар заасан энэ тогтоолыг 2012.10.1-2013.4.1-ний хугацаанд дагаж мөрдөх ажээ.

Тус тогтоолоор, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайланг нүүрсний борлуулалтын гэрээ болон гэрээний монгол хэл дээрх албан ёсны орчуулгын хамт авч байх үүргийг Татварын ерөнхий газарт даалгасан байна.

"Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай" ЗГ-ын 2010.9.15-ны өдрийн 237 тоот тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай ЗГ-ын 2012.10.13-ны өдрийн 86 тоот тогтоолын товч танилцуулга

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 19.1, 19.2¹ дахь заалтуудыг үндэслэн баталсан эл тогтоолд

¹ 19.2.Энэ хуулийн 19.1-д заасан үйлчилгээний хөлсний хэмжээг Засгийн газар тогтооно. (19.1.Хууль тогтоомжид заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, лавлагаа, мэдээлэл өгөхөд үйлчилгээний хөлс төлнө.)

"Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай" ЗГ-ын 2010.9.15-ны өдрийн 237 тоот тогтоолын хавсралтын 2.1-д заасан "Монгол Улсын иргэний үнэмлэх олгох, дахин олгох-10000 төгрөг" гэснийг

"Монгол Улсын иргэний үнэмлэх олгох, дахин олгох-15000 төгрөг" гэж өөрчлөхөөр заасан байна.

ТАНЫ ЭРХ ЗҮЙН МЭДЛЭГИЙН САНД

Улс болон бусад улсын иргэн, байгууллагын хоорондын хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай конвенц¹

Хөрөнгө оруулагчдын хувьд төр эсхүл төрийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанитай холбоотой үүссэн маргаанаа шийдвэрлүүлэх гол сонголт нь Хөрөнгө Оруулалтын Маргаан Шийдвэрлэх Олон улсын Төвд² (ХОМШОУТ) хандах явдал юм.

ХОМШОУТ нь олон улсын хөрөнгө оруулалтын маргааныг эвлэрүүлэлт, арбитраар шийдвэрлэх тогтолцоо, арга хэрэгслийг хангах үндсэн зорилготой

¹ <https://icsid.worldbank.org/ICSID/ICSID/RulesMain.jsp>

² <https://icsid.worldbank.org/ICSID/Index.jsp>

бөгөөд Дэлхийн банкны гүйцэтгэх захирлууд боловсруулж, 1965.3.18-нд үзэглэхэд нээлттэй болж, 1966.10.14-ний өдөр хүчин төгөлдөр болсон, өдгөө 158³ гишүүн улс бүхий Улс болон бусад улсын иргэн, байгууллагын хоорондын хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай 1965 оны Конвенц буюу Вашингтоны конвенцийн дагуу үүсгэн байгуулагдсан олон улсын автономит институт юм.

Монгол улс тус олон талт гэрээг 1991.6.14-ний өдөр үзэглэж, соёрхон баталсан болохоо ХОМШОУТ-ийн Нарийн бичгийн даргын газарт мэдэгдсэн ба улмаар тус конвенц нь 1991.7.14-ний өдөр манай улсад хүчин төгөлдөр болсон билээ⁴.

Монгол улс Вашингтоны конвенцид нэгдсэнээр тус конвенц түүнчлэн 43⁵ улстай байгуулсан Монгол улсын хөрөнгө оруулалтын хоёр талт гэрээ болон холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийн дагуу гадаадын хөрөнгө оруулагчид манай улсад хийсэн хөрөнгө оруулалттай нь холбогдон маргаан үүссэн тохиолдолд тухайн маргааныг шийдвэрлүүлэхээр ХОМШОУТ-д хэрэг үүсгүүлэх шууд статус, эрх зүйн орчин бүрдсэн билээ.

2004 онд ХОМШОУТ-д Монгол улстай холбоотой нэгэн хэргийг үүсгэсэн байна. Алстом Пауэр Италия ХХОНК (Alstom Power Italia SpA) болон Алстом ХХОНК (Alstom SpA) (Итали улс) нь Эрчим хүчний чартерын гэрээний⁶ дагуу Монгол улсын эсрэг гаргасан нэхэмжлэлийн үндсэн дээр 2004.3.18-ны өдөр ARB/04/10 тоот хэргийг⁷ үүсгэсэн бөгөөд талуудын эвлэрэх хүсэлтийг үндэслэн Арбитрын бүрэлдэхүүн 2006.3.13-ны өдөр арбитрын ажиллагааг зогсоох шийдвэр гаргаснаар уг хэрэг хаагджээ.

Манай улстай холбоотой хөрөнгө оруулалтын маргаанаар ХОМШОУТ-д хандсан эсэхийг бид байнга ажиглаж, холбогдох мэдээллийг та бүхэнд цаг тухайн үед хүргэж байх болно.

³ https://icsid.worldbank.org/ICSID/FrontServlet?requestType=CasesRH&actionVal=ShowHome&pageName=MemberStates_Home

⁴ <https://icsid.worldbank.org/ICSID/FrontServlet?requestType=ICSIDDocRH&actionVal=ContractingStates&ReqFrom=Main>. "Төрийн мэдээлэл" сэтгүүл, тусгай дугаар, II боть, 2005, 573 дахь талд Монгол улс тус конвенцид 1996.5.28-ны өдөр нэгдэн орсон хэмээн дурдсан байгаа боловч Легас ХХК-ийн зүгээс тодруулга хүсч ХОМШОУТ-д хандаж бичсэн захидлын хариуд ХОМШОУТ-ийн Нарийн бичгийн даргын газраас 1991.6.14 ба 1991.7.14-ний өдрүүдийг баталгаажуулсан болохыг энд цохон тэмдэглэж байна.

⁵ <http://www.unctad.org/Templates/Page.asp?intItemID=2344&lang=1>

⁶ <http://www.encharter.org/index.php?id=213>

⁷ <http://icsid.worldbank.org/ICSID/FrontServlet?requestType=GenCaseDtIsRH&actionVal=ListConcluded>

ТАНЫ ХУУЛЬ ЗҮЙН АНГЛИ ХЭЛНИЙ БОЛОВСРОЛД

UMBRELLA [ʌm'breɪ] noun

1 шүхэр, нарны хаалт, нарны халхавч

I prefer small folding umbrellas.

Надад эвхдэг жижиг шүхэр дээр санагддаг.

2 төв байгууллага, толгой байгууллага, том байгууллага, олон салбартай байгууллага, олон гишүүнтэй байгууллага, гишүүнчлэлтэй байгууллага, олон жижиг байгууллагыг [эгнээндээ] нэгтгэсэн том байгууллага

umbrella group/organisation

The united nations is an umbrella organisation with 192 member states.

Нэгдсэн Үндэстний Байгууллага нь 192 гишүүн улс бүхий том байгууллага юм.

umbrella company – компаниудын нэгдэл (захиалагч, үйлчлүүлэгч, харилцагчдад үйлчилгээгээ илүү оновчтой, үр ашигтай байдлаар хүргэх зорилгоор албан бусаар зохион байгуулагдсан нэгдэл)

Umbrella companies market themselves to be 100% committed to customer service.

Компаниудын нэгдлүүд харилцагчдадаа үзүүлэх үйлчилгээнд өөрсдийгөө 100% зориулдаг хэмээн сурталчилдаг.

umbrella term – хэд хэдэн үзэл баримтлалыг хамрах нэг ойлголт, цогц ойлголт, нэгдсэн ойлголт, өргөн ойлголт, өргөн хүрээтэй ойлголт

Marketing is an umbrella term for a range of activities that span across research, advertising, sales, promotions and public relations.

Маркетинг бол судалгаа, зар сурталчилгаа, борлуулалт, урамшуулал, олон нийттэй харилцах харилцаа зэргийг хамарсан өргөн хүрээтэй ойлголт юм.

umbrella limited partnership - "халхавч" хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл (ХХН), үл хөдлөх эд хөрөнгийн хөрөнгө оруулалтын траст (ҮХЭХХОТ) (үл хөдлөх эд хөрөнгө өөрөө шууд эзэмшилгүйгээр, ямар нэг компанийн хувьцаагаар сольж авах замаар эзэмшиж болох ба уг үйл явцыг хэрэгжүүлэхэд ашиглагддаг ХХН-ийг "халхавч" ХХН гэнэ)

umbrella-partnership real-estate investment trust (UPREIT) - Өөрөө шууд эзэмшилгүйгээр, "халхавч" ХХН-ийн хувьцаагаар сольж авах замаар үл хөдлөх эд хөрөнгө эзэмшиж, уг эд хөрөнгөө "халхавч" ХХН-өөр дамжуулан хянаснаар зарим борлуулагчдад нэн даруй татвар төлөх үүрэг хүлээхгүй байх нөхцөлийг бүрдүүлж өгдөг ҮХЭХХОТ

An UPREIT gives real estate owners access to public capital markets, while permitting them to defer taxes.

ҮХЭХХОТ нь татвар төлөх хугацааг хойшлуулах боломжтойгоор нээлттэй хөрөнгийн зах зээлд оролцох бололцоог үл хөдлөх эд хөрөнгө эзэмшигчдэд олгодог.

umbrella policy (umbrella liability coverage) - үндсэн даатгалаас давсан хохирлыг хамруулдаг нэмэлт даатгал (мөн "bumbershoot insurance" гэж нэрлэх нь бий)

If the standard policy does not cover any loss, such outstanding balance can then be submitted to the umbrella policy provider for consideration.

Хэрэв үндсэн даатгал нь аль нэг хохирлыг хамруулаагүй бол хамрагдаагүй үлдсэн тэрхүү хохирлын талаарх хүсэлтийг үндсэн даатгалаас давсан хохирлын нэмэлт даатгалын даатгагчид гаргаж болно.

umbrella agreement (umbrella contract) - цогц гэрээ, бүхнийг хамруулсан гэрээ, бараа бүтээгдэхүүн нийлүүлэгч эсвэл үйлчилгээ үзүүлэгч ба захиалагчийн хооронд байгуулдаг их хэмжээний захиалга гүйцэтгэх ажлыг хялбарчлахын тулд ерөнхий цар хүрээг нь урьдчилан тогтоож өгсөн гэрээ

Umbrella agreements are usually concerned with immediate contract terms and conditions that may occur in the future.

Цогц гэрээнд гол төлөв ирээдүйд үүсч болох нөхцөл байдлын талаарх нөхцөл, болзлыг тусгадаг.

The Agreement establishing the WTO serves as an umbrella agreement.

ДХБ-ыг байгуулах тухай гэрээ нь цогц гэрээ болж үйлчилдэг.

Мэргэжлийн хариуцлагын даатгалын талаар товч ойлголт өгнө үү.

Мэргэжлийн хариуцлагын даатгал гэдэг нь даатгуулагч мэргэжлийн ажил үүргээ гүйцэтгэх, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх явцдаа ямар нэг алдаа гаргасны улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсан тохиолдолд хүлээх хариуцлагын эрсдэлийг бууруулах зорилго бүхий даатгалын бүтээгдэхүүний нэг төрөл юм.

Орчин үед захиалагч, хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн мэдлэг боловсрол, чадвар, бизнес эрхлэлтийн түвшин, мэргэжлийн ажил үйлчилгээнд тавих шаардлага улам бүр өсөн нэмэгдэхийн хэрээр хувь хүн болон байгууллага аль аль нь мэргэжлийн ажил, үйлчилгээ эрхлэгчдийг сонгохдоо мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулсан эсэхийг нь гол шалгууруудын нэг болгож авч үзэх болсон. Даатгалын бүтээгдэхүүний төрлүүд дундаас мэргэжлийн хариуцлагын даатгал нь зөвхөн даатгуулагчийг төдийгүй даатгуулагчаас ажил, үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчийг ч мөн эрсдэлээс хамгаалдагараа онцлог юм.

Аль салбарын мэргэжилтнүүд мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулах нь түгээмэл байдаг вэ?

Монгол улсын даатгалын компаниуд мэргэжлийн хариуцлагын даатгалд эмч, хуульч, брокер, нягтлан бодогч, орчуулагч, сэтгүүлч, тээвэрлэгч зэрэг олон салбарын мэргэжилтнүүдийг даатгаж байгаа бөгөөд даатгалын бүтээгдэхүүний төрөл нь "бүх мэргэжлийн хариуцлагын даатгал" гэсэн нэршилтэй байдаг.

Зарим салбарын мэргэжилтнийг хариуцлагын албан журмын даатгал буюу мэргэжлийн хариуцлагын даатгалд заавал даатгуулахыг хуулиар шаарддаг. Тухайлбал, нотариатч нь нотариатын үйлдлийг буруу хийсэн, үйлчлүүлэгчийн хувийн байдлыг буруу тогтоосон зэрэг бусад буруутай үйлдлийн улмаас үйлчлүүлэгчид хохирол учруулсан тохиолдолд түүнийг нөхөн төлөх зорилгоор хариуцлагын даатгалд заавал даатгуулах үүрэгтэй¹. Мөн тээврийн хэрэгслийн өмчлөгч бүр, түүнчлэн тээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч буюу автотээврийн хэрэгслийг жолоодох ажил гүйцэтгэж өөрт ашиг, орлого олох зорилгоор эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу сургалтын хөтөлбөрт хамрагдан мэргэжлийн үнэмлэх авсан этгээд болон "С", "D" ангиллын тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцох жолооч нь тээврийн хэрэгслийн өмчлөгч эсэхээс үл хамааран жолоочийн даатгалд заавал даатгуулна². Эдгээрээс гадна, 2014.1.1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх "Хуульчийн эрх зүйн байдлын тухай" хуульд зааснаар³ шүүхэд төлөөлөх эрх нээлгэхийг хүсч буй хуульч нь өмгөөлөгчийн хариуцлагын даатгалд заавал даатгуулах үүрэгтэй.

Даатгагчаа сонгохдоо ямар хүчин зүйлсийг харгалзаж үзэх нь зүйтэй вэ?

Даатгагч компани нь хэр удаан хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа, сүүлийн жилүүд дэхь нөхөн төлбөр олголтын байдал, давхар даатгалтай⁴ эсэх, давхар даатгалын хамрах хэмжээ, даатгуулагч өөрөө хүлээх хариуцлагын хувь, даатгалын хураамжийн хувь зэргээс гадна даатгалын гэрээний нөхцөлийг сайтар судлах тэр дундаа гэрээнд заасан нөхөн төлбөрт хамаарах болон үл хамаарах тохиолдлуудыг харьцуулан судлаж үзэх нь зүйтэй.

Монгол улсад мэргэжлийн хариуцлагын даатгалын үйлчилгээ үзүүлж буй компаниудын талаар товч мэдээлэл өгнө үү.

2012 оны 9 дүгээр сарын байдлаар Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй тусгай зөвшөөрөл бүхий 18⁵ даатгалын компани үйл ажиллагаа явуулж байгаагаас дор дурдсан компаниуд мэргэжлийн хариуцлагын даатгалын үйлчилгээ үзүүлдэг бөгөөд бүгд давхар даатгагчтай байна. "Моннис даатгал" ХХК-ийн хувьд зөвхөн Моннис группийн гишүүн компаниудын ажилчдыг мэргэжлийн хариуцлагын даатгалд хамруулдаг ажээ.

№	Даатгалын компанийн нэр	Даатгалын бүтээгдэхүүний нэр	Даатгалын дүнгийн доод хязгаар	Даатгалын хураамж	Даатгуулагчийн өөрөө хүлээх хариуцлагын хувь	Вэб хуудас, цахим хаяг, утасны дугаар
1	Тэнгэр даатгал	Бүх мэргэжлийн хариуцлагын даатгал	2,000,000 төгрөг	0.8-1.5 %	20%	www.tengerdaatgal.mn, info@tengerdaatgal.mn, insurance@prime.mn, 312234
2	Миг даатгал		Мэргэжлээс хамаарч талууд харилцан тохиролцоно			www.mig.mn, info@mig.mn, 331332
3	Номин даатгал		1,000,000 төгрөг	1.5%	20%	insurance.nomin.net, insurance@nomin.net, 330023
4	Ард даатгал		1,000,000 төгрөг	50,000 төгрөг	20%	www.arddaatgal.mn, daatgal@arddaatgal.mn, 368539
5	Монгол даатгал		1,500,000 төгрөг	0.5%-1.2%	10%	www.mongolmaatgal.mn, insurance@mongolmaatgal.mn, 313615
6	Улаанбаатар хотын даатгал		1,000,000 төгрөг	2%-3%	Мэргэжлээс хамаарч талууд харилцан тохиролцоно	www.ubci.mn, info@ubci.mn, 70119827
7	Мөнх даатгал		Мэргэжлээс хамаарч талууд харилцан тохиролцоно	1.8%	20%	www.munkhdaatgal.mn, info@munkhdaatgal.mn, 331332
9	Соёмбо даатгал		10 сая төгрөг байх тохиолдолд	0.8%-1%	20%	www.soyombodaatgal.mn, insurance@soyombodaatgal.mn, 77220707
10	Бодь даатгал		1,000,000 төгрөг байх тохиолдолд	2%-3%	20%	www.bodiinsurance.mn, bodi@bodiinsurance.mn, 70110280, 323444
11	Монре даатгал		500,000 төгрөг	3.5%	Мэргэжлээс хамаарч талууд харилцан тохиролцоно.	www.monre.mn, sanal_huselt@ubdaatgal.mn, 70009000
12	Практикал даатгал		Мэргэжлээс хамаарч талууд харилцан тохиролцоно.			insurance@practical.mn, 331525

¹ Нотариатын тухай хуулийн 24.1 дэхь заалт

² Жолоочийн даатгалын тухай хуулийн 5.1, 5.3 дахь заалтууд

³ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 30.2 дахь заалт

⁴ "Давхар даатгалын үйл ажиллагаа" гэдэгт даатгагч нь даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн буюу хэсэгчлэн дахин даатгахыг ойлгоно. Даатгалын тухай хуулийн 4.1.9 дэхь заалт

⁵ http://fcc.gov.mn/index.php?option=com_docman&task=cat_view&gid=252&Itemid=133

ТАНЫ АСУУЛТАД ХАРИУЛЪЯ

Хувийн тэтгэврийн сангийн тухай товч ойлголт өгнө үү.

Монгол улсын иргэдийн хувьд тэтгэврийн тухай ойлголт нь Нийгмийн даатгалын сангийн Тэтгэврийн даатгалын сангаас олгож буй даатгуулагчийг өндөр наслахад нь насан туршид нь, тахир дутуу болоход нь хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл) нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн хөрөнгө¹, түүнчлэн мэргэжил, албан тушаал, албаны онцлогоос хамаарсан нэмэгдэл гэсэн ойлголтоор ерөнхийдөө хязгаарлагддаг.

Дэлхийн олон оронд өндөр настны тэтгэвэр, түүнийг бүрдүүлэх тогтолцоонд төрөл бүрийн арга ашигладаг бөгөөд тэр дундаас хамгийн өргөн ашигладаг Дэлхийн Банкнаас гаргасан зөвлөмжид дурдсанаар тэтгэвэр нь:

- Төрийн нийгмийн халамж;
- Хувийн хэвшлийн (хувийн даатгал) буюу ажил олгогчийн тэтгэвэр;
- Хувь хүний хадгаламж гэсэн гурван гол эх үүсвэрээс бүрддэг ба эдгээрээс хамгийн гол үүргийг хувийн тэтгэвэр гүйцэтгэдэг байна².

Хувийн тэтгэврийн сангийн гол ач холбогдлыг тайлбарлаж өгнө үү.

Монгол улсад нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврээс гадна нэмэлт тэтгэвэр авах бололцоо олгох хувийн тэтгэврийн сангийн тогтолцоог нэвтрүүлснээр төрийн хувьд төсвийн зардал буурч улмаар нийгмийн даатгалын талаарх төрийн нуруун дээрх ачаа тодорхой хэмжээгээр хөнгөрөх, хөрөнгийн зах зээлийн хөгжилд түлхэц үзүүлэх, нийгэм зөв хөгжих, эдийн засгийн бодитой, тэгш, өгөөжтэй өсөлтийг хангахад хувь нэмэр оруулах, ажил олгогчийн хувьд ажилчдынхаа нийгмийн асуудлыг шийдэх чухал хэрэгсэл болох, шимтгэл, татвар ногдох орлогоос тус санд төвлөрүүлсэн хөрөнгө хасагдах, ажилтан, ажилчдын байгууллагадаа ажиллах, итгэх итгэл нэмэгдэх, урт хугацаанд тогтвор суурьшилтай ажиллах, ажилтны хувьд орлогын нэмэлт эх үүсвэртэй болох, амьдралын ирээдүйн баталгаа нэмэгдэх, ажил олгогчоос мөн шимтгэл төлөх тул мөнгөн дүн шууд нэмэгдэх, санд төлсөн мөнгө татвараас чөлөөлөгдөх³ зэрэг давуу талууд бий болно.

Хувийн тэтгэврийн сангийн гишүүн этгээдийн хувьд өөрийн тэтгэврийн санд хуримтлагдаж буй мөнгөн дүнгийн хэмжээ, эргэлт зэрэгт хяналт тавих, тэтгэврийн сангаараа дамжуулан хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцох, тэтгэвэрт гарсныхаа дараа уг хуримтлалаа бөөнөөр нь эсхүл хэсэгчлэн авах, өвлүүлэн үлдээх зэрэг өргөн сонголтууд бүрдэх юм.

Манай улсад хувийн тэтгэврийн сангийн хөгжил ямар түвшинд байгаа вэ?

Тэтгэврийн сан дахь мөнгөн хөрөнгийг хөрөнгө оруулалт хийх, эдийн засгийн эргэлтэд оруулах замаар өсгөн нэмэгдүүлснээр тэтгэврийн даатгуулагчийн хувьд амьдралын баталгаат эх үүсвэрийг жинхэнэ утгаар нь бодитоор бүрдүүлдэг хувийн тэтгэврийн сангийн тогтолцоо нь хөрөнгийн зах зээлийн бүрдэл хэсэг байдлаар олон улсад хэдийнэ хэрэгжиж, хөгжлийн өндөр түвшинд хүрсэн боловч манай улсад хувийн тэтгэврийн сангийн талаарх эрх зүйн зохицуулалт, албан ёсны хяналтын тогтолцоо одоогоор бүрдээгүй байна.

УИХ-ын гишүүн, МҮХАҮТ-ын дарга С.Дэмбэрэлийн дурдсанчлан, банк, санхүүгийн секторт өрсөлдөөн бий болгох, альтернатив санхүүгийн орчныг бий болгох, тухайлбал, хөрөнгө оруулалтын болон тэтгэврийн сангууд бий болгох, жижиг, дунд бизнесийн хувийн тэтгэврийн санг бий болгон улсын тэтгэврийн сантай өрсөлдүүлэх, нийгмийн даатгалын үйл ажиллагааг бас хувийн даатгалын системийг зах зээл рүү хандуулж, эдийн засгийн эргэлтэд оруулах, хүмүүст даатгалын сонголтыг бий болгох⁴ нь зайлшгүй хэрэгжүүлэх ёстой дараагийн алхам юм.

Монгол улсад анхны "Тэтгэврийн Ууган Сан"-г ("ТУС") Бодь групп болон Голомт банкны ажилтнууд өөрсдийн санаачлагаар 2010.7.2-нд үүсгэн байгуулжээ. Ажилтан нараа үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллах хүсэл сонирхлыг нэмэх, ажилтнууддаа ирээдүйн хуримтлал үүсгэх боломжийг бий болгох зорилгоор банкны хувь нийлүүлэгчийн зүгээс тус санг мөн дэмжиж ажилладаг юм байна. Сангийн гишүүн Голомт банкны ажилтан нар өөрсдийн сар бүрийн цалингаас 5 эсхүл түүнээс дээш хувийг хуримтлуулахад Голомт банк тухайн ажилтны татварын дараах цалингийн 5 хувийг ажилтны нэр дээр нэмж хуримтлуулдаг ажээ. Ажилчид зөвхөн тэтгэвэрт гарсныхаа дараа биш 2 жилээс дээш хугацаанд Голомт банкинд ажиллаж, уг санд хуримтлал хийсэн тохиолдолд ашиг тусыг нь хүртэх эрхтэй бөгөөд олон жил ажиллах тусам ашиг тусыг илүү ихээр хүртэх аж. Уг сангийн үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй бөгөөд Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл нь ажилтан нарын дундаас сонгогдсон байдаг ба хөрөнгө оруулалтын бодлого болон "ТУС" сангийн үйл ажиллагааг вэбсайт түүнчлэн бусад мэдээллийн хэрэгслээр дамжуулан нээлттэй тайлагнадаг ажээ⁵.

Үүнээс гадна, МҮХАҮТ-аас "Тогтвортой, Тэнцвэртэй, Оролцоотой хөгжлийн төлөөх түншлэл" уриатайгаар 2012.5.25-ны өдөр зохион байгуулсан "CEO Summit-2012" компанийн захирлуудын дээд хэмжээний чуулга уулзалтаар Монгол улсад тэтгэврийн сангийн тогтолцоог нэвтрүүлэх болон түүний ач холбогдол, үр дүнгийн талаар Монголын санхүүгийн зах зээлийн холбооны дэд ерөнхийлөгч Л.Бямбаагийн тавьсан илтгэл нь оролцогчдын анхаарлыг ихээхэн татсан⁶ бөгөөд хувийн тэтгэврийн сангийн тогтолцоог нэвтрүүлэхэд хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичигт МҮХАҮТ болон Монголын Санхүүгийн зах зээлийн холбоо, "Юү Эм Си Капитал" ХХК-ийн төлөөлөгчид гарын үсэг зурснаар МҮХАҮТ-ын гишүүн компаниудын дундын тэтгэврийн санг байгуулах чиглэлээр талууд хамтран ажиллах⁷ эхлэл тавигдсан байна.

Хувийн тэтгэврийн сангийн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх явцад гарах ахиц, дэвшилтийн талаарх цаг үеийн мэдээллийг бид та бүхэнд үргэлжлүүлэн хүргэх болно.

¹ <http://www.ndaatgal.mn/62>

² <http://www.mongolchamber.mn/index.php/home-page/home/2012-08-27-08-29-56/1104-2012-05-10-160756>

³ <http://www.mongolchamber.mn/index.php/home-page/home/2012-08-27-08-29-56/1104-2012-05-10-160756>

⁴ <http://www.mongolchamber.mn/index.php/home-page/home/2012-08-27-08-24-12/1369-2012-08-31-182908>

⁵ <https://m.egolomt.mn/Intro/Intro3.aspx>

⁶ <http://www.mongolchamber.mn/index.php/home-page/home/2012-08-27-08-24-12/1177-2012-05-25-190152>

⁷ <http://economy.news.mn/content/109023.shtml>

Та сонирхсон асуултаа бидэнд
legas@mongol.net хаягаар илгээгээрэй.

**Монгол улсын хууль цаазын түүхэн дэхь нэн чухал баримт бичиг болох
"Халх журам" хуулийн тухай**

1709-1795 оны хооронд Халхын хаад, ноёд болон төр, шашны томоохон зүтгэлтнүүд өөр өөр газар 20 гаруй удаа хуран чуулж, хэлэлцэн тогтоосон "Халх журам" хууль нь "Гурван хошууны цааз ба дараа дараагийн жилүүдэд түүнд оруулсан нэмэлтүүдийг халх даяар дагаж мөрдөх буюу дагаж журамласугай" хэмээн тогтоосноор буй болж, нийт халх Монголын хууль буюу "Халх журам" хэмээн алдаршжээ¹.

Манжийн ноёрхлын үед дээд хэмжээндээ хүрсэн шарын шашны сүм хийд, лам нарын эрх мэдэл, онцгой эрх "Халх журам" хуульд

¹ С.Жалан-Аажав, 1995 он, Халх журам, УБ хот, Хэвлэлийн үйлдвэрлэлийн Үнэт цаас компани, 7 дахь тал

маш хүчтэй тодорсон² байдаг. Тухайн үед харь улсын дарангуйлалд байсан Монголчууд зан заншил, нүүдэлчдийн соёлын хэв шинжээ алдахгүйн төлөө тэмцэж ирсний баталгаа нь "Халх журам" хуулийг боловсруулж, 100 шахам жил дагаж мөрдсөн явдал юм.

18 дугаар зууны эхэн үеийн Монголын нийгмийн тогтолцоо, Монголын нүүдлийн феодализмын бүх үндсэн шинж чанарыг өөртөө тусгасан Халх журам хуулийн жинхэнэ эх хувь нь бүрэн хадгалагдаж үлдээгүй бөгөөд өнөөдөр бидэнд мэдэгдээд байгаа "Гурван хошууны их цааз"-ын үндсэн гурван янзын эх бичиг олдлоод байгаагийн хоёр нь Монголын

² Мөн хэвлэл, 5 дахь тал

Үндэсний номын санд, мөн "Яамны халх журмын дүрэм" хэмээх хувилбар нь МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Монголын төр, эрх зүйн түүхийн судалгааны төвд тус тус хадгалагдаж байна³.

Цэвээн Жамсранов, А.В.Рязановский, С.Д.Дыльков, М.Хагихара нарын олон эрдэмтэн Халх журмыг судалснаас С.Жалан-Аажав анх удаа Халх журмыг хэргийн төрлөөр нь ангилж бүгд 14 бүлэг 301 зүйлтэйгээр кирилл бичигт хөрвүүлснийг дор толилуулъя⁴.

³ Халх журам ХҮИХ зууны үеийн Монголын хууль цаазын эмхтгэл <http://bayarsaikhan.blogmn.net/23431>

⁴ С.Жалан-Аажав, 1995 он, Халх журам, УБ хот, Хэвлэлийн үйлдвэрлэлийн Үнэт цаас компани

ХАЛХ ЖУРАМ ХУУЛЬ

унах морийг авбал) хэдэн ч хүн болов эмээлт морийг нь аваад ноёдыг бол тавт, харц хүнийг тавь ташуурд. Тэр эмээлт морь (элчийн морийг авсан хүний унасан морь) нь хүнийх бол шахаагаар үнэнийг олоод мөн адилхан морь ав.

V зүйл. Ер (аливаа) элч айсуйг сонсоод мал буруулбаас тэр малын эзэн хүн бүрээс нэг нэг шүдлэн морь авах. Энэ авагч нь морьдыг аль ноёны элчээс буруулсан байна түүний санд авах (өгөх). Түшмэд элчийн идшийн эзнийг айлтгах (түшмэд элчийн идшийг түүний ноёны хэлсэн ёсоор өгөх). Дархан улаат (улаа барих албагүй дархан чөлөөт хүн) нь хүний малыг биендээ багтааж хүргүүлбэл тэр дарханаас хязгаалан морь авах. Малаа дарханд багтаагч (өөрийнхөө малыг дарханд өгөх аргаар малаа бууруулсан буюу нуусан хүн) тэр хүнийг малаа буруулсан лугаа адил торгож бай.

VI зүйл. Хэн хүн гэгээний элч гэж хуурч улаа шүүс унаж, идэж яваад зарлиг гэж худал үг хэлбэл биеэр өөд болоход улаа шүүс тасалсан лугаа адил.

VII зүйл. Жүнгэн (хааны их хатан) болоод хаан биеэр хаа өөд болох бол (явбал) улаа шүүс хэмжээгүй. Элч явах бол найман улаа, хоёр шүүстэй. Биеэр өөд болж явтал (ноёд бус хүмүүс) хэн хүн улаа шүүс тасалбаас хамаг малыг хагаслах. Ноёд болбоос зуун тавин анзуугаар (төлөөс буюу торгууль) торгох, хагасыг адуу, хагасыг үхэр, насны хэмжээ цөм хязгаалан. Таслаад мэлзвээс ноёдын тул хошууны дотроос ноёдыг, харцын тул сайдыг сонгож шахъя. Жүнгэний элч ба хааны элчийн улаа шүүс тасалбаас хоёр ест.

VIII зүйл. Ван, бэйл биеэр өөд болох ахул арван улаа, гурван шүүстэй¹. Энэ улаа шүүсийг ноёд харц хэн хүн тасалбаас гурван ест. Элч нь дөрвөн улаа, хоёр шүүстэй. Энэ элчийн улаа шүүсийг тасалбаас ес тавт. Засаг (хошууны засаг ноён) биеэр өөд болох ахул зургаан улаа, хоёр шүүстэй. Энэ улаа шүүсийг ноёд харц хэн хүн тасалбаас гурван ест. Элч нь хоёр улаа, нэг шүүстэй. Энэ улаа шүүсийг тасалбаас нэг ест.

IX зүйл. Гэгээний сүргээс улаа үл унах. Элч мэдэж байж унах бол гурван ест. Ноёдын өөрийн сүрэг нь гэгээний элч, гурван үйлээс (дайсныг дарах) бишид улаа шүүс өгөхгүй. Албатынхаа малыг сүрэгтээ багтааж эс өгөх бол Дархан хүний малыг биедээ багтаасан

¹ "Ван" гэдэг нь хошой чин ван, Чин ван, Жүн ван гэсэн гурван зэрэглэлтэй байсан. "Бэйл" гэдэг нь хааны угсааны хэргэмийн гуравдугаар зэрэг буюу бас хошууны угсаатай засгийн хэргэм бүхий манжийн ноёд.

торгууль лугаа адил.

X зүйл. Яаралт элч улаачаа эс эрвээс өөр хүнд захиж яв. Яаралгүй элч эзэнд нь хэлж уна. Эзэн нь үгүй бол сүрэг нэгт айлд нь хэлж уна. Айлын хүн эс зөвшөөрвөөс өөрийнхөө морийг өг. Хэрэв морь өгөхгүй бол хонь ав. Яаралгүй элч улаачаа эс хүлээвээс хонь ав. Яаралгүй элч хязгаалангаас доош уна. Имаг (ямагт) бүдхүүн морь болох аваас эзэн нь гараараа өг. Дээш унах ахул шүдлэн хонь ав. Улаач эзэнд нь эс хэлбэл шүдлэн хонь ав. Улаач улаагаа хулгай хийвээс хулгай хийсэн улхааныг (улааны морьдыг) цөм аваад (хурааж аваад) шүдлэн морь ав. Элчгүй улаач бусадтай хуйвалдаж өөр газар нутагт шилжүүлээд баригдвал хүн бүрээс шүдлэн морь ав. Эзэнгүй адуунаас хулгай хийж барьсан улааг (морьдыг) яаралгүй элч бүү уна. Хэрэв унаваас талчилсан (хуйвалдсан) лугаа адил. Гаднаас ирсэн ноёдын элчид өөрийн хошууны улаач нь ноёд, дархадаас бүү барьж өг. Барьж өгвөөс шүдлэн морь ав. Энэ гурван хошууны элч мэдэж барьж унаваас шүдлэн үхэр ав. Элч хажуу айлчлах мэт явах бол улааг нь буцааж өгөх. Эс өгвөөс сонгодог хонь авах. Элч гэртээ нартай байтал хоних ахул маргаааш нь өөрийн мориор явж бай.

XI зүйл. Элч хүн датсан малаасаа (өртөөний албанд зориулж авсан мал) хулгай хийвээс их хэвээр болох (1640 оны Монгол-Ойрадын хуулиар шийтгэх). Нэг хүнтэй элч зохицож авах юмаа эс аваад биш хүнээс авбаас тэр хоёрын анзуугийн хагасаар хувааж торгож бай.

XII зүйл. Бас хэн хүн датсан (татсан) малаас золих (солих) ахул их хэвээр. Хэн хүн датаринд өгснөө аваад (албан татварт нэгэнт өгсөн малаа буцааж аваад) мууг тавибаас гурван ест. Тийнхүү сольсныг харсан гэрч алданхины (гурван ест) хагасыг идэж (авч) бай.

XIII зүйл. Элч боос (хээлтэй) гүү, нялх унагатай гүү бүү уна. Унаваас шүдлэн хонь авах. Яаралгүй элч учиргүй шогоор илүү унаа унаж явах ахул хажуу явсан (явах ёстой замаасаа гарч өөр газраар дур мэдэн сэлгүүцэж явсан) элчийн торгууль лугаа адил. Бас элч хүн замдаа хүнийг шогоор (ямар ч шалтгаангүйгээр) зодох ахул хөлт.

XIV зүйл. Ер улаат ноёдын элчийн улаа шүүс тасалбаас нэг ест. Эн хайрлаж улаат болсон (ноёноосоо шан хүртэж улаа ухан эрхтэй болсон) харц хүний улаа шүүс тасалбаас тавт.

XV зүйл. Ер ноёдын чилээ мэдэх (өвчтэй ноёныг эмчлэхээр явж буй) элч улаат ноён

I БҮЛЭГ. ӨРТӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬ

I зүйл. Хутагтын гэгээн (нэгдүгээр Жавзандамба Занабазар) хаашаа ч явсан эртний долоон хошуунд хэлэлцсэн ёсоор улаа шүүс хэмжээгүй. Улаа шүүс тасалбаас хамаг юмыг нь талж (хурааж) санд (Жавзандамбын сан хөмрөгт) барь.

II зүйл. Ноёд биеэр тасалбаас өөрийнх нь сүргээс гурван зуун мал ав. Хэрэв үгээдэй (мал хөрөнгөөр ядмагхан) ноён байгаад мал нь зуу эс хүрвэл албатаас нь зуун мал гүйцээж барья. Зуун малын хэмжээ нь тавин адуу, тавин үхрээс бүрдэнэ, нас нь цөм хязгаалан. Тайж зэрэг хэргэмгүй, албатгүй болсон тайж, тавнан (тайжийн хүргэн) биеэр тасалбаас өөрийнх нь өмчилж байсан малаас гаргуулж авах. Хэрэв мал нь тавь хүрэхгүй бол хүүхдүүдээс нь тавин мал гүйцээж барья. Энэ малын хэмжээ хорин таван адуу, хорин таван үхэр, нас нь цөм хязгаалан. Улаа шүүс таслаад мэлзвээс (улаа шүүс өгч чадахгүй гэх буюу өгөх бололцоогүй хэмээн маргаваас) хошууны дотроос нь ноёдын тул ноёдыг харцын тул сайдыг сонгож шахъя (шахаанд оруулах буюу хөсрийн олд дээсэн дээр тохсон эмэгтэй хүний өмд, оймс, гутал, хөсрийн яс, олд, дээс, нохойн баас мэтийн хамгийн бузар гэж үзэж байсан зүйлийн доогуур шургуулж гаргаж үнэн худлыг тогтоох, ял тулгах).

III зүйл. Элч (Богджавзандамба хутагтын гэгээний элч) хаашаа явбаас арван улаа, хоёр шүүстэй. Энэ шүүсийг гэгээний амьтан битгий ал, хоосон битгий хонуул хэмээснийг хүндэтгэн дага, зарлигийн ёсоор гэгээний элчийн шүүс гэж амьтан битгий ал, хоосон бүү хонуул (хутагтын гэгээний элчид зориулж мал алж байна гэхгүйгээр хоол хийж өг), улаа шүүс тасалбал гурван ест (гурван есөн малаар торгож шийтгэ). Сангийн юм авч явагч элч мөн сангийн юмыг гэрээр ачиж унах, тэр юмнаас гадна илүү ачиж унаваас гурван есөөр торгоё. Энэ есийн дөрвийг бод, тавыг хонь, бод малын нас нь хязгаалан. Бас сураг тавигч элч (захиа, зарлиг уламжилж явах элч буюу шуудан хүргэгч) хоёр улаа унах, хоногт эзнийг нь мэдэж бэлэн идэш өгүүтэй. Шүүс эс өгвөл хөлт (морийг нь ав), хөлийн хэмжээ шүдлэн. Улаа шүүс тасалбаас тавт, энэ тавтын хэмжээ хоёр нь шүдлэн морь, үхэр, гурав нь шүдлэн хонь. Энэ (хоёр) зүйл элчийн улаа шүүс таслаад мэлзвээс отгын даргыг шахъя (отгын даргад тулган хүлээлгэж хариуцуул, хэрэв маргалдвал шахаанд оруул).

IV зүйл. Бас элчээс адуу хөөвөл (элчийн



болох ахул хэвт улаагаар явах (тогтоогдсон тоо ёсоор улаа хэрэглэж явах). Тасалбаас ер лугаа адил. Улаагүй ноёдын элч тасалсан ноёд эзгэн унаж бай (улаат ноёдын улааг тасалсан лугаа адил).

XVI зүйл. Ер гурван үйлийн элчийн улааг нэг хоёр морь таславч улаа тасалснаар тооцно. Гурван үйлийн элчийн улааг ноёд тасалбаас тавин бод тавин хониор торгож бай. Төр барьсан сайд, тайж, тавнан, тархад тасалбаас гучин бод. Энгийн (зэрэг тушаалгүй) харц хүн тасалбаас харайх барайхы (байгаа бүх эд хөрөнгө) нь талъя. Халуун амь нь зон дагаан байна.

XVII зүйл. Ер элч хүн улаа таслав гээд түүний морь тэмээг аваачаас гэдрэг холбоотой (нэг дахин илүү төлж) өгч бай.

XVIII зүйл. Гаднаас (Халхын гурван хошуунаас гадна өөр газраас) элч ирэхэд мөрнөөс зайлж нууж малаа буруулбаас, эс зайлж суусан хүнээс улаа шүүс унаж идвээс, зайлагч хүнээс шүүс төлж өгье.

XIX зүйл. Улаа шүүс үл өгөх Дархад сүмчин (сүм, хийд сахих хүн) нь дээдийн (төрийн төлөөлөгч) хэрэг, гурван үйлийн элчээс бусад хэрэгт улаа шүүс өгөхгүй. Энэ дархан нэг хүнээ авч гар харах (нэг хүн гаргаж алба хашуулбаас түүнийг мөн улаа шүүснээс чөлөөлөх) буй.

XX зүйл. Элч архи уугаад хэрэг гаргаж явдлаа эс чадваас нэг шүдлэн морь авах, гэрчид шүдлэн үхэр өгөх. Хэн хүн элчид архи өгвөл түүнээс шүдлэн хонь ав. Үзсэн гэрч дарагдуулбал шүдлэн үхэр өвч үнэн гэрчид өгөх.

XXI зүйл. Гэгээний элчид ирт үзүүртээр гар хүрвээс таван ест (таван толгой мал) болоод тав илүү.

XXII зүйл. Хааны элчид ирт үзүүртээр гар хүрвээс дөрвөн ес болоод гурав илүү. Мод чулуугаар гар хүрвээс ес тав болоод гурав илүү. Ташуур нударгаар гар хүрвээс нэг ест болоод нэг илүү. Амаар дайрваас тав болоод нэг илүү. Хөтчид юугаар ч гар хүрсэн торгож бай.

XXIII зүйл. Ер элчид ирт үзүүртээр гар хүрвээс ест болоод гурав илүү. Чулуу модоор гар хүрвээс нэг ес болоод гурав илүү. Ташуур нударгаар гар хүрвээс тав болоод хоёр илүү. Амаар дайрваас тавт. Хөтчид юугаар ч гар хүрсэн банзуу болоод хонь илүү.

II БҮЛЭГ. ХУЛГАЙН ЦААЗ

XXIV зүйл. Гэгээний сан, цагаан сүргээс (гэгээний (Жавзандамбын) сан ба сумын хөрөнгө түүнчлэн лам хуврагуудын мал хөрөнгө) хулгай хийвээс хамаг юмыг талъя. Халуун амь нь зон дагаан байх. Биеийг нь ная ташуурдаад, гурван мянга мөргүүлж (сүмд мөргүүлэх), гурван зуу эргүүлж (гороо эргүүлэх). Хүний гэрт явсан бие (ганц) хүн хулгай хийвээс өмчтэй бол өмчийг нь талаад, биш засаг нь мөн ёсоор. Өмчгүй бол ямар юм хулгай хийвэл түүний орыг нь ноён өгөөд түшмэд элчийн идэш өг. Засаг нь мөн ёсоор. Энэ бие хүн өмчтэй өмчгүй болов ноёноороо нэг тоотой (ноёнтойгоо нэг гэрт хамт амьдарч байгаа) болох ахул ноёныг нь хоёр шүдлэн хониор баалъя. Тусгаар гэртэй өөр хотод болох (ноёнтойгоо хамт бус тусдаа гэртэй) ахул хотын ахыг нэг шүдлэн хониор баалъя. Хулгайчид нэг жил гүйцтэл хишиг бариульа (үнэ хөлсгүйгээр зарцлаа). Хүнсийг ноён нь дааж бай. Тайж тавнан хулгай хийвээс мөн хувьт (хувийн) малыг нь талаад засаг нь золиогүй мөн ёсоор.

XXV зүйл. Саалийн үнээ улааны тэмээ хулгай хийвээс сүрэг лугаа адил (цагаан сүргээс хулгай хийсэнтэй адил ял шийтгэнэ). Эзэнд нь орыг нь өгөх.

XXVI зүйл. Хулгайч хүрээнд нь морио оруулбаас (морио эрэн сурвалжилж яваа хүнээс зайлуулж хүрээ хийдэд оруулах) жасаат ялаас гадна гурван есөөр торгох. Энэ торгуулийг жасын санд өгөх. Үүнийг харагч гэрчид ес бүгдээс нэг нэг сайныг сонгож идэх.

XXVII зүйл. Сангийн чулуун нүүрс, шохой хулгай хийвээс гурван ест. Өвс (сангийн өвс) мэдэж байж идүүлбээс гурван ест. Эс мэдэж идүүлбээс хөлт.

XXVIII зүйл. Тарианд орсон малаас арван сонгодог, таваас адгийн арваас доош, таваас дээш хэд ч байсан дунджийг автугай. Таваас доош хэд ч байсан төдийн хонь автугай. Бие (малгүй ганц бие) хүнээс хэт хутга, алчуур, цурвуулын аль нэгийг автугай.

XXIX зүйл. Тарианаас хулгай хийвэл ял нь шохой, нүүрстэй адил. Тарианы газраас гадагш хоёр хар цагааны (малын өнгө зүсийг ялгаж таних багцааны зайтай) газар хорих.

XXX зүйл. Сүм бурхны харьяат чимэг, малыг хэн хүн хулгай хийвээс гэгээний сангийн сүргээс хулгай хийсэн лугаа адил. Мэлзсэнийг шах. Хошуун дотор сайдыг сонгож шахаж бай.

XXXI зүйл. Авай ээж (хааны хатан), хаан, бэйлийн сан сүргээс хулгай хийсэн хулгайч гэгээний сан сүргээс хулгай хийсэн лугаа адил.

XXXII зүйл. Ганц хүн мал хулгай хийвэл хорин бод. Арав нь хязаалан арав нь шүдлэн байна. Ер нь хулгайчийг тармагц (тогтоомогц) шүүсэн ноёд сайдын өмнө ная ташуурдаад хүрээг зуу эргүүлж мянга мөргүүлжэ.

XXXIII зүйл. Хоёр дахиж хулгай хийсэн хүнийг хоёр зуу эргүүлж хоёр мянга мөргүүлжэ. Гурван үе хулгай хийвээс мянга эргүүлж түм мөргүүлжэ. Мөн ёсоор гурван сар дуусгасугай. Энэ засагт хоёлог золиогүй (ташуурдах, эргүүлэх, мөргүүлэх гүйж хэтрүүлэх, малаар сольж үл болно).

XXXIV зүйл. Бас шахаагаар торсон (хэргээ хүлээсэн) хулгайчийг ная ташуурдах. Хулгайч хорогдвоос (биеэ хайрлаваас) ная ташуурыг гурван бодоор золиод, зуу эргүүлж мянга мөргүүл. Арав хоногт дуусгаж бай.

XXXV зүйл. Илт хулгай хийж баригдсан хүнийг хэдэн хулгайч байсан бүгдийг нь ная ташуурдаж, хоёр гарыг нь хавсарч төмрөөр бугуйвчлан хадаад, нэг жил болох ахул малын эзэн ноёнд тушааж тавья. Хоёр дахиж хулгай хийсэн хүнийг хоёр жил болох ахул мөнхүү тэр ёсоор хадаж хадгалаад, мөн ёсоор тушааж тавья. Гурван үе хулгай хийвээс насан турш хадаж, буу тавья. Гарыг нь боож, зангид нь тушааж хадгалуульа. Зангийн тушааж хадгалуулсан хулгайчийг алдуулан тавих ахул харьяат засаг нь залуу тэмээ, мориор баалж автугай. Хулгайчийг алдуулан тавьсныг гадны хүн гэрчилбэл гэрчлэгч хүнд морийг нь өгье.

XXXVI зүйл. Шахаагаар торсон хулгайчийн гарыг нь боохгүй. Ная ташуурдаж бай. Хулгайчийн гэр, мал, тоого тулга зэрэг өлөг эд эс гүйцвээс дарга ноён нь гүйцээж өг. Эс гүйцээж өгвөөс цөм барьж (баривчилж) өг. Хүнээ барьж өгөх дургүй бол эрийн золио таван бод, эмийн золио гурван бод, хүүхэд бүрт нэжгээд бодоор золих. Энэ золио малын нас цөм шүдлэн. Шахаагаар торсон хулгайчийн ташуур нь гүйцэд (ная ташуурдах), ял нь (зуу эргүүлж, мянга мөргүүлж арав хоногт

дуусгахын) хагас бай.

XXXVII зүйл. Хулгайч малын эзнийг алах ахул хүн алсны анзуу өгөөд, үлдсэн малыг нь засаг (ноён нь) анаад, биеийг нь хошууны дотор боол болгон барьж өгтүгэй. Мал нь ан зуу эс гүйцвэл халуун амийг нь цөм барьж өгтүгэй. Хүн үхэлгүй бие морь шархадваас гурван ест. Алдсан суманд сум тоолон нэг ест. Хулгайч хүн малын эзнийг чулуу модоор цохиж, хөнгөн шархдуулсан бол гурван ест.

XXXVIII зүйл. Ганц хулгайчийн ял хорин бодоос хараад бодоод (гаргаад) тав. Түшмэд, элч нэг хошууных бөгөөс түшмэд нэг хязаалан морь, элч шүдлэн морь идэх. Хэдэн хошуу бөгөөс хошуу тоолон энэ ёсоор идэх. Гэрч нэг шүдлэн бод идэх. Ялаас гадна гал нэг сонгодог бод (хулгайчийн хэргийг шийтгэхэд хэрэглэсэн хоол унданд гарсан зардал) идэх.

XXXIX зүйл. Дүү хулгайч хэдүй ч болов ес бүрээс гаргаад (бодоод) нэг нэг бод авах. Үлсэн (үлдсэн) найм бүрээс нэг нэг бод аваад түшмэд элтэй хувааж идэх.

XL зүйл. Ер хулгайч хэдэн хошуу бөгөөс хулгайчийн тоогоор ялаа хувааж өгөх. Малын эзэн хэдэн хошуу бөгөөс малын эзний тоогоор ялаа хувааж идэх. Малын эзэн хэдий олон болов, гурван галыг хувааж авах. Гурваас дээш илүү гал гэж байхгүй.

XLI зүйл. Ер торж дуусгасан (ял торгууль нэгэнт ногдуулсан) хулгайчийн дотроос нэг нь би ариун билээ гэх бол түүнийг сүх атгуулсугай (сүх бариулж шахаанд оруулан тангараг хэлүүлэх).

XLII зүйл. Ер цааз дотор хэмжээ эс гарсан (торгож шийтгэсэн малын тоо, нас, хэд нь бод, хэд нь бог мал байх) ял анзуу нь нэг ес бол дөрөв нь бод, тав нь хонь, нас нь цөм шүдлэн, олон ес бол заримын нь тав бод (дөрөв нь хонь, таван мал бол хоёр бод, гурван хонь, гурав бол нэг нь бод хоёр нь хонь) байна.

XLIII зүйл. Ер анзуу ялд тийм мал гэсэн нь үгүй гэж үнэнийг олох аваас их сайн тэмээнд хоёр шүдлэн морь, дундаж тэмээнд хоёр хязаалан, тайлаг (гурван настай тэмээ) тэмээнд хоёр шүдлэн морь, тором (хоёр настай) тэмээнд нэг хязаалан морь, ботго, даага бол соёолон таван хонь, хязаалан дөрвөн хонь, унага бол нэг хонь байна.

XLIV зүйл. Хулгайчийн малын хүлэг (хүлэг дээс) чөдөр, ногт, шижим мах хийсэн уут, юманд хадсан оосор бүч эдгээрийг авсныг хулгайч нэхвэл торгуульгүй (торгохгүй).

XLV зүйл. Хулгайчийн авч явах малыг алдагдуулсан (хулгайлсан малыг илрүүлэн олж өгсөн) хүн арваас дээш бол арав бүрээс нэг сонгодогийг ид, арваас доош тав хүртэл бол дунджийг ид, таваас доош бол адгийг ид, хоёр тэмээ бол сайн морь ид, нэг тэмээ бол шүдлэн морь ид, хоёр морь бол шүдлэн үхэр ид, нэг морь бол сайн хонь ид, хоёр үхэр бол нэг хонь ид, хоёр хонь бол хоёр хөл ид, нэг хонь бол нэг хөл ид.

XLVI зүйл. Хулгайчийн мөр (хэрэг) шахсан (шахаанд орсон) сайд ариун шахаанд ороод (хулгайн хэрэгт сэжиглэгдсэн, баригдсан, хүнийг хулгай хийгээгүй гэж нотлохоор шахаанд орох) хойно ариун гэгч хулгайч нь бузар болж тодорвоос мөн тэр ах (шахаанд орсон сайдын ахлагч) сайдыг шах. Тэр (ахлагч) сайд зохицсонгүй (хулгайчтай холбоо сүлбээгүй) эс мэдсэнийг үнэн гэж шахаанд орох ахул (шахаанд буруу орсон тул) урьд орогч сайд гартугай (шийтгэх). Хойд (ахлагч) сайд шахаанаас буцваас (хулгайн хэрэгт тэр

сайд батлахын тулд шахаанд орохгүй) урьд орогч сайдыг дөрвөн морь, таван шүдлэн үхрээр торгож тэр малыг засаг нь ав. Сайд ариун хүнийг бузар гэж торгоод, хойно тэр хулгайч ариундаа гарч тодорвоос мөн нөхөр ах сайдыг нь шахах. Торгууль мөнхүү урьд ёсоор шахаанд барьсан (шахаанд оруулахаар тогтсон) сайдын өмнө (оронд) албатын тул (ноёныг) би орно, энэ ариун билээ гэгчийг шахаад баригдсан (сайд) эс орох ахул торгуульгүй. Сайд хан хүнийг албатын тул өмнө барихгүй (шахаанд орсон сайд, албатын хэргийг гэрчлэхийн төлөө хан хүнийг гэрч баримт болгож болохгүй) бай.

XLVII зүйл. Нэгжүүл нэгжигч хүнийг урьд гэрчид тушааж биеийг нь арилгаж оруул (ямар нэг юмыг нууж авч ирж, нэгжүүлж байгаа хүнийг гүтгэх буюу нэгжих илрүүлсэн юмаа өөрийн болгож ашиглаж завших явдлаас сээрэмжлэх).

XLVIII зүйл. Нэгжүүл ямар нэгэн ам буюу мах мэтийг авч иржээ (нэгжээд ямар нэгэн юм олжээ). Ариун хүнийг ямар юмаар гүжирлэвээс түүгээр торгож бай.

XLIX зүйл. Ер ноёдын гэр нэгжээд юм эс гарах ахул хадаг, цагаан морь ноёнд барь (ноёныг хилсдүүлсний төлөө буруугаа хүлээ).

L зүйл. Ер ноёд хээл (хахууль) өгсөн байвал ял хэлэлцэхгүй.

LI зүйл. Хүмүүсийн эдэлж хэрэглэдэг юм хулгайлсан тохиолдолд ногдуулах ял торгууль: - илдсэн хуяг олбог, буу, товь (дуулган дотор давхарлаж өмсдөг малгай), дуулга, хуягийн мөрөвч, арьсан хуяг хулгайлсан байвал долоон ест;

- саадаг сум, сэлэм, жад, мадага (тал иртэй буюу хоёр иртэй хутга), дарь хулгайлсан бол гурван ест;

- хутга, хуурай, таваас доош сум, арав харвахаас доош дарь, сум нэг ест;

- хуяг болон ямар нэгэн зэр зэмсгийн зүйл хулгайлсан байвал бүгдийн орыг өгч бай;

- ном бурхангүй хүрд, алт мөнгө, булга, шилүүс, торго, тогоо, тулга, араатан дах, араатан дотортой хувцас, эрдэнийн эрхи, заслын (хүзүүнд зүүдэг) эрхи, халиу, хар үнэгэн малгай, халтар үнэгэн малгай, булган малгай зэргийг хулгайлсан бол гурван ест;

- адгуус ханаж идсэн, морины сүүл огтолсон, адгуус имэлсэн (им тэмдэг тавьсан), тас бүргэд, эм хүний залга тасалсан, хазаар, эмээл, чөдөр, сүх, хүзүүвч, сүйх, сэрээ, царил, хүрз, алх, өрөлбө, дөш, хөрөө, бүс, тарваган дах, дээл, хүрэм, бөс дээл, цув, хөнжил, нэхий дээл, илгэн дээл, ууж, булигаар, хивс, авдар, хонины унгас, зэс, гууль, төмөр, төмөр хувин, төмөрлөсөн домбо, хувин, торгон цамц, торгон дэвсгэр, цэмбэн дээл, араатны арьс зэргийг хулгайлсан бол нэг ест;

- дээвэр, туурга, өрх, үүд, майхан, тооно зэргийг хулгайлсан бол хоёр ест;

- хөрөнгөтэй айраг, савтай архи, хэв хадаг, гүцтэй шар тос, цай, тамхи, ёл, тас, бүргэд, мах, нумны хөвч, тохом, нэмнээ, үйлийн хайч, хингар, харуул, бүс, хормогч, бус хүрэм, бүс цамц зэргийг хулгайлсан бол тавт;

- ер ноёдын гишүүнчний (зарц) хураасан аргал, түлээ, тарваганы арьс, хүний мал саах, нэхий, хурганы арьс, илэг, цулбуур, хөнөг, ногт, ташуур, тулам, шанага, аяга, самбар, дэгээ, шөвөг, зүү, товч, эрхийвч (сум харвахад хуруундаа хийдэг зэс бөгж), дээс,

ширэн түлхүүр, тэмээний унгас, тэвш, хувин, бэхний бумба, гарих, галын хайч, хутга үл хүрэх төмөр, чимхүүр, ховоо, онгоц, төмөргүй модон хувин, домбо, завьяа, аяганы ширээ, аяганы гэр, аяганы алчуур, гутал, өмд, оймс, тариа, тайга (анч нохой), өвс, нүүрс зэргийг хулгайлвал мориор торгоно;

- бичиг бичих цаас, араг, савар, хүрээний хуврагийн аргал, түлээ, энгийн хүний гадна хураасан аргал түлээ, уурга, багана, унь, хана, саваа, хацавч (хавтгай мод), хөлсний алчуур, хужир, давс, цан, хуурай идээ, цагаан идээ, сам шүүр, таваас доош хадаг, нэгээс доош бүс, баглаа, утас, цув, балуу (билүү), нохой, сэрээний иш, жадны иш, зүүний хавал (зүү хадгалдаг сав) зэргийг хулгайлбал хониор торгох. Ер бүгдийн орыг авч бай.

LII зүйл. Хулгайчийг үзэх ахул аль ойрхи дөрвөн зүгтээ бараатай улс (айлд) зарла. Эс зарлавал хөлт. Зарыг таслаад хулгайч юм авах бол тавт. Дээрэмчийг үзээд эс зарлаваас нэг ест, зар таслаад дээрэмчин мал булаах ба хүн алваас зар таслагч хүн гурван ест. Хэн хүн хулгай, дээрэмд цохилт сайн хийвээс эзэн ноён нь шагнаж хайрла.

LIII зүйл. Гарт орсон хулгайчийг бүү ал. Алваас алагдагчийн ялыг үрэх (хэрэгсэхгүй болгох).

LIV зүйл. Бас хэн хүн дээрэм, хулгайчийн авч явах юмыг эс нэвээс тавт. Хэн хүн сайн морио орхиод хөтөлгөөгүй нэхвээс хөлт. Ноён хүнд сонгосон атлаа хүн эс илгэвээс ест. Мүү (чадал муутай) хүнийг нэг муу уналгатай хөтөлгөөгүй (хөтөлгөө морьгүй) илгэвээс тавт.

LV зүйл. Бас ер хэн хүн мөр малгайн төдий ороод эс харваас (Хэргийн үл мөр тодорхой бүс бөгөөд үзэж харсан хүн байхгүй бол) даргыг шахах.

LVI зүйл. Ноёд, тайж, тавнан эрхтэн эс нэгжүүлвээс үгүй болсон юмны анзууг өг. Гэрч ац (нэгжих хэрэггүйгээ гэрчлэх хүнийг гаргаж авч ир гэж шаардах) гэтэл хүнтэй болоод эс өгвөл хөлт.

LVII зүйл. Энгийн хүнийг гэрч болж яв гэтэл эс болох ахул хөлт.

LVIII зүйл. Ер мөр мөшгөгч ба нэгжүүл нэгжих хүнд нөхөр (дагаж явах хүн) эс өгвөөс морь ав. Энгийн хүнийг яв гэтэл эс ажирваас (үл ойшоовоос) хөл (унаж яваа морь) ав.

LIX зүйл. Нэгжүүл эс өгвөөс торгох. Хэдэн хүн хөших ахул (татгалзвал) төдий хөл ав.

LX зүйл. Бас улаан мах (улаанд хэрэглэх мах) миний чиний гэвэл (хэн гаргах тухай маргах) сүхт (сүх бариулж тогтоох). Хэн хүн юмаа автав (алдав) гэж нэгжээд, хөндлөн хүний автсан юмыг харваас нэгжигч хүн хулгайчаас авсан юмаа юу ч болов төлж аваад гэрчийн идэш өгтүгэй (гэрч болсон хүнд тогтоосон ёсоор зохих шагнал урамшлыг өгч бай).

LXI зүйл. Хэн хүн нэгжээч хүнтэй хамт явж нэгжээд, хулгайчийг (хулгайд алдсан юмаа) олвоос мөн шөнө, өдөрт автсан (алдсан) юмаа хулгайчаас төлж ав.

LXII зүйл. Уургач (хулгайч), уутач (хулгайч, дээрэмчний авсан юмыг нууж хадгалсан хүн) хоёрын уутач нь мөн ёсоор (хулгайчтай адил зүйрлэж шийтгэх).

LXIII зүйл. Хулгайчийг ноёд (засаг бүс сул ноён) дарваас гурван ест. Тайж, тавнан, сайд дарга нар дарваас тавт, энгийн хүн дарваас нэгэн ест. Засгийн ноёд (албан тушаалтай ноёд) биеэр дарваас таван ес авч, эс дарсан

засгууд хувааж автугай. Гэрчилсэн хүн хагасыг ав. Үлдсэнийг засагт ав.

LXIV зүйл. Баригдсан хулгайчийн тоног (биедээ хэрэглэж явах эд юм), хөлийг цөм ав.

LXV зүйл. Бас ер мөр ба аль ч шахааг (хулгайчийг илрүүлэхийн тулд энд удирдаж байгаа язгууртан болоод албан тушаалтныг хариуцлагад татаж, шахаагаар мөрдөн байцаах) ноёдын тул ноёдыг, тайж тавнангийн тул тайж, тавнанг шахъя. Тайж тавнангийн хөвгүүн тул тайж, тавнангийн авайгүй (эхнэр, авгай аваагүй) хөвгүүнийг шахъя. Шавь нарын (гэгээн буюу сүм хийдийн харьяат ард) тус их даргыг шахъя. Хуврагийн шавь нарын (лам хувраг нарын харьяат хүмүүс) тус барууны тул барууны даргыг (бага дарга) зүүний тул зүүний даргыг (бага дарга) шахъя.

LXVI зүйл. Гүйдэл (алдуул мал) хэдүй ч болов арав бүрээс сайныг идэх. Арваас доош дунджийг идэх, хоёроос доройг нь идэх, нэгээс бөгс идэх, эзэнтэй нь явж эвэлж алдуулаас (хулгайчийн гараас эвий нь олж байж салгаж авах) мөн энэ идшийн хагасыг идэх. Хулгайч олон цөөн гэх, хүүхэд бий үгүй (гэвээс) гэхийн тус (төлөө) есөн алданхид (хулгайд алдсан мал есөн толгой мал ба эд юм) даргыг (шигүүлэнгээс дээш дарга) шах. Тав алданхиас доош бол шигүүлэнг буюу шүүлэнгийг шахъя². Малын эзний мал олон цөөн гэхийн тус мөн малын эзний даргыг шахааж бай.

LXVII зүйл. Элч идшиндээ тоонон (тооцож бодох) хэмээн онолхон (оногдсоноо) авч гэдэргээ харьваас идсэн бай (торгуулиар өөртөө ногдох хувийн авахгүй байх).

LXVIII зүйл. Ер хулгайч мөрөө ариун хүнд оруулаад тэр хулгайч тусгаар гарваас (хэргээ хүлээвэл) хулгайч бүрийн хөл, мөрийг мөр орлогчид (хилсээр хэрэгт холбогдсон хүн) өг.

LXIX зүйл. Ер ноёд нь албат хөвгүүдээ (зарц хүүхэд), дарга нь отгоо (тэр даргын нутгийн харьяат ард), эцэг нь хөвгүүнээ хулгай хийснийг дуудаж харах ахул (албанд мөрдүүлэх буюу хэлж мэдэгдэх) ор галыг өгөх (хоолны материалыг хариуцаж гаргах), ял заагаггүй. Энэ дуудагч хүн ялын хагасыг идэх.

LXX зүйл. Бас ноёд харц хүнээр хулгай хийлгэвээс өөрөө хулгай хийсний ёсоор буй.

LXXI зүйл. Ер зарга шүүсэн сайдын санаа эс нийлвээс бурханы өмнө төлөг орхиж түүгээр болж бай.

LXXII зүйл. Ер зарга шүүсэн ноёд (сайд) гоёчилбоос (хэргийг шударга бусаар шийдвэрлэвэл) нэг тэмээ тэргүүлэн таван бодоор торгоё. Ноёд сайдыг гоёчлов гэж дайрч заалдаад заргыг урд сайдын ёсоор болговоос заалдагчийг нэг тэмээ тэргүүлэн есөн бодоор торгоё. Энэ мал нас цөм хязаалан. Хагас нь морь, хагас нь үхэр.

LXXIII зүйл. Засаг барьсан түшмэд согтуу сууж зарга буруу хагалваас (шийдвээс) соёолон мориор торгож засаг ноён нь ав.

LXXIV зүйл. Хэн хүн заргатай бол төдийд ир гэж ноёд хэл илгээ. Тэр болзоонд эс ирвэл тэр үл ирэгчид элч илгээж, мөрийг нь барьж биеийг нь авч ирүүл. Түүнд эс ирвэл буруутанг торгох, зөвтийг тав хоног хүлээ. Таван хоногт эс ирвэл үрэх (хэрэгсэхгүй болгох). Болзоот өдрөө гурав дахь хэлэлцээ болох ахул гурван сайд, хоёр хэлэлцээ болох ахул хоёр сайд цуглаж, газрын хол ойрыг хоногээр хэмжиж болзож бай. Болзооноос хожидвоос гурван **хонь ав. Заргат хүнийг тогтоомогч элч харах**
² Дөчийн доторхи зохион байгуулалт - "Хорины шүүлэнг" гэж хорин хүн буюу айлыг захирсан хүнийг хэлдэг байжээ.

(явуулах), тэр элч тогтоож өгсөн өдрөөс арав хоногийн дотор барьж өгөх. Төдий болтол эс барьж өгвөл идшээ байх (шан хөлсий нь хасах). Элчийн тэр идшийг малын эзэнд өг. Элчээс нэг шүдлэн бод авч ноён сандаа ав.

LXXV зүйл. Зарганд хүрч (зарга шүүх газар очих) төгсгөсөн хүний заргыг хагаслагч түшмэд (уг заргыг шүүсэн хүн), төгсгөгч элч (уг заргыг дуусгасан элч), хамтаар хүний биеийг (ялтан) эр, эм хүүхдийг (ялтны гэрийн хүмүүс) цаазын ёсоор золионы бодод бодож биеэр буй (ялтны байгаа бүх бод мал ба хонь, эд бүгдийн дотроос хагаслагч түшмэд, төгсгөгч элч нар тогтоогдсон ёсоор хувиа (олзоо) авах) бод ба хонь эд бүгдээс хоёроос сонгодогийг, арван таваас дээш дунджийг, долоогоос дээш адгийг, зургаагаас доош хөл идтүгэй. Бодоос бодыг, хониноос хонийг идтүгэй.

LXXVI зүйл. Ер хэн хүн ял болбоос бүү довтол (битгий өөрийн дураар одож, булааж авахтун). Элч авч (өөрийн ноёноосоо элч авах) ноёнд нь хүрч (хэрэг хийсэн хүний ноёнд мэдүүлэх) анзуугаа ав. Малын эзэн өөрийн ноёноос элч авалгүй санаагаар одож (санааны зоргоор хүлээж буй) ялаа авбаас тэр яланаас зөвтийн (малын эзэн) ноёнд харуул (гаргах), түшмэд, элчийн идэш өгөөд бус ялыг хулгайчийн ноёнд өгөх. Малын эзэн өөрийн ноёноосоо элчтэй одож нөгөө ноёныг элчгүй довтолч аваас тэр ялыг (яллан авах ёстой юм) цөм авч буруутны ноёнд өгөх.

LXXVII зүйл. Хүний эм охиныг хүн аваад (хулгайлан авч явах) дээр хоргодвоос халуун амь үл хагацах (эр, эм хоёрыг үл салгах) тул эмийн худалдаанд найман адуу, долоон үхэр, дөчин хонь өг. Малгүй бол эрийг хүн дээр нь барьж өг. Хүнээ өгөх дургүй бол ноён нь энэ малыг гүйцээж өг. Мал нас цөм шүдлэн.

III БҮЛЭГ. ГЭРЛЭЛТ, ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

LXXVIII зүйл. Ноёд, тавнангуудад авай (ноёд, тайж, язгууртны охин) дээр авай өгвөөс тэр өгөгч ноёныг арван тэмээ, зуун адуугаар баалъя. Энэ бааг засаг дор автугай.

LXXIX зүйл. Засаг барьсан ноёд биеэр хошууддаа авай дээр авай өгвөөс (авгайтай хүнд хоёр дахин авгай авч өгөх) засгийн ноёдыг (засаг захиргааны эрх барьж байгаа ноёд) арван таван тэмээ, зуун тавин адуугаар баалъя. Энэ бааг засгуудад өгье. Тавнанг таван есөөр торгож, торсон (торгож авсан) малыг урьд авайд өгч, авай язгууртан дагуулж ирсэн инжээ аван төрхөмдөө харих.

LXXX зүйл. Авай дээр биеэ мэдэж очвоос хойт авайг хагацуулъя. Тавнанг таван есөөр торгоё. Торгосон малыг засагт автугай. Засаг нь мэдэж байж дарваас гурван хошууны засгийн ноёд хурааж автугай.

LXXXI зүйл. Тавнанг авайг гээвээс (хаях) ташуураа барьж гарах (гэрээсээ мал авалгүй ганцаараа явах, тонилох). Авай инжээ авч хошуундаа биеэ мэдэж. Тавнангийн талсан эд малыг хувааж, хагасыг нь засагтаа авах, хагасыг авайд өгөх.

LXXXII зүйл. Авай дээр харц эм авбаас эмийг нь хагацуулъя. Харц эмийн эцгийг талъя. Тавнанг золиогүй (ташуурдах шийтгэлийг малаар сольж болохгүй) ная ташуурдъя. Эм авсан тул авай уурлаж, тавнангаас хагацваас хойт авсан харц эмийг хагацуулъя. Бус ял нь ёсоор болох. Авай инж болоод сүрэг мал, гэрээ аван хошуун дотроо биеэ мэдтүгэй.

LXXXIII зүйл. Ноёд ноёд зуураа (хоорондоо) сүйтээ авалцах ахул (нэг ноён нь нөгөө

ноёныхоо сүйт охиныг авах) гурван өрх хүн, гурван зуун анзуугаар торгоё. Гурван өрхийн нэгийг ямбагүй (албан тушаалгүй албат) хүн сонгож автугай. Хоёр өрхийг ноён нь мэдтүгэй. Авсан сүйтийг хагацуулъя.

LXXXIV зүйл. Ноёд гурван хошууд зуураа (дотроо) харц хүний сүйтийг авбаас нэг тэмээ өгөөд, хошуун дотроо сүйгүй охиныг сонгуулж өгтүгэй.

LXXXV зүйл. Ноёд ноёдын хатан дор орвоос (явалдах) ноёд зуураа сүй эвдсэн лугаа адил. Анзуу эс гүйцвээс биеийг нь авъя (өөрийг нь албат болгож авна).

LXXXVI зүйл. Ноёд харц хүний эмд орвоос зуун тавин анзуугаар эс бөгөөс малаар торго. Харц хүн хатан дор орвоос хамаг биеийг нь талаад халуун амийг нь цөм хатны ноёд албатын дотор хятадын хятадад (боол болгох) барьж өгье. Хатад, авай нар нэг адил.

LXXXVII зүйл. Харц хүн харц хүний эмд орвоос гучин бэрх (морь, тэмээ, хонь ямаа тус бүр гуч бүгд нийлээд зуун хорин бог, бод) тэргүүтэй гурван зуун анзуугаар торго. Эс гүйцвээс нэг бодод хорин таван ташуур, ташуурыг зуугаас давуулахгүй.

LXXXVIII зүйл. Хүний эм ба охиныг босуулсан (оргуулсан) хүнийг хүний эмд орсон лугаа адил. Хөнжлийн захаас татваас гурван ест, эм хүн эр хүний өвөрт орвоос гурван ест.

LXXXIX зүйл. Ноёд хүүхдээ хуримласан болоод өөр тавнанг дор өгвөөс таван бэрх (таван хошуу мал) тэргүүтэй тавин таван анзуугаар торгоё. Хуримгүй болбоос урьд авсан малыг хариулж өгтүгэй.

XC зүйл. Ноёд харц хүний хуримт эмийг бус хүнд өгөх болбол хуримт хүний ноёд нь сонгож өг. Сонсголгүй өгвөл язгуурын хуримт хүнд хариулж өгтүгэй. Хариулж эс өгвөөс зуун мал анзуу өг.

XCI зүйл. Хэн хүн сүйт охиныг сүйгүй ноёд худал хэлж авбаас хагацуулж язгуурын сүйт (анх сүйт тавьсан хүн) дор өгье. Худал хэлэгчийн эд малыг хагаслая.

XCII зүйл. Хаан хүний охин авайг харц хүн сүйлэх бөгөөс цагаан тэмээ мөнгөн буйлтай, цагаан морь булган молцогтой, мөнгөн аяга архиар дүүрсэн, нүхгүй сувд эрдэнэ эдгээрээр сүйлснийг сүй дор тооцно.

XCIII зүйл. Ноёд, тавнангуудын охиныг гуйваас мөнгөн аяга, сувд, архи хүргэвээс тооцно. Үгүй бол тооцохгүй.

XCIV зүйл. Харц хүн өөр зуураа сүйлэх бөгөөс архи болоод хонины гэдэс дотор, эвэр туурай гүйцэд болбоос тооцох, гэрч үгүй ба гэрч эс мэдвээс тооцохгүй.

XCV зүйл. Ер худад өгөх (хүнд) малын боосын хэмжээ тэмээ өвлийн сүүл сар, гүү зуны сүүл сар, үхэр намрын сүүл сар, хонь намрын дунд сар бол боосод тооцох.

XCVI зүйл. Ер худ болсон хүн малаа аваад охиноо өгөхгүй явсаар жил удаасан хойно охиныг эцэг одож хагацуулан нэг жил доторхийг (өсгөсөн малын анхны тоо) тоогоор нь өгөөд, хоёр жил болсон бол малын хагасыг холбоотой өг. Гурван жилээс цаашихыг цөм холбоотой (анх өгсөн малыг хоёр дахин нэмж) өг. Хүүгийн эцэг одож хагацуулбал мал зуу бол түүнийгээ авах, жилийн хэмжээ арван хоёр сар байна.

XCVII зүйл. Сүйлсэн хүү, охин авалцахын урьд хэнд өгсөн байваас өгсөн малаа хариулж автугай.

XCVIII зүйл. Мал өгөлгүй хүчин (хүчээр) хүргэн орж, эм аваад өөрөө урваж очвоос арван бод, гучин хонь өг. Явах дуртай байтал эрхгүй ноён нь нэхэж авах бол (буцааж ирүүлбэл) найман бод, хорин хонь өгөх. Хүүхдийг золиогүй (мал өгөлгүйгээр зүгээр аваад яв). Өөрөө урвасан хүний хүү нь эцгээ дагаад, охин болбоос хоёр бодоор золь.

XCIX зүйл. Үхсэн хүний эмийг ноён хүнд өгвөөс тэр эм хөвгүүн хэд байвч хойт эртэй малаа хүн бүр адил хувааж аваад, хүү нь албандаа гартугай (албат өрх болж салаад ноёндөө алба барих). Ноёноос зарлиггүй аваас ташуураа барьж гартугай.

C зүйл. Төрсөн нагацдаа ууган, отгон хоёр зээ нь ялгүй. Нагац эцэг үгүй бол мөн ууган, отгон хоёр хүүд нь ялгүй.

CI зүйл. Хонилж, архилж (хонь, архитай) ирээд өгсөн юм оргүй (төлөхгүй).

СII зүйл. Ер ноёд үрдээ өмч өгөхдөө хаанд айлтгаж ба засгийн ноёндөө тэмдэглүүлж тамгалуул. Тэмдэггүй болоод зарга булаацалдваас тод ялцтай гэрч ба тэмдэггүй болох аваас үрийн амнаас хэлэх үг ба ийм билээ гэх буюу хүн эс хүсэх бол тооцолгүй (баримт болгож тооцож үл болно). Үр дор ялгаагүй тул бүгдэд мэдэгдэх, зөвт хүү, бүгдэд мэдэгдэх буруут хүү хоёроос дээд хувааж өгөх, булаацалдаж байгаа хүүхдүүдийн эх нь мэдтүгэй.

СIII зүйл. Ер хаан хүн, харцад өөрөө хайрласан (охиноо өгсөн), харц, хаан хүнд өөрөө барьсан, энэ хоёр харилтгүй (хариуд нь мал авахгүй), гэгээгсэн эм (анхны хариуд), мэдэл боол (гэргийн ажил төрлийн талаар эрх мэдэлтэй гэрийн юмыг мэддэг бөгөөд боол гаралтай хүн) хоёрын авлаа гэх ялтай.

IV БҮЛЭГ. БОСУУЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

СIV зүйл. Дээр (Жавзандамбыг) зорьж ирсэн босуулыг хэн хүн үзвээс бүү саад хий, хүргэж ир. Ирсэн тэр босуул санд шингэх босуул (уг босуулыг гэгээний сүмд хүлээж авахгүй) болбоос идэшгүй (хүргэж ирсэн хүнд шан өгөхгүй). Шингэвэргүй (хүлээж авч болохгүй) босуул болбоос ноёд нь тушааж, ёст идшээ идтүгэй. Зорьсон босуулыг мэдсээр байж саад хийвээс нэг шүдлэн мориор баалж, их санд авах.

СV зүйл. Босуулыг барьсан хүн хөтөлгөөтэй босуулын хөтөлгөөг идэх. Хөтөлгөөгүй босуулын уналганд бөгс идэх (унаж яваа мориог алж бөгсий нь авах). Арав хүрсэн мал авч явах босуулыг бариваас арваас хоёрыг авах, арав эс хүрвээс нэгийг идэх, явган босуулаас хонь идэх.

СVI зүйл. Гадагш (хошуунаас гарч) очих босуулыг ноёд эс бариваас тэмээ тэргүүлэн найман хязгаалан морь ав. Хэрэгт оролцсон сайд (тухайн хошуу тамгын газар алба хааж буй хүн) эс бариваас нэг соёолон тэргүүтэй зургаан соёолон морь ав. Ямбат хүн (ерийн албан тушаалтан) эс бариваас нэг хязгаалан тэргүүтэй эрвэн шүдлэн морь ав. Албат хүн (албат ард) эс бариваас гурван шүдлэн морь ав.

СVII зүйл. Дотогш ирэх босуулыг эс бариваас ноёд бөгөөс долоон хязгаалан морь ав. Төрд оролдсон (оролцсон) сайд болбоос гурван шүдлэн ав. Ямбат хүн бол хоёр шүдлэн ав. Албат хүн бол нэг шүдлэн ав.

СVIII зүйл. Гаднын хошуунаас хуучин албат болоод ноёндөө зорьж ирэх хүн эм (эхнэр) хүүхэд, гэр малаараа ирэх хүн бол бүү саад

хий. Саад хийвээс мориор баалъя (шийтгэ).

СIX зүйл. Морьтой эм, хүүхэдтэй бөгөөд бог малгүй хүн зорьж ирсэн хүнийг ноёнд нь хүргэж өг. Тэр хүний ноён шүдлэн мориноос дээш юугаар шагнахыг өөрөө мэдтүгэй. Явган хүн ноёноо зорьж ирэх болбоос мөн л хүргэж өг. Тэр хүний ноён нь хониноос дээш юу өгөхийг өөрөө мэдтүгэй.

СХ зүйл. Ер босуул олон бөгөөд босуул мөн гэж танигч хүн хүч хүрэхгүй болбоос аль ойр улсад зарла. Зарлалат эс ажирваас үл ажрагчийг арван наймтаас дал хүртэлх насны эр болбоос бүгдээс нь хөл морь ав. Зарлагчид ялгүй. Зарлагчийн шанг ноён нь мэд.

СХI зүйл. Босуул босохдоо гурван хоногоос дотор хүн алваас босуулын малаас хүний анзуу өгье. Босуулын мал анзуу эс гүйцвээс эм хөвгүүнийг барьж өгье. Хар (ганц) бие хүн босохдоо (оргохдоо) хүн алваас ноёноос нь хүний орыг тэмээгээр босгоод, далан таван анзуугаар торгоё. Ноён нь анзуу эс гүйцвээс шахаагаар арилгаж малыг нь хагаслаж өгье.

СХII зүйл. Босуул хүн хүнийг шархдуулаас босуулын малаас шархдагчид идүүлэн шөл өг. Ямбат хүн шархадсан бол нэг тэмээ, нэг морь өг. Энгийн хүн бол нэг морь өг. Босуул малгүй бол ноён нь гурван шөл (хонь) өг. Ямбат хүнд нэг тэмээ, нэг морь өг. Ямбагүй хүнд нэг морь өг. Босуул малтай бол харвасан цавчасны анзуугаар бай.

СХIII зүйл. Гурван хоногоос цааш босуул ямар ч гэм хийв ноёнд хамаагүй.

СХIV зүйл. Босч гурав хоногоос цааш босуулыг барьсан хүн босуулын биед юу байгааг тонож аваад, хар биеийг язгуурын эзэнд нь барьж өг. Босуулын авч яваа юм нь хөндлөнгийн хүний юм болбоос язгуур эзэнд нь өгөөд баригч хүн хагасыг идэх, тэр хөндлөн хүний юмыг босуул төлж өгөх, босуул юм байхгүй бол босуулыг барьж өг. Босуулын эзэн хүнээ өгөх дүргүй бол эрийн золио таван бод, эмийн золио гурван бод, хүүхэд бүрт нэгжгээд бодоор золих. Энэ малын нас цөм шүдлэн, үхэр, морь сольж авч болно.

СХV зүйл. Бас босуул хүн эм ба охиныг босгож хүчиндвээс (ичээвээс) мөнхүү босуул хүн алсан лугаа адил.

V БҮЛЭГ. ЦАГААЧЛАГЧИЙН ТУХАЙ ХУУЛЬ

СХVI зүйл. Бас ер хавчуурыг (өөрийн гэх эзэнгүй, энд тэндгүй тэнүүчилж, очсон явсан газраа хавчигдаж байдаг хүн) юутай ирсэн болох ахул түүнийг авах. Түшүүлэгч (хавчуурыг очсон газар түүнийг хүлээн авч тусалж дэмжсэн хүн) хүн юу өгсөн бол түүнээ авах. Завсрын (хавчуур нь ямар нэгэн газар ирж аж төрж амьдарч байгаад буцаж явах хүртэлх хугацаа) үржсэнийг язгуурын малын хэрээр (бангаагаар нь) хуваах. Хавчуур миний олсон ийм юм гэх бол түшүүлэгчийн даргыг шахах. Мөн гэж хэлбэл хавчуурт өгөх. Эс тэгж хэлбэл урьд ёсоор хувааж бай.

СХVII зүйл. Ер гурван хошууны хавчуурыг хаа явж гэм хийвээс хавчуур өөрөө даах. Нэг дохтой хар (ганц бие) хүн бол авч явагч хүн даах, биш хошуунаас ирсэн хавчуур гэм хийвээс авч явагч хүн дааж, хадгалж уг ноёнд нь хүргэж ялла. Хар бие бол явагч хүн ноён сайддаа тушааж (өмч) өг. Эс бөгөөс хүргэж орхи. Өмч эс өгөөд, хүргэж өгөхгүй бол авч явагч хүн даах.

VI БҮЛЭГ. ХҮН ГҮТГЭХ, ЗАРЛИГ ЗӨРЧИХӨД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГЫН

ТУХАЙ ХУУЛЬ

СХVIII зүйл. Гэгээнд хэн хүн хэргээ үнэнээр айлтга. Гүжрээр худал үг айлтгаваас ноёдыг бол тэмээ тэргүүлэн долоон есөөр торго. Үүний таван есийг санд, хоёр есийг гүжирдүүлэгчид өг. Тайж тавнангууд бол тэмээ тэргүүлэн таван ес, үүний гурван ес бөхөл (бүрэн бүтэн) болоод есийн хагас дөрвийг санд, нэг бөхөл ес болоод есийн хагас тавыг гүжирдүүлэгчид өг. Харц хүн бол тэмээ тэргүүлэн гурван ест, үүний хоёр есийг санд, нэг есийг гүжирдүүлэгчид өгөх.

СХIX зүйл. Ноёдыг харц хүн гүжирлэвээс нэг тэмээ тэргүүлэн долоон ест, үүний таван ес нь санд, хоёр есийг ноёнд өгөх.

СХХ зүйл. Гэгээний (Жавзандамбын) зарлигаас ноёд давбаас (биелүүлэхгүй бол) таван ест, тайж тавнан давбаас хоёр ест, энэ есийн нэг нь тэмээ, найм нь адуу. Энэ малын нас шүдлэн. Тун (огт) юмгүй хүн бол энгийн хүнийг гурван жил хишиг бариулъя. Давсан ноёд, тайж, тавнан зэрэг эрхтэнийг мөн арван хоног зуу эргүүлж, мянга мөргүүлъя.

СХХI зүйл. Гэгээнд хоргодсон хүнийг (гэгээнд өгч хамгаалуулсан хүн) албал алсны анз болоод гадна нь (түүнээс гадна) зарлигаас давсны ёсоор торго. Хэзээд мөргөхгүй (бурханд мөргөх эрхийг хасах), хүн алахын зэргэд гэмт хүн хоргодсоныг ноён нь аваачаад албал гэгээний зарлигаас давсан ёсоор.

СХХII зүйл. Ер хоргодсон хүнийг хүрээний дотроос эзний санаагаар (дур зоргоор) аваачвал зарлигаас давсны ёсоор шийтгэх.

СХХIII зүйл. Дээрэнд (гэгээнд) мөргөхөөр ирсэн хүнээс гурван хошууны хүн хулгай хийвээс, аль хошууных байна, тэр хошуун лугаа хэлэлцсэн цаазаар торгохоос гадна гурван хошууны цаазаар засаглаад (яллаад) хүрээ зуу эргэж, мянга мөргөтүгэй.

VII БҮЛЭГ. ХҮРЭЭ ХИЙДЭЛ ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ, БАЙГАЛЫН ОРЧИН, ДАРХАН ЦААЗТАЙ ГАЗАР, АМЬТНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

СХХIV зүйл. Хүрээ ба их гэр засах гэж тэмдэглэсэн газар хэн хүн дур мэдэж байж буух ахул гурван ест, эс мэдэж буувал морь барьж нүүлгэ, эс нүүвэл гурван ест, нүүтэл морийг өгөх (барьцаанд авч байх).

СХХV зүйл. Дээрээс зарлигтай шахлага байсан газар (шахах цааз явуулж болохгүй газар): Хан-Уул, Хүшгэр, Хөгөнө, Түхэм, Шаварт, Онгоны бэрх хошуу, Хоёр шаахт, Онгон, Өнжүүл, Баян-Улаан, Зоргол, Суман-Улаан, Адаадаг, Улааннуур, Өгий эгдээр газрыг язгуурын ёсоор шахахуй байтугай (дээр дурьсан газруудад шахаа буюу хүний биеийг зовоож эрүү шүүлт явуулахгүй байх). Давж шахвал аймгийн ахаас нь тайлаж тэмээ, олноос нь нэг нэг хязгаалан морь авах, олон цөөн гэж үг яриа гаргавал аймгийн ахыг шахах, тайж тавнангийн биеийг шахах, гэрчлэгч хүнд арваас нэгийг өгөх, гурван аймгаас элч гарч авах, гурван аймгийн элчид арваас нэгийг идэх, нэгэн аймгаас шахавч хэлтгий (ганцаараа буюу дангаараа зарлиг зөрчиж шахах) гурван аймгийн элч гарч явах. Гурван аймгийн элч нар арваас нэгийг ид, буруутнаас авах буруугүй хүнээс авахгүй бай.

СХХVI зүйл. Бас хүрээ зассан (байгуулсан) газар хүрээнээс хуурай нойтон мод огтлохгүй. Хүрээний захаас гадагш гарвал өндөсч харваас нааш (өндийн хараад нүдний хараа тусах газрын) нойтон мод огтлохгүй байх. Хэн хүн огтолсон бол багаж болон биедээ авч

яваа эд юмыг бүгдийг авах. Тэр эд юмыг хэн үзсэн хүн авах, тэр үзсэн хүн аваад зарганд хүрэлгүй шингээвэл (аливаа зарга шүүх газар очилгүйгээр өөрөө авах) үзэгч хүнд хамаагүй болоод дам гэрчлэгч хүнд өгөх, хэн хүн (зарга шүүх газар очилгүй өөрөө авсан хүн) эс өгвөл гурван этгээдээс эрхгүй нэхэж авах. Нойтон мөчир нойтон модны ёсоор хуурай мөчир хуурай модны ёсоор цаазаар болох. Гурван этгээдээс элч гарч үзэж байх. Гаднаас ирэх ноёд, зочдод тэр гурван этгээдээс буюу гурван газраас гарч эргэж шалгаж буй элч хэлж танилцуулж байх. Огтолсон модноос мэрэг бүү ав (огтолсон модтой тааралдавч түүнээс олз бүү ав). Хэрэв авах бол хутганы чинээ юм ав, гоёхгүй. Хэрэв гоёх бол өгөхгүй. Хуурай мод огтолсон, нойтон модыг хуга дайрсан байвал элчийг нь ав. Мод огтолсон хүний эд юмнаас элч сүх ид. Гурван этгээдийн элч байвч нэг сүх идэж бай.

СХХVII зүйл. Хүрээ хаа зассан газраас зэрэгчлэн хойт бие нь Сэлэнгээс уламжлан Ар тойлб, Нам даваа, Нарийн, Орхон, Чандага тайн хяр, Шувуутайн хяр, Сангийн даваа, Цулхад зэргээс нааших газрын амьтныг алахгүй, хэрэв алваас хуучин цаазын ёсоор болгож бай. Нойтон модыг хүрээний захаас хоёр хар цагааны газраас нааших модыг бүү огтол. Огтолбоос багаж эд юмыг нь авч бай.

СХХVIII зүйл. Ер сар бүрийн шинийн найман, арван таван, арван гурван, хорин таван, гучин эдгээр өдөр юм бүү ал. Давж албаас мөн тэр алсан юмыг үзсэн хүн гэрчилж байж заргын газар хүрч ав.

СХХIX зүйл. Эмгэг өвчингүй морь, хонгор галуу, могой, мэлхий, ангир, нялх янзага, болжмор, нохой эднийг бүү ал. Алсныг үзсэн хэн хүн үзвээс морь ав.

VIII БҮЛЭГ. ХҮНИЙ АМЬ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ТУХАЙ ХУУЛЬ

СХХХ зүйл. Ноёд өөрийн албатаа шогоор алваас гэгээний зарлигаас давснаар торгох. Алагадгийн мал, эм, урийг дээр өргөө (гэгээнд өгөх). Буруут албат засагтаа сонсголгүй алваас зарлигаас давсны ёсоор торгох, алданхи нь санд авах. Өөр ноёдын албатыг алваас мөн хүн алсны анзуугаар болоод хүний орыг хэрийн хүнээр босгох (алагдсан хүнтэй тэнцэх хүн төлж өгөх). Хүнгүй (албатгүй) ноён бол сайн тэмээ, морь хоёроор босготугай. Хүн малгүй гэвэл намаас нь ноёдыг шахъя (ноёдын бүлэг дотроос нэгийг нь шахаж түүний "хүн малгүй" хэмээсэн үнэн эсхийг нотлох). Шоглож юугаар жанчваас мөн их цаазын ёсоор болгох. Харц хүн харц хүнийг жанчсан бол анзуугаар торгох. Буруу хийсэн харц хүнийг ноён урьд зодоод заалдваас ямар буруу хийсний алдангийн хагасаар торгох.

СХХХI зүйл. Хэн хүн хүнийг өшөлж ба шоглож алваас гучин бэрх гурван зуун анзуу болоод ямбат хүний орыг хүн тэмээ хоёроор босго, ямбагүй хүнийг хүнээр босго, хүнгүй бол залуу тэмээ, соёолон мориор ор босго, засаг нь зуу ташуурдаад хошууны дотор хятадын хятадад барьж өгье (боолын боол болгох). Анзуугийн мал эс гүйцвээс биеийг нь алагадгийн (эм) оронд халуун амьсар нь барьж өгье.

СХХХII зүйл. Хүний хоёр нүдийг тэсэлбээс (сохолвоос) хүн алсан лугаа адил. Нэг нүдийг тэсэлбээс зуун тавиар торгох, ташуур нь адил, шүд хугалваас шүд бүрийн нэг ест, шүд тоолон нэг сонгодог бодоор ор босго, хөдөлсөн шүд бол ор өгөх ялгүй, охорсон (сохорсон) нүд

бол ирт үзүүртээр алалгүй шархдуулсан лугаа адил. Гар хөл хугалж хэрэгт орвоос (эдгэж ажилтай болох) гурван ест, эс орвоос нүдний анзүү лугаа адил. Эрхий, долоовор хэрэгт эс орвоос гурван ест, орвоос нэг ест, өөр хуруу эвдэрч хэрэг дор эс орвоос нэг ест, орвоос тавт

CXXXIII зүйл. Ноёдын гар хөлийг ташаарч хүндээр гэмтээвэл байгаа бүх эд малын нь хагасыг авч яллах. Хуруугий нь ташаарч гэмтээвэл долоон ест, ноёноос өөр хүнийг ташаарч гэмтээвэл хагас анзугаар торгох, биед нь засаггүй (эрүү шүүлт тулгахгүй), ямбат хүнийг ташаарвал нэг тэмээ, нэг морь ав. Энгийн хүнийг ташаарвал нэг морь ав, шөл өгч эдгээгээд ноёндоо тушааж өг.

CXXXIV зүйл. Харц хүний мэдэл хөвгүүдийг (харц хүний гэрийн ажил хэргийн талаар эрх мэдэлтэй хүн) алваас хагас анзугатай. Эмтэй нь унтваас мөн хагас бай.

CXXXV зүйл. Шогоор ямар ч юм булааж авах бол тэр зэргийн том хулгай хийсэнтэй адил. Ер шогоор хүний мал ачиж, унавал хөлт, ачиж унасныг үхүүлбэл мөн ял болоод орыг өгөх.

CXXXVI зүйл. Ер хүний мал эндүүрвээс хөлт.

CXXXVII зүйл. Бас шилэрсэн ингийг барьж ботгыг нь дэнжүүлж (хөлд оруулж) өгсөн хүнд шилдэг хонь өг.

CXXXVIII зүйл. Тарвага утаад ухаж авалгүй орхисон хүнээс шүдлэн үхэр ав.

CXXXIX зүйл. Хэн хүн хүнийг аминд хүрэхээр их үгээр ховолж худлаар хаанд айлтгаваас харц хүн ноёдыг бол ноёдод ам гарсан (гэмгүй хүнийг муучилж гүтгэсэн) алданхиар торгох, тайж тавнан бол тайж тавнанд ирт үзүүрт гаргасантай адил, энгийн хүн ямар ямбатыг их үгээр ховолвоос тийм ямбатанд зэмсэг гаргасан ёсоор болгоё. Ямар зэргийн хүн мөн тийм зэргийнхээ хүнийг ийм үгээр ховолвоос зэрэг юугаан (адил зэргийн) хүнийг ирт үзүүртээр жанчсаны алданхиар торгоё. Өчүүхэн худал үгээр ховолвоос тавь ташуурдыа. Ноёд бол соёолон морь автугай. Засаг барьсан ноёдод хэн хүн худлаар (их үгээр) ховолвоос хаанд их үгээр ховолсны хагас алданхи, бага үгээр ховолвоос бага үгээр ховолсны хагас алданхиар торгоё. Ерийн ноёдод ховолвоос нэг естөөр торгоё.

CXL зүйл. Ер ямбат хүний эм нь эр юугаан ямба лугаа адил.

CXLI зүйл. Харц хүн болоод нэгийгээ харааж, хараагдагч хүн нь нөгөөгөө хараагагүй нь тод гэрчтэй бол хараагчийг хязгаалан мориор торгоё. Элч морь авагчаас хонь, гэрч нь торгуулагчаас хонь идтүгэй.

CXLII зүйл. Жүнгэн (хааны их хатан) болон хаанд ам хазайваас буй бүх юмыг нь талаад цөмий нь санд барья. Халуун амийг цөм (гэр бүлээр нь) албатын хөвгүүдэд (хаад ноёдын зарц боол) барьж өгье.

CXLIII зүйл. Бас ер ноёдод ам гарч (харааж) гар хүрвээс ял нь энэ ёсоор. Биеийг нь дайрсан (биед нь гар хүрсэн) хэнийг ноёны албат дотор муу хүнд барьж өг (хамгийн адгийн муу хүн болгох). Дашаарваас дашаарсан нь бодитой болох ахул хагасаар торгох. Мэлзвээс ноёдын тул ноёдыг, харцын тул сайдыг (хошууны дотор) сонгож шахаж бай.

CXLIV зүйл. Ноёд өөр зуураа ирт үзүүрт гаргаваас нэг тэмээ тэргүүлэн таван ест, хэн нь гаргаваас түүнийг торгох, хоёулаа гаргаваас үрэх. Гаргасан зэмсгээ өөрөө хурааваас мөн ёсоор торгох, хүн барьж (хурааж) авбаас

зэмсэг гаргасан ноёныг нэг тэмээ, дөрвөн мориор баалж засагт авах, барьсан хүнд бааны малаас хоёр морь, ялын малаас есөн бод өгөх. Хоёулаа гаргаад үрсэн боловч хоёулангаас нэг нэг тэмээ, дөрөв дөрвөн мориор баалж засагт авах. Ноёд хэрэлдэж зодолдвоос ах нь буруутай бол морь тэргүүлэн ест тавт, дүү нь буруутай бол гурван ест, амаар донголцвоос (доромжилвоос) ахын буруу бол тавт, дүү буруут бол нэг ест, ах нь халж (халдаж) зодоод дүү нь эс хүлээвээс үрье. Дүү нь халж зодоох ахул дүү нь эс хүлээвээс үрээд, алданхины илүүг ахад нь өгье. Тайж тавнан өөр зуураа хэрүүл болж ирт үзүүртийг гаргаваас, мөн мод, нударгаар цохилцох хийгээд амаар хараалцваас хоёр харц хүн хэрэлдсэнтэй адил. Авайд гар хүрвээс ноёд лугаа адил. Бас танж тавнан харц хүнийг жанчваас мөн ирт үзүүртийг гаргаваас энгийн хүний ял лугаа адил, учиргүй харааваас нэг хязгаалан морь ав.

CXLV зүйл. Ер ноён тойныг (язгууртны гаралтай лам) жанчих ба хараах алин ч болов хаан хүнд ам хазайсан, гар хүрсний ёсоор шийтгэ. Хаан ба харц алин ч гэлээ хүнд ирт үзүүртээр гар хүрвээс ест, өөр юугаар гар хүрвээс долоон ест, амаар дайрваас гурван ест. Гэцэлд (бага сахил авсан балам буюу лам) ирт үзүүртээр гар хүрвээс зургаан ест, өөр юугаар ч гар хүрвээс дөрвөн ест, амаар дайрваас ест тавт. Ер бандид (бага сахил ч аваагүй бяцхан лам) ирт үзүүртээр гар хүрвээс таван ест, өөр юугаар гар хүрвээс гурван ест, амаар дайрваас нэгэн ест. Өвшид (гэртээ байдаг бөгөөд сахил авсан жирийн эр хүн) ирт үзүүртээр гар хүргэвээс гурван ест, өөр юмаар гар хүрвээс ест тавт, амаар дайрваас ест тавт. Аль алинд нь ирт үзүүрт гаргавал гараар цохисонтой адил. Аливаа санваартны (сахил авагчид) сахил авахуулсан хүн мал боловч сахил хүртээсэн учиргүй ноёрхож хараавал мөнхүү хуврагийг (тойн, гэлэн, гэцэл, банди зэрэг бүх балам буюу лам) дайрсан алданхиар торгох.

CXLVI зүйл. Ер энгийн хүнийг хэн хүн ирт үзүүртээр жанчваас гурван ест, чулуу, модоор жанчваас нэг ест, ташуур нударгаар жанчваас тавт. Бас төр барьсан сайд хэргийн тул жанчваас ба харааваас ялгүй. Шоглож жанчаад ил эвдэрвээс (мах арьс улайваас, хөхөрвөөс) энгийн цаазын ёсоор торгох.

CXLVII зүйл. Төр барьсан их ямбатан сайд, тайж тавнан ирт үзүүртээр гар хүрвээс таван ест, өөр юмаар гар хүрвээс гурван, амаар дайрваас нэгэн ест болоод нэг тэмээ илүү авах.

CXLVIII зүйл. Бага ямбатан, шигээчинд (хаад ноёдын зээ, тавнангийн хүү) ирт үзүүртээр гар хүрвээс гурван ест болоод тав илүү, өөр юмаар гар хүрвээс нэгэн ест болоод гурав илүү, амаар дайрваас тавт.

CXLIX зүйл. Ер хэн эцэг ба багшдаа ямар юмаар гар хүрвээс есөн ест, амаар дайрваас таван ест, гар хүрсэн хүнийг ная ташуурдаад нэг жилийн хугацаагаар аргал түүлгэе. Хэн хүн амаар дайраад нэг өмчтэй болох (эцэг эх буюу багштайгаа нэг гэр бүлд хамтран амьдарч байгаа) ахул дөч ташуурдаад, жил гүйцтэл аргал түүлгэе.

CL зүйл. Ер хэрүүлийн өмгөөс (хэрүүл хийж байгаа хүмүүсийг өмгөөлж хамгаалсан хүн) хөл авах.

CLI зүйл. Согтсон хүн ихсийн (хаад, ноёд зэрэг дээд язгууртан, дээд тушаалтан) дэргэд

идвэл ноён нь шүдлэн мориор торго.

CLII зүйл. Хүн хэрэлдээд, шарх гаргасныг мөн өдөртөө ямбатан зэрэгт үзүүлж чадвал торгох. Ямбат сайд эс олдох ахул гэрч болж явах хүнд үзүүлж болно. Нэг хоновоос тоохгүй бай.

CLIII зүйл. Бас эрхи тасалбаас нэг морьт, хэдэн эрхи гэвээс төдий хоньт, шүрийг нь гэвээс төлөх, хэрүүлээр дангиа (хүзүүнд зүүдэг) тасалваас есөөр торгоод тэр алданхийг аймгийн дацанд (сүм хийдийн ном хурдаг газар) барь.

CLIV зүйл. Ер оргочин (буюу орохчин - гаднаас буюу өөр хошуу нутгаас орж ирэх хүмүүс) ба явдалд явагчид (албан ажлаар явах хүмүүс) завхуул малыг (алдуул мал) барьваас бүү авч яв. Аль ойр агсан хүнд сонсгож завхуулыг барьсан сар, өдрөө бичиж сайтар тушааж өг. Өгөлгүй авч явбаас хулгайд тооцох, барьсан газартаа үснээс нь тэмдэг тавь.

CLV зүйл. Завхуул малыг хэн хүн эс үзвээс хүнд сонсгож барь. Хүнгүй газар үзвээс барьсан газраа баригч малын үснээс буулж барь. Гурав хонотол бүү ажиж уна. Гурав хоносоос хойш ноён сайдад хэлж уна. Барьсан малын зүсийг буруу хэлбэл үхрээр баал. Мориноос өөр ямар ч завхуул малыг мөн энэ ёсоор ноён сайдад сонсгож барь. Барьсан малыг гурван жил болтол эзэн нь эс авбаас хойно танисны бөхөс идтүгэй (гурван жил өнгөрснөөс хойш таньж малаа авбал зөвхөн хагасыг нь авах).

Тэр мал алдваас, үхвээс сайдад сонсго. Эс сонсговал завхуулыг завшсан лугаа адил. Завхуулыг завшваас ор болоод нэг ест. Завшсаныг гэрчилсэн гэрч нэг сонгодогийг ид. Барьсан (алдуул) мал эм болоод үржсэн бол барьснаас хойшны үрийг нь баригч хүн идэх. Хөхүүлийг нь малын эзэн авах.

CLVI зүйл. Бас дотогш орох оргочин ямар ч хол аянд нөхрөө өвдсөнийг эмчлэлгүй, эзгүй газар орхиж ирээд, тэр хүн үхвэл тэмээгээр ор босгоод нэг есөн бод авах, эдгэвээс соёолон хязгаалан морь авч бай. Авагч (авсан) юмыг өвдөгчид өгөх. Энэ өгөгч (өгсөн) юмыг галын нөхдөд (нэг гал болж хамт явсан хүмүүс) адилхан өгч бай. Элчтэй болох ахул (элч хүн галын ахлагч болж явах) элчийг соёолон мориор баалж ноён нь ав. Бусад хүмүүсээс нь тус бүр нэгжээд шүдлэн морь авч эзэн ноёнд нь өгье. Тэр дотроос өвчилсөн хүнд баалуулсан хүн тус бүр шүдлэн морь өгөх.

CLVII зүйл. Хүнийг зовчвоос (бусдын мэдлийн хүнийг дур мэдэн өөр газар зайлуулж явуулах) таван ест, нууваас гурван ест.

CLVIII зүйл. Цээрлэх халдварт (өвчит) хүн өвчнөө нууваас, түүнчлэн халдаж хүн үхвээс хүн алсан анзугаар торгох, хүн өвдөөд эдгэвэл гурван ест, нуувал нэг ест гучин бэрх, гурван зуун анзугаар торгох.

CLIX зүйл. Нохой хуцаж ба зууж хүн үхвээс хүн, тэмээгээр ор босго. Мал хүнийг ямраар (өшиглөж буюу мөргөх зэргээр) алваас тэмээгээр ор босго.

CLX зүйл. Галзуу хүн, хүн алваас хагас анзугаар. Галзуу хүнийг барьж хүргэж өгөөд нэг залуу тэмээ, эмээлтэй морь ав. Галзуу хүнийг хүн алваас есөн ест, галзуу хүн хутхалдаж (хүмүүсийн дотор тэмцэлдэж) явсаар үхвээс үрье. Галзуу хүн, хүнийг гэмтээвээс дашаарсантай адил. Галзуу хүнийг эзэн ноён нь мэдэж байж эс хадгалваас (алдваас) нэг тэмээ тэргүүлэн есөн бод, дөрвийг адуу, дөрвийг үхэр өг.

CLXI зүйл. Аглаг зүүсэн төмөгийн саалинд (нүхэнд буюу газар ухаж тавих сагаал нум) шилэрдэж (харвагдаж, дайрагдах) хүн үхвээс хүн, тэмээний нэгээр ор босгоод зуун анзуу өгөх. Шөл өгч эмчилтүгэй. Эдгэвээс ямбат хунд тайлаг тэмээ, ямбагүй хүнд хязгаалан мориор төлөөс өгч бай. Нутгийн хүний малын бэлчээр дээр сагаалч (сагаал нум тавьдаг) хүн шогоор ирж зүүгээд, түүнд ямар мал үхвэл, төлөх, хэдэн мал шархадвал түүнийг эмчлэх, ачих, унах, саах малын оронд эдгэтэл ачлага, уналга, сааль (саах үнээ) өгөх, шоглож зүүсний алданхи шүдлэн морь өгөх.

CLXII зүйл. Төмөгийн сагаал (харвадаг нум) их зам дээр битгий зүү. Хулгайч сагаалинд дайрагдаж үхвэл ташаарсан лугаа адил. Мал үхвэл орыг холбоотой төлж бай. Бас сагаалинаас гадагш таван алд газраас нааш үхсэн гөрөсийг авсан байвал нэг шүдлэн морь авах.

CLXIII зүйл. Бас сагаалины нум хулгай хийвээс ял нь ес тавт. Орыг нь өгч бай. Нумыг эвдвэл нум тус бүрийг хониор ор босго. Нумыг эвдвээс ба авбаас шүдлэн морь аваад төмөгийг (нум сумыг) төлүүлбэ.

CLXIV зүйл. Ер алсан гөрөөснөөс мэргэ авах (хувь авах). Үнэг хөөж алахад оролцсон хүмүүсийн дотроос түрүүлж хөөсөн хүн нь ав. Айлын гадаа аргалчин, малчин тааралдаж алсан боловч хөөсөн хүн гүйцэж ирвэл эзэн нь авах.

CLXV зүйл. Хавхны цааз нь нум хулгай хийсэнтэй адил.

IX БҮЛЭГ. ИРГЭНИЙ БОЛОН ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ХОЛБОГДОЛТОЙ ЗАРИМ ЗҮЙЛ

CLXVI зүйл. Ер энэ гурван хошуун дотроо их гэмт хүнийг хөөж орхивол улсын зах харагч (хилчин) сайн хүнд тушааж өгөх. Эс тушаагаад тэр хүн гэм хийвээс үг эзэн нь даах. Тэр тушааж хөөж орхисон хүнийг хаан хүн түдгэзвээс (саатуулваас) нэг ест, тайж, тавнан, ямбатан, сайдаас хязгаалан, шүдлэн хоёр морь, харц хүн түдгэзвээс нэг хязгаалан морь авч бай.

CLXVII зүйл. Ер хэн хүн ямбат хүний булш эвдвээс нэг ест, бага ямбат хүний булш эвдвээс тавт, энгийн хүний булш эвдвээс хөлт.

CLXVIII зүйл. Ихэсийн онголсон газар, хоёр хар цагааны газраас дотогш хүн бууж мал нь хөндвөөс малын эзнээс хөл авч бай.

CLXIX зүйл. Чонын хөөсөн ба бороо шуурганд уруудсан хониноос зуун хонь бол нэг шилдэг, хоёр дунджийг ид.

CLXX зүйл. Чонын барьсан сэгийг нууваас таваар торго. Чононд баригдсан малын сэгнээс авсан байвал нэг морь ав (Өөрөө алж идсэн малыг чононд идүүлсэн хэмээн нууж буюу худал хэлж болохгүй).

CLXXI зүйл. Ер хан хүн, харц хүн хоноцыг хөөж, хоноц хөөгдөж яваад үхвээс хөөгчөөс хүн ба тэмээ нэгээр ор босго, гурван есөөр торго. Мал үхвээс орыг нь ав. Хүний гар, хөл хөлдөж унаваас нэг ес ав. Гар хөл нь уналгүйгээр хөлдвөл шүдлэн морь, шүдлэн үхэр ав. Зүгээр хөөсөн байвал шүдлэн морь ав. Хөөгдсөн хүн хөөгчийн өрхийг дэвс (гэрийн) гадна нь хонож, хоноцын уналгыг алдвал гэрийн эзэн төлж бай.

CLXXII зүйл. Ямар ба гэсэн юмыг олсон хүн ноёд айлтгаж, сайдад мэдүүлж зарла. Эзнийг нь олж харвал эзэнд нь өг. Зарлалгүй нууж байгаад эзнийг нь хожим хойно олж харвал

нэг морь өг. Хөндлөнгийн хүн минийх гэж авбал хулгай хийсэн ёсоор шийтгэх. Баян хүн байвал эрх тушаалыг нь хасах. Гэсэн юмыг олсон хүн ямар ч юм байсан гурван хувийн нэгнийг идэх. Бурхан ном, буу, сахиус олсон хүн ёсоор зарлаж эзэнд нь өг.

CLXXIII зүйл. Хүний шинэ ухсан зассан усыг булаацалдаж хэрэлдвээс нэг хязгаалан морь ав. Өөрийнхөө малыг усалж дууссан боловч усаа эс өгвөөс мөнхүү морь ав. Хазаарт моринд ус эс өгвөөс шүдлэн хонь ав. Унасан мориноос бусад адууг хуурч усалваас мөнхүү морь ав (шинээр ухсан худаг буюу ус гүйцэд сайн ундарч гараагүй байхад мал услахыг хориглож буй). Мэдээ байж (зориудаар) шоглож ус бохирдуулбал шүдлэн морь, үхэр хоёрыг ав. Үзсэн гэрчид үхэр өг.

CLXXIV зүйл. Ер өтөгт (гэрийн буурь, бууц) барьсан, буусан гэрийг байх ёстойд тооцно. Бариагүйг тооцохгүй. Хоёр хүн зэрэгцэж өтөг үзэхээр ирээд булаацалдлаас хэн урьдсан нь автугай. Хоёулаа зэрэг хүрч ирвэл хэн эхэлж хараад ташуураараа газар цохисон нь ав.

CLXXV зүйл. Орос, Хятадын энд ирсэн наймаанаас (худалдаачнаас) хэн зээл (бараа) авагч хүн эзэн ноёндоо айлтгаж тушааж ав (зээлээр авсан барааныхаа тухай мэдэгдэж бай). Авсны хариу өгөхдөө мөнхүү тушааж өг. Аль алиныг эс тушаавал соёолон мориор баалж, зээлэнд дутсан юмыг эрхгүй хурдан гүйцээлгэж өгч бай.

CLXXVI зүйл. Хэн хүн түймэр алдлаас хэдэн хүн ч байсан хүн тус бүрээс морь аваад юуг түлвээс таваар торго, алдагч хүн өөрөө унтрааваас торгуульгүй гэрчилвээс гэрчлэгч хүн хөл идээд алданхиас нэг морь ав, үлдсэн дөрвийг түймэр унтраасан хүмүүс хувааж ид.

CLXXVII зүйл. Улсын (олон айлын) дунд түймэр шатааваас түймрийг аль ойр байгаа улс нь (айл нь) зартай заргүй унтраа. Зар сонсож байж ноён хүн эс мордвоос морь ав, ямбатан сайд дарга нараас үхэр ав, энгийн хүнээс хонь ав. Хэн хүн зар тасалваас энэ зэргээр баалж бай. Хүн үхвээс хүн алсны анзуу болоод ортой (хүний амийг тэмээгээр орлуулж далан таван анзуу авч байх).

Ямбат хүн түлэгдээд эдгэвэл тэмээ морь хоёр өг. Ямбагүй бол морь өг, эдгэтэл шөл өгч эмчлээд ноёндоо тушааж тавь. Нүүсэн нутгаас гал гарваас гурав хоногийн доторхийг тооцох, гурав хоногоос цаашихыг тооцохгүй. Хэн хүн нүүсэн нутгийнхаа галыг унтраа, эс унтраавал шүдлэн морь өгч бай.

CLXXVIII зүйл. Нэг жилд нэг сумнаас арван өвч хуяг авах, жилдээ хэдэн хуяг дутваас зангиас (сумын засаг дарга) хуяг тоолон морь авъя. Тогтоосон тооноос гадна санаагаараа хуяг олсон хүнийг ноён нь хязгаалангаас дээш насны мориор шагна. Ер хуяг хөө, олбог, илдэс алиныг ч болов өгсөнд тооцож байх. Ер хуяг олох чинээтэй ноёд тайж нар гурван жил дотор хуяг олох, эс олвоос хязгаалангаас дээш мориор баалж засагт аваад, хуяг худалдаж аваад, хуяг олох чинээгүй сайн эрд шагнасугай. Баалуулагч хүнээр дахин хуяг олгуул.

CLXXIX зүйл. Ер жуулчин хүн жуулчлахдаа хоногийн газраас цааш одоодоо төрөл ураггүй сайн хүнд сонсгож яв. Ирсэн ураг төрлөө мөнхүү сайн хүнд сонсгож илгээ. Гэртээ хүрч ирэхдээ урьдаар сайн хүнд сонсгож үзүүлж байж гэртээ буу.

CLXXX зүйл. Өрийг өдөр барьж авах бол ямар нэгэн хэрэгт холбогдуулж авч үзэхгүй.

Шөнө барьж авсан байвал хулгай болох.

CLXXXI зүйл. Эм хүнийг жанчиж хүүхдээ унагааваас (дутуу гаргаваас) хэдэн сартай бол төдий есөөр торгох.

CLXXXII зүйл. Бас ер ураг төрлийн харьцаатай хүнийг гэрч болгож буюу гэрчээр явж болохгүй. Юманд ханилж явсан хоёр хүн, элч, улаач хоёр, айл саахалтын хүн (хоноц, хонуулагч) олны мэдэх хүмүүсийг гэрч болгож болохгүй.

CLXXXIII зүйл. Ер хэн хүн лам нар, ямбатан, сайд дархадын морийг өөрийн хэрэгт санаатайгаар унасан байвал морь авч бай. Ер хэн хүн элч унаж эцсэн морио хуурч худалдлаас мөн хулгайн ёсоор үзэж шийтгэх.

CLXXXIV зүйл. Нэгэн хүн олон жуухтай (үе угсаа залгамжлах тэмдэг бичиг буюу баримт бичиг) бол нэг л хөвгүүндээ өгөх.

CLXXXV зүйл. Ер эцэг нь хөвгүүнийхээ (өрх гэр болж амьдарч байгаа хүү) амийг мэдэхгүй бай (түүний гэр бүлийн, ахуй амьдралыг эцэг нь толгой мэдэж болохгүй).

CLXXXVI зүйл. Ер гурван хошуун дотроо ноёдын хэвт болгож хайрласан сайд (язгууртан биш боловч ноёдын зэрэгт орж явах сайд буюу хайрын ноён) мөнхүү ноёдын ёсоор бай.

X БҮЛЭГ. ГУРВАН ХОШУУНЫ ИХ ЦААЗАД ОРУУЛСАН НЭМЭЛТҮҮД

CLXXXVII зүйл. Эр дарсан (цэрэгт явах болсон хүнийг буюу түүний насыг нууж дарвал) байвал найман адуу, нэг тэмээгээр баалах, дарсныг хэн хүн харсан байвал гурван адуу, нэг тэмээ өгөх, нум дутаавал шүдлэн морь, жад дутаавал бяруу, буу дарж хүнд худалдсан байвал шүдлэн морь авах, таван сум дутвал шүдлэн хонь, сэлэм, бууны сэлбэг хэрэгсэл дутаавал сумны ёсоор баалах, жадны иш гурван алд дэлэм дутвал шүдлэн хонь өгнө.

CLXXXVIII зүйл. Арван хүний нэг нь дарга байна. Энэ арав дотроос хорь хоногийн газраас нааш явахдаа шанзтавт (шанзав лам) айлтгаж яв. Эс айлтгаваас давсан ёсоор бай. Хорь хоногоос нааш явахдаа арвын ахад хэлж зөв гэвэл яв (арвын хамгийн их настайд нь хэлж яв). Эс хэлж явбаас шүдлэн мориор баалж бай.

CLXXXIX зүйл. Архийг жаран наснаас доошхи хүмүүс уухыг дор дурдсан гурван нөхцөлөөр хязгаарлаж буюу хориглож байжээ. Засгуудаас дээшхи ихсийн хишиг, хүүхдийн хурим (үс авах), гүүний үрс (гүү барих баяр) эдгээрээс өөр цагт архи бүү уу. Уувал үзсэн хүн эмээлт морийг нь ав.

CXC зүйл. Ер энэ цааз доторхи хэмжээнээс дутвал захирч эс чадсан тул даргаас соёолон, шигүүлэнгээс хязгаалан, дамчаас (дамал) шүдлэн хонь авч бай. Арвын даргаас шүдлэн хонь авч бай.

CXCI зүйл. Тамганы хэмжээ гурав дөрвөөс нэг нэг, олон тэмээтийн тав бүрээс нэг нэг, морийг арваас нэгийг тамгалж бай.

CXCII зүйл. Тамгат тэмээ, морийг гурван үйлээс биш элчид бүү өг. Элч, улаач хоёр мэдэж байж барьж унах бол эртний цаазын ёсоор шийтгэж бай. Илүү ачлага, уналгагүй хүн нүүдэлд ач, уна. Ачиж унаад гажуу явах бол эртний цаазын ёсоор (Монгол-Ойрадын 1640 оны хуулиар) шийтгэж бай.

CXCIII зүйл. Бас ер нийт хэн хүн хятад, орост тэмээ бүү хөлслүүл. Хөлслүүлвээс мөн хөлсийг авч бай.

СХСIV зүйл. Эр бүр хулгана жилийн (Энх-Амгалан хааны тавин есдүгээр оны хөх хулгана жил, нийтийн он тооллын 1720 он) цагаан сараас нааш олбог хийхтүн. Бэлэн олбоггүй хүн цагаан сараас нааш олохтүн.

СХСV зүйл. Гэгээний элч ба аливаа элч улаа унахдаа улаа унахын тоогоор тамга дарсан бичиг өгөх, тамгагүй бол улаа өгөхгүй. Тамгат элчийн улаа тасалбаас урьд цаазын ёсоор торгож бай.

СХСVI зүйл. Дээрхийн (Дайчин гүрний хаан буюу төрийн дээд газар) шавь нараас дээдийн хэрэг, цэргийн хэргээс бус манай долоон хошууны элч өөрийн хэрэгт улаа унахгүй. Хэрвэ унаваас язгуурын цаазын (Монгол-Ойрадын 1640 оны хуулийн) ёсоор торгох.

СХСVII зүйл. Улаат засгууд улаа унуулж явуулах хэрэгт элчээ өөрийнхөө тамга дарсан бичиг өгч зарах (явуулах). Онц чухал хэргээр улаа унах эрхтэй харц хүн зөвхөн мөргөлд явахдаа л улаа унахтүн. Хол жуулчилж яваад улаа, хүнс дутвал унаж, идэж бай. Улаа унах ёстой хэрэгт улаа унахдаа аймгийн Ихсийн (хошуу засгаас дээшхи хүн) тамгаар явж бай. Тамгагүй бол жуухаа (онц чухал эрхийг зөвшөөрсөн тэмдэг бичиг) авч явж унах, тамга, жуух эс үзүүлвээс улаа шүүс өгөхгүй.

СХСVIII зүйл. Хэн хүн өр нэхэх бол өгөгч, авагч хоёр их хүрээний орчин хаан шанзтав вангуудад тушаасангүй (мэдэгдэхгүйгээр) өгснийг үрэх, мэдэгдсэн бол хэлэлцэх. Хөдөөд бол нэг сум, нэг отгийн хүн бол сумын тайж ба улсын зангиас дээш хүнд, отгийн харьяат хан харц хүн (харц гаралтай дарга хүн) даргадаа эс тушаасныг үрэх, хоёр өөр отог ба сумны хүн бол мөн тус тусын захирагчдаа эс тушаасан байвал үрэх. Хэлтгий тушаах (нэхэмжлэгч буруу ташаа нэхэмжлэл гаргах) бол нэхэгчийн дарга занги ганцаараа мэдэвч, нэхэгдэгчийн дарга зангийг мэдээгүй бол үрэх.

СХСIX зүйл. Гэлэн (их сахил авсан балам буюу лам) хүн архи ууваас есөн соёолон морь, гэцэл хүц ууваас таван соёолон морь, банди хүн ууваас гурван соёолон мориор баалж бай. Тэднээс авсан бааны мориог гэрчилсэн хүнд өгч бай.

СС зүйл. Тэдэнд хэн архи өгвөөс таван соёолон мориор баалж бай.

ССИ зүйл. Хэн хүн үзсэн атлаа нууж дарваас архи өгөгч ёсоор шийтгэж бай. Өгөгч ба дарагчийг баалсан мориог их санд (сумын сан хөрөнгө) тавьж бай.

ССИI зүйл. Гэлэн, гэцэл, банди хэн ч архи ууваас их хуралд эдтэй (өргөл барьц) манз чанаж (номын хуралд цай, хоол бэлдэж өгөх), биеэ ариутгах номыг гэлэн хорин нэг, гэцэл арван дөрөв, банди долоо уншиж хуралд мөргүүлвэ.

ССИII зүйл. Зэд, манз хийх юмгүй хувраг архи уувал манзны усны хувинд гурван сарын турш өдөр бүр зургаан хувин ус хийж бай. Дуусгаад мөн ёсоор хуралд наманчилтугай.

ССIV зүйл. Залхалгүй дахиж архи уувал хулгайчийн ёсоор жил дуустал хадья (шоронд хийх). Дуусаад мөн ёсоор наманчилтугай.

ССV зүйл. Ер хан харц, хэн хүн хуврагт архи өгвөөс өгөгч хүнийг дөрвөн соёолон мориор торгож хоёрыг нь засагт автугай. Хоёрыг гэрч идтүгэй. Архи уусан хуврагийг цаашид ном үзүүлэх эсэхийг лам нь мэдтүгэй.

ССVI зүйл. Ер хуврагт архи дахин худалдвас зарлигаас давснаар торгоё. Хар хүн бол найман шүдлэн адуу, нэг тэмээгээр торгоё.

Дөчин ташуур жанчъя. Гэрчилж харсан хүнд энэ малын хагасаар шагнаа. Худалдагчийн архиог хэн хүн гэртээ хадгалвас (хэн хүний худалдах гэж байгаа аливаа юмыг замаас нь аваад цааш нь өндөр үнээр дамлаж худалдах) уутчийн ёсоор шийтгэж бай.

ССIX зүйл. Хүрээ гэгч бурханы орон тул худалдаа хийгч ард өдөр худалдаа хийхээс бус өөр самуу улс (биеэ худалддаг янхан) үзэж шөнө дөл очиж хоноод тэр нь илэрч мэдэгдвээс хулгайчийн ёсоор яллаа. Авч хоносон гэрийн эзнийг (янхны худалдаа хийдэг хүн) мөнхүү ялаар яллаа.

ССX зүйл. Үзвээс самуу улс (архи худалддаг хүн) цаазыг дагаж явахгүй, архи авч ирж нууж далдалж худалдаад тэр нь илэрч мэдэгдвэл нэг есөн малаар торгоё. Үүний нэг нь тэмээ, найм нь шүдлэн морь байна. Бас дөч ташуурдъя. Архи худалдсан хүнийг үзэж гэрчилсэн хүнд таван мориор шагнаа.

ССXI зүйл. Архины худалдаа хийх газрын самуу газар (архи худалдах ба янхны газар буюу биеэ худалддаг эмсийн гэр орон) бүр монголчууд ирж худалдаа хийвээс таних улс ба үл таних улсыг бүү авч хоногтүн. Гэртээ авч хоновоос гэрийн эзнийг гурван соёолон мориор яллаа. Гэрээр (янхны газар) аливаа монголчууд ирж дураар хоновоос манайд ирж мэдэгд. Хэргээ зөвшөөрөхгүй бол унаж яваа мориог нь аваад соёолон мориор торгоё. Гэрчилсэн хүнд авсан юмны хагасыг өгье.

ССXII зүйл. Хэн хүн хулгай хийвээс хэдэн хулгайч болбоос цөмийг хааш хаашаа дөрөв дөрвөн алд өргөн гүн газар ухаж нэг жил дуустал хадъя. Ах хулгайчийн эхнэр, хүүхэд малыг авч (хурааж авч) малын эзэнд барьж өгье. Дүү хулгайч нарыг гурван есөн бодоор яллаа. Хулгайчийг худгаас (шоронгоос) гарсан хойно зуу ташуурдаад гурван жил болтол түлээ түүлгэе.

ССXIII зүйл. Хулгайчийг яллах талах цагт өөрийн юмнаас нь үлдээж өгье (зөвхөн ял эдлэх хугацаанд нь идэж уух юмыг нь өөрийнх нь эд хөрөнгөнөөс гаргуулж байх).

ССXIV зүйл. Эсийн хэмжээ хоёр морь хоёр шар, үнээ, хоёр шүдлэн, нэг бяруу байхаар тогтоожээ.

ССXV зүйл. Хулгайчаас талсан зүйлээс нэг сонгодог, дөрвөн хязгааланг гаргах (энэ нь хулгайчийн хэргийг зөвхөн шийтгэх үед хэрэглэгдэх зүйл болно).

ССXVI зүйл. Түшмэд элчид нэг соёолон, нэг хязгаалан өгөх, дэд хулгайчийн гурван есөөс нэг морь, нэг шар, нэг үнээ, хоёр шүдлэн, нэг бярууг зарцуулах, нэг шар, нэг шүдлэн, нэг бярууг түшмэд элч нар хувааж идтүгэй (хулгайчийг олж барих, яллах, ял эдлүүлэхэд гарах хөрөнгө зардлыг ийнхүү өөрөөс нь гаргуулж байжээ).

ССXVII зүйл. Хэдэн гурван ес байсан ч дээр өгүүлсэн ёсоор гүйцэтгэж байх. Хэдий ч ял болов буруутын хошууны элч нэгэн шүдлэнгээс илүү идэхгүй.

ССXVIII зүйл. Ял эс гүйцсэн хүний эм, үрийг нь бодож ялыг гүйцээнэ. Хулгайчийн ноён ба төрөл нь зольж авах болвоос үнэ нь хуучин цаазын ёсоор бай (хүнээ барьж өгөх дургүй бол эрийн золио таван бод, эмийн золио гурван бод, хүүхэд бүрт нэжгээд бодоор золих, малын нас том шүдлэн байх).

ССXIX зүйл. Хулгайчийг худгаас суллаж гаргасан этгээдийг харсан гэрчид хулгайчийн хураасан малын хагасыг өгч, ах хулгайчийн эм

үр дотроос аль нэгийг нь сонгож өгье.

ССXX зүйл. Тайж хүн хулгай хийвээс дээдийн цаазын ёсоор шийтгэ. Нэг удаа хулгай хийхэд нь тайжийг эвдээд (тайж хэмээх хэргэм зэргийг хүчингүй болгоод) гэр малыг нь хураалгүй гурван есөн бодоор яллаад улстай (өөрийн харьяат хамжлагатай) бол улсыг нь ах дүү нарт нь авч өгье. Дахиж хулгай хийвээс мөнхүү харц хүний ёсоор яллаж засуульа.

ССXXI зүйл. Хувраг хүн хулгай хийвээс анх удаа хулгай хийхэд нь худаглах хатуу засгийг (гавлах гинжлэх) нь байж, гурван есөөр яллаад, өөрөө санваараа эвдсэн тул отго, суманд нь өгч хар болж явтугай. Дахиж сахил авах, наманчлахыг хориглоно. Хулгай хийсэн хувраг хар шавь, гэрийн боолтой бол тэр шавийг нь отго суманд гаргаа.

ССXXII зүйл. Ер тайж ба хувраг хүн хонины үнэ үл хүрэх эд юм хулгай хийвээс ял нь хуучин цаазын ёсоор байх, харин тайж хүний тайжийг нь эвдэхгүй улсыг нь салгаж авахгүй байх. Хувраг өөр дуртай бол наманчилж санваараа сэлбэтүгэй (нүглээ наманчилж сахилаа шинэтгэ), дургүй бол хар болгож отго, суманд гаргаа. Хувраг хүн шахаагаар хэрэг хүлээвээс мөн ёсоор хагас ялаар яллаа. Яллагдсан хувраг манз чанаж наманчилтугай.

ССXXIII зүйл. Вангуудаас доош хэн хүн хулгайчийг дарваас үүнд: засгийн ноёд биеэр дарваас таван ес, эн ноёд (засаг захиргааны газар алба ажилгүй сул) дарваас гурван ес, тайж таван, сайд дарга нар дарваас ес тав, энгийн хүн дарваас нэг есөөр торгое. Гэрчилсэн хүнд торгуулийн хагасыг өгье. Хагасыг нь засагт автугай. Засаг ноёдын таван эеийг нөгөө засгууд хувааж автугай. Хулгайчийг барьж шийтгэсэн өдөр нь засаг ба ноёд сайд, сайн хүнээр толгойлуулан авч явж худагт хүргэтүгэй.

ССXXV зүйл. Шахаагаар торсон хулгайчийн ял нь язгуурын цаазын ёсоор болтугай. Засаг нь худагдалгүй хагас жил хадъя. Хулгай хийхдээ хүн алсан хулгайчийг насанд нь худаглаа.

ССXXVI зүйл. Хүнийг шархдуулсан хулгайчийг худгаас гармагц хүн шархдуулсан мэсийн эзний гарыг нь хугалъя. Гарыг эдгэсний хойно мөн ёсоор засаглаж, түлээ түүлгэе. Мэсний эзэн эс танигдах ахул хулгайчийг энэ ёсоор засаглаа.

ССXXVII зүйл. Хулгайчийг хэн хүн худгаас гаргах ба барьсан, хадсаныг тавьбаас засгийн ноёд (хошуу засаг буюу хошууны засаг дарга), дацангийн лам (засгийн ноёдтой зэрэгцэх их эрх мэдэлтэй лам) бол долоон ес, туслагч (хошуу засгийн хавсарга буюу орлогч) ба эн гэлэн (их сахил авсан лам) бол зургаан ес, эн ноёд, тайж нар, хуврагууд бол таван ес, хошуу захирагчаас (хошууны өдөр тутмын ажлыг эрхлэн гүйцээдэг хүн) доош, албаны зарцаас дээшхи хэргэмтэн хулгайчийг тавьсан байвал хэргэмийг нь байлгаад (хэвээр байлгаад) хошуу захирагчийг гурван ес, майрны (мээрэн) зангийг (хошуу захирагчийн туслагч) хоёр ес, залны зангийг (буюу залан - ноёд сумангаас дээш хэд хэдэн сумын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулах хэргэмтэн) ес болоод тав, харьяат тайж, таван, отгын дарга, сумын занги, ес болоод гурав илүү, албаны заргыг ес болоод нэг илүү, эрхтэн дархтан (алба хашдаггүй онц эрхтэй болсон хүмүүс) бол ял нь ес болоод хоёр илүү, эцэг өвгийн удам угсаа, хэргэм зэргийг залгамжилсан онц эрхийн тэмдэг бичигтэй дархан хүн бол

бага жуух өгөөд их жуухыг ав авах, энгийн хүн бол аль нь нэг ес, засаг нь худагт байсан хулгайчийг тавьбаас тэр хулгайчийн оронд дутуу хоногийг гүйцэтлэх хадгалаад гарсан хойно нь тавь ташуурдъя. Хадсан хулгайчийг тавьбал мөнхүү дутуу хоногийг гүйцэтлэх хадаад хорин тав ташуурдъя.

ССХХVIII зүйл. Хулгайчийг тавнан хэн хүн гэрчилбэл ялын хоёр хувийг гэрчид шагнаа. Үлдсэнийг засагт автугай. Хулгайчийг алдваас ял нь тавьсны хагас.

ССХХIX зүйл. Тавин цайны үнээс доош үнэтэй ямар ч эд юм хулгай хийвэл хуучин цаазын ёсоор яллаж, засаг нь хулгайчийг хадмагц (барьмагц) даруй худаг ухсан газар хүргэж хадгалуулья.

ССХХХ зүйл. Ер хадсан, худагласан хулгайчийн хүнсийг нь хулгайчийг талах (шүүх), яллах (хорих) цагт өөрийн юмнаас нь үлдээж өгье. Алсан лугаа адил (хулгайчийн хүнсийг тасалбал түүнийг алсантай адил).

XI БҮЛЭГ. МОРЬ УРАЛДААНЫ ТУХАЙ ХУУЛЬ

ССХХХI зүйл. Ер уралдахад засуулаас гадна дөрвөн сайдаар гэрч тавих. Тэр гэрч сайд тэмдэг авч очоод уралдах хэмжээний газарт хүрээд тэр тэмдэг ил гаргамагц уралдана. Тэр газарт хүрэлгүй зуураас уралдвал засуул ноёдоос морь ав, тайж тавнангаас үхэр, энгийн засуулаас хонь авах.

ССХХХII зүйл. Уралдагч хүү уралдааны газар хүрэлгүй замаасаа эргэж давхих ахул уралдсан морийг нь хураан авч, унасан хүүхдийг арав ташуурдах.

ССХХХIII зүйл. Морь уралдааны газар уралдуулах мориноос өөр морь авч явж болохгүй, хэрэв хөтөлж яваа морио угтуулан тавибал унасан морийг нь авах.

ССХХХIV зүйл. Зуурчилж (замын хагасаас) уралдсан хүний морийг авахаас гадна ес авах, унасан хүүхдийг арав ташуурдах, замын дундаас уралдаанд орсон хүнийг тосон авч ирсэн тэр хүний морийг нь авах.

ССХХХV зүйл. Засуул (уралдааны морь баригч хүн) угтуулаас (уралдаанд оролцсон хүмүүсийг буцаж ирэхэд тосч авах хүмүүс) гадна зарлиггүй хүн очвол унасан морийг нь авч бай.

ССХХХVI зүйл. Уралдааны замаас дутуу эргэж ирвэл түүнийг гэрчлэх (хээр) замд тавьсан тэмдэг авч ирээд нэг мориор баалж бай. Эс ирсэн ноёдын (уралдаанд оролцсон хүмүүсийг дагаж хянаж шалгаж явах үүрэгтэй ноёд) пио тэмдгийг (гэрчлэх тэмдэг) холбоотой авах.

ССХХХVII зүйл. Уралдуулах морио шүдийг нь үзүүлэхгүйгээр авч явбал уралдаанд оролцох дугаар буюу тэмдэг өгөхгүй.

ССХХХVIII зүйл. Түрүүлж ирсэн морь удаах мориноосоо бүхэл биеэ өнгөрүүлбэл тооцох. Моринь зарим бие дутуу бол тооцохгүй. Хоёр морь зэрэгцэж ирвэл эцсийн тэмдэг хүртэл аль түрүүлбэл түүнийг тооцох. Хэрэв аль нэг нь түрүүлэхгүй бол дахиж уралдах.

ССХХХIX зүйл. Барианд орох морь унаад хүүхэд нь явганаар гүйж ирвэл уг морийг барианд орсонд тооцох.

ССХХI зүйл. Ер засуул, угтуул, морины хүүхдэд ташуур өгөхгүй. Хэрэв өгвөл ташуур өгөгчөөс хонь авах. Уралдсан морийг засуул дэмжиж хөөхгүй.

ССХХI зүйл. Уралдах хүүхдийг том, бага

гэхгүйгээр эзэн нь мэдтүгэй.

ССХХII зүйл. Ер ах наст морины насыг дарж уралдуулж болохгүй. Дүү настыг дээш ах настанд оруулж уралдахад гэмгүй. Ер уралдах морины насан лав дөрвөн захаас (үүдэн шүдний захын дөрвөн шүд) наашийг (дотогш) оруулж байх.

ССХХIII зүйл. Түрүүлсэн их соёлон морийг ноёд өөртөө авах бол нэг тэмээ, найман адуу хайрлаж авч бай. Түрүүлсэн хязгааланд нэг тэмээ, зургаан адуу, түрүүлсэн шүдлэнд нэг тэмээ, дөрвөн адуу, түрүүлсэн сарваанд (даага) нэг тэмээ, хоёр адуу өгөх.

XII БҮЛЭГ. ХУЛГАЙН ЦААЗАД ОРУУЛСАН НЭМЭЛТҮҮД

ССХХIV зүйл. Хийдийн сүргээс хулгай хийвээс ганц хар биеийг нь тавих (хулгайчийг ганцаарангий нь цөллөгт явуулах). Хамаг юмыг (хөрөнгө) нь авах.

ССХХV зүйл. Чулуун нүүрс, тоосго болгох түлээ, хураасан өвс зэрэг гэр ахуйн холбогдолтой юм хулгай хийвээс таван есөөр торгож шийтгэх.

ССХХVI зүйл. Хийдэд суусан хуврагийн сүрэг шавь нар (лам нарын мал сүргийг хариулдаг хүмүүс), хийдийн сахиулчин хулгай хийвээс ял нь эр мал арван хоёр ест, эм мал арван есөөр торгож шийтгэх.

ССХХVII зүйл. Эдэнгээс (лам хуврагуудын мал сүргийг хариулагчид, хийдийн сахиулчид) хулгай хийсэн хүн мэлээ болж шахлага болох (хулгай хийснээ хүлээхгүй, гэрч нотлох баримтгүй хэрэгт шахлага хэрэглэх) ахул зуун өрх албаттай ноёдоос дээшхи ноёдын хоёр сайдыг сонгож шахах, зуун өрхөөс доошхи албаттай ноёдын сайдыг шахаж бай.

ССХХVIII зүйл. Гаргаж өгвөл (сайд шахаанд орохоос айж хулгайчаа гаргаж өгвөл) хагас ял өгөх. Сайд мэдэж байж шахаанд орох (хулгай хийсэн хүнийг мэдэж байгаа боловч түүнийг хамгаалахын тул хэрэг хийгээгүй хэмээн өөрөө шахаанд орох) ахул ахлагчийг нь нэг тэмээ, хоёр соёлон морь, дүүгээс нэг тэмээ өгөх.

ССХХIX зүйл. Хулгай хийсэн хүний нэг сонгодгийг (хулгайч нарын толгойлогч) барьж өг. Барьж эс өгвөл нэг тэмээ, таван соёлон бодоор золжих. Эмийг зонд харих (төрсөн гэр орон, төрөл төрөгсдөдөө буцаж очих).

ССХХI зүйл. Биш хулгайчийн (хулгайч нарын толгойлогчоос бусад нь) халуун амийг өршөөж тэдний ял нь эс гүйцвэл хүүхдий нь барьж өг. Барьж эс өгвөөс амь бүрийг гурван хязгааланд бодоор золжих.

ССХХII зүйл. Өөрийн хошуунаас дуудаж ирүүлсэн хүн хулгайчийг харсан тухайгаа гэрчилж өгвөл гурван ес идэх. Зүгээр гэрч хоёр ес идэх. Хулгайчийг барьсан хүн хөлий нь цөм идэх. Хулгайд алдсан мал олж өгсөн хүнд нэг малаас хонь ид, хоёроос үхэр ид, гурваас арав хүртэл нэгийг идэх, арваас дээш бол арав бүрээс нэгийг идэх. Эдгээр идэшний орыг хулгайчаас авах.

ССХХIII зүйл. Хулгайч нарын ялд авсан малыг язгуурын санд (ноёдын санд бүртгэж аваад сүм хийдийн сүрэгт тавьж байх) авч хийдийн санд тавих.

ССХХIV зүйл. Хийдийн аймгийн улс (сүм хийдийн харьяа хэсэг бүлэг хүмүүс) гадна (гадны) хүнээс хулгай хийвээс ял нь эр мал арван ес, эм мал арван хоёр ест.

ССХХV зүйл. Хулгайч нарыг шахалганд оруулбал хоёр сайдыг (сүмийн харьяат

аймгийн хэргийг эрхлэх сайд) сонгож шахах. Хэрэв хулгайчийг гаргаж өгвөл хагас ял өгөх. Сайд хулгайчийг мэдэж атлаа шахаанд орвол толгойлогч сайдаас тэмээ, дараа сайдаас нь морь ав.

ССХХVI зүйл. Хулгайчийн авч яваа адууг алдуулсан хүн гурваас дээш арав хүртэл бол нэгийг идэх, нэг адууны төлөө хонь идэх, хоёр бол үхэр идэх.

ССХХVII зүйл. Сүм хийдийн аймгийн хүн адуу хулгайлсныг мэдсэн, гэрчтэй бөгөөд морьтой бол аль ойролцоо байгаа ноёдод айлтга. Тэр ноёдод нэхэл авч өг. Авч эс өгвөл хоёр тэмээ, хорин адуу авах.

ССХХVIII зүйл. Аль ойр байгаа айл, хүмүүст зарла. Зарласаар байтал эс очвоос баа (ял) нь тавнангуудаас нэг тэмээ, таван адуу, боржигон тайж нараас нэг тэмээ, нэг морь, дархан (дарга) түшмэдээс нэг тэмээ, энгийн хүнээс хоёр морь авах. Энэ бааны малын нас нь цөм хязгаалан байна.

ССХХIX зүйл. Гаднын хүнээс хүн босч ирж адуу хөөж иржээ (халхын гурван хошуунаас өөр газраас гурван хошуунд адуу хулгайлан хөөж иржээ). Хуврагийн шавь нар, хийд сахигчид зарласаар байтал эс очвол баа нь хийд сахигчаас хоёр хязгаалан морь авах, энгийн хүнээс нэг хязгаалан морь авах.

ССХХX зүйл. Хулгайд алдсан малаа нэхсэн газрын хошууны ноёдын зарсан улс (зарлага, элч) нэхэж хүрч ирэхэд хулгайд алдсан мал нь мөн байтал эс өгвөл аль ойролцоо байгаа их ноёдод айлтгаж элч авч хүр.

ССХХXI зүйл. Түүнд өр нэхэгчид эс өгвөл хаанд айлтга. Хоёр хааны элч очиж үл өгөгч ноёдод тэр юмыг авч өгөд, баанд нь гурван тэмээ, гучин адуу ав. Нас нь цөм хязгаалан.

ССХХXII зүйл. Урьдын нэхэгч ноёдод тэр бааны адуу, тэмээнээс нэг тэмээ, арван адуу өгөх. Ялнаас хоёр ес идэж бай.

ССХХXIII зүйл. Тавнангууд, тайж нар, энгийн харц хүмүүс зараар нэхэж явалцах (хулгайд алдсан малыг нэхэж явалцах) бол энэ идэшнээс идэлцэж бай (ял шийтгэлд хурааж авсан малыг хувааж авах буюу хувь ав).

ССХХXIV зүйл. Хийдэд хаан хүн гар хүрвээс (эвдэж гэмтээвээс) хар биеийг нь хөөж орхиё, хамаг улсыг (бүх албат боолыг) нь авья, харц хүн бол хар биеийг нь алья, хамаг юмыг нь авч бай.

ССХХXV зүйл. Хаан хүн нөхцөж өмөөрвөөс (сүм хийдэд халдсан хүнийг өмөөрвөөс) тавин гэр хүн, зуун хуяг, зуун тэмээ, мянган адуу, харц хүн өмөөрвөөс халуун амийг нь тавья, хамаг юмыг нь ав.

ССХХXVI зүйл. Хийдийн сахигчид гурван үйлээс бишид улаа бүү өг. Хэрэв элч хүн улаа унаваас нэг ес авах.

ССХХXVII зүйл. Их сүрэгчин (хошууны сангийн буюу сүм хийдийн сангийн мал хариулагч) хуврагийн шавь нар, хийд сахигчаар хавчуур (өөрийн гэх эзэн ноёнгүй, эзнээсээ босож оргож ирсэн хүмүүс) хүнийг явуул. Хөөж орхи.

ССХХXVIII зүйл. Хавчуурыг хэрэв явуулбал даргаас нь таван бод авч, явагч хүнээс таван бод, хавчуур зургаан бод авч бай. Энэ бол хавчуур хүн мөн хэмээн гэрчилсэн хүн бааны бодоос хоёр бод идэж бай.

ССХХXIX зүйл. Хавчуур миний малыг авлаа намайг шоглов (хохироов) хэмээн ноёдыг хуурч мэхэлвээс халуун амийг нь тавиад (ам бүлээр нь бүгдийг нь цөлөөд), хамаг юмыг нь



авч бай.

CCLXIX зүйл. Хавчуур улаа барьсан морио минийх бус, хүнийх гэж худал хэлж хуурч мэхэлвээс нэг ес авах. Нөгөө минийх гэж худал хэлсэн хүнээс мөн нэг ес авах.

CCLXX зүйл. Хуврагийн шавь нар, хийдийн сахиулагчид нутагтаа ноёдын өргөө барих буух (барих) газраас бусад газарт аль тааламжтайгаар (аль дуртай газраа) нутаглаж бай.

CCLXXI зүйл. Адуу хөөсөн хүмүүсийн мөр дор хүн дарагдаж үхвээс таван соёлон бодоор төлөх, морь үхвээс мөн тийм мориор төлөх.

CCLXXII зүйл. Хуврагийн шавь нар, хийд сахигчдыг шахаанд оруулах бол сайн сайдаар шахуулж бай. Түүнчлэн тэднийг их сайд тавангууд байвал мөн шахуулж бай.

CCLXXIII зүйл. Аливаа илт хулгай (дээрэм) хийсэн хүнийг дээдийн хуучин цаазын ёсоор (дайчин гүрний цааз буюу манжийн хуулиар) алаад, гэр мал ба эм, хүүхэд сэлтийг цөм малын эзэнд өгье. Бас дүү хулгайчаас (хамт явж хулгай хийсэн хүн) гурван ес мал авч малын эзэнд өгөөд зуун ташуур жанчихаас гадна хэрэв ял үл гүйцэх болвоос гэр бараа ба тогоо тулга зэрэг хамаг юмы нь нэг есөд бодож, хүүхэдтэй хүнээс есөн малд нэг хүүхэд бодож, хоёр есөд хоёр хүүхэд бодож өгөхөөс гадна хоёр хүүхдээс илүү барьж үл өгнө. Хүүхэдгүй эр нь эмтэй бол эмий нь барьж өгье. Ганц бие хүн бол мөнхүү биеийг нь барьж өгье. Мал ба эхнэр, хүүхдийг өгөвч эрхгүй дутсан ялын мал буй болбоос дээдийн цаазын ёсоор малын төлөө хорин таван ташуур жанчихдаа зуугаас бүү хэтрүүл.³

ХИИ БҮЛЭГ. ТОЙН БОЛОХ ТУХАЙ ХУУЛЬ

CCLXXIV зүйл. Ер гэрээ тэвчиг (гэрээ орхиж) тойн буюу палам (лам) болох хүн номын ёсоор эзэн ба эцэг, эхээсээ асууж тойн болох. Өгөгч палам ч (лам) асууж өгтүгэй. Эцэг эх нь хол ба эзэн ноён нь хол болоод сонсгож үл болох учир тойн болохдоо аймгийн засагдаан сонсгож зөв гэвэл автугай.

CCLXXV зүйл. Тойн болсон хойно номын ёсон лугаа барилдсан (нэгэнт сахил санваар авсан) тойн хувраг өөр ертөнцийн (аль нэгэн) ноёдод харьяалагдахгүй. Өөрийн санаагаар биеэ мэдэх.

CCLXXVI зүйл. Хэрэв эзэн ба эцэг эхийн зөвшөөрөлгүйгээр тойн болох ахул толгойгоо бүү мэдтүгэй.

CCLXXVII зүйл. Лав магад сүжгээр болохыг эзэн нь саад бүү хийтүгэй.

CCLXXVIII зүйл. Хийд ба дацан мэт аймагласан тусгаар тогтносон (олон аймаг, хошуунаас хийд ба дацанд ирээд өөр өөрийнхөө аймагт тогтоосон дэг журам буюу хуульд захирагдан аймаг аймгаараа оршин суух) хуврагууд тэр аймгийн цаазаар болох. Аймаг хийд, дацанд сууж бай.

CCLXXIX зүйл. Барилдсан болох (аймаг, аймгаараа оршин суух) ахул санаагаар толгойгоо мэдэж очихгүй.

CCLXXX зүйл. Хийд дацанд эс багтсан тойн хүн өөрийн дурраар аль нэг аймагт очвол ямар нэгэн алба төлөхгүй, зөвхөн өөрийн олсон хувьт юмаа авч очих.

CCLXXXI зүйл. Ер хувраг болон өөрийн эрх мэдэлтэй шавь нарт гурван үйлээс бишид улаа шүүс өгөхгүй.

CCLXXXII зүйл. Мэдэл бус (өөрийн эрх ³ Н.Лүндэндорж, 2002 он, Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага, УБ хот, Адмон, 217 дахь тал.

мэдэлгүй, эзэндээ алба барьдаг) хүн лугаа нэг өмчтэй бол улаа шүүс өг.

CCLXXXIII зүйл. Хуврагт гүрэм хийлгэж барьсан, эмч нарт өвчин үзүүлж барьсан юм өргүй.

CCLXXXIV зүйл. Ямар ба ертөнцийн (ердийн) хэлэлцээ, тохиролцоо хийж буй хүмүүс аль хошуунд оршин сууж байна тэр хошууны цаазын дагуу шийдэж бай.

CCLXXXV зүйл. Өөр газар одоод сахилаа эвдвээс угт (тэр нутгийн) ноён нь нэхэж автугай (сахилаа эвдсэн тул алба барих).

CCLXXXVI зүйл. Хийд хүрээ, дацанд гаднаас ирсэн тойн хүн түүнээсээ гарвал мөн тэр аймгийн цаазаар явах. Хэрэв гарч явах бол өөрийнхөө олсон юмтайгаа л очтугай. Мөн тэр аймагт оршин сууя гэсэн бол бүрмөсөн суутгай.

CCLXXXVII зүйл. Өөр орон төвд, хятад мэт бус газраас ирсэн сахилгүй бөгөөд буяны явдалт эмч зурхайч лав мөн бол хуврагийн цаазын ёсоор ганц биеэ мэдэх. Өөрөө олсон юмаа авч очих. Өөр хэлт ийм хүнд гурван үйлээс бишид улаа шүүс өгөхгүй.

CCLXXXVIII зүйл. Баруун талаас (голдуу төвдөөс) ирсэн палам нарын тухай. Богд гэгээнд (Жавзандамба) айлтгаж залж ирсэн лам, эмч нар хэн ч бай бүгдээрээ гэгээний зарлигийг сахин биелүүлж байх ёстой бөгөөд тэд хэр чинээгээрээ сайн үйлс хийвээс сайн, харин муу аашлах мэт шалтгаанаар буруутваас мөн гэгээний зарлигийг эс сахисан учир гэм буруутайд тооцно.

Залагдаж ирсэн хүмүүс оршин байгаа газар орныхоо ёс журмыг үл хүндэтгэх ба муугаар авирлаваас зарлигийг санаатайгаар зөрчсөн хэрэгт авч үзнэ. Энэ хэргийн үнэн эсэхийг тогтооход бэрх тул ойр агсан гэрч болох их лам ба их ноёд гэрчилвэл зохино. Хэрэв ламын буруу бөгөөд нутагт нь буцааж явуулахаар бол анх залж ирүүлэхдээ тогтоож өгсөн хугацааг дуустал байлгаж бай. Хэрэв өргөл барьж өгсөн хүн өөрөө буруутвал гэм буруугийд тооцогдсон хүн хэдий болтол оршин суухаа өөрөө мэдтүгэй.

CCLXXXIX зүйл. Төвд тэргүүтэн өөр орноос ирсэн тойн ба залж ирүүлсэн эзэн хоёулаа эхэлж уулзахдаа сайн сайхан байвал ингэе, муу муухай байвал тэгий гэж хэлэлцэн тохирсон бол түүгээрээ байх, тийнхүү хэлэлцэн тохирсон зүйлгүй бол зөвхөн өөрөө олсон юмаа аваад л явтугай.

ССХС зүйл. Ер гаднаас ирсэн тойн хүн гэм хийсэн бол урьд хаанаас ирсэн байваас тэр зүгт нь явуул. Түүнийг ноён хүн саатуулбал есөөр торгож шийтгэ, харц хүн саатуулбаас нэг морь ав.

ССХСИ зүйл. Ямар ба хэлэлцээ мэт зүйлийг аль ноёдын дэргэд хийсэн байна, тэр ноёдын цаазаар болтугай.

ССХСИИ зүйл. Аймаглан тогтсон хуврагийн аймгийн тойн, тухайн хийд, аймгийн тогтсон цаазад (өөрийнхөө харьяалагдаж байгаа хийд, аймгийн дагаж мөрдөж буй дэг журам) захирагдаж байна.

ССХСИИ зүйл. Гаднаас ирсэн лам эрдэм сурах зэрэг буянт хэрэг болон хүний амьдралын ерийн хэргийн талаар өөрөө өөрийгөө мэдэж явах (Харин тухайлан заасан болзол байвал түүнийг зөрчиж үл болно).

ССХСИV зүйл. Төвд зэрэг өөр орноос ирсэн тойн ба тойн бус аль ч тэр тус оронд нийтээр дагаж мөрдөж байх ёстой цаазад захирагдаж

байвал оршин сууж болно.

ССХСV зүйл. Өөр орноос ирсэн тойн бус бөгөөд буяны явдалт илбэчин (увдистан, ид шидтэн), эмч, зурхайч мэтийн хүмүүс өөр бусдад тус хүргэж нийтээр дагаж явах ёстой цаазаар явбал зохино.

ССХСVI зүйл. Тойн хүнийг хар хүн хөөж явуулж буюу хүнд хэрэгт гүжирдэж оруулжээ гэтэл тойн сүх чанга атгаж (шахаанд орж) хэрэг хийгээгүй ариун болж гарах бол тэр хүнээс гурван зуун анзуу авах, үүнд: зуун тавь нь бод, зуун тавь нь хонь байна. Анзуугаа эс гүйцээвээс халуун амий нь малтай нь хамт тэр тойнд барьж өгөх. Малгүй гэвэл албатын даргыг нь, тайж тавангийн авгай аваагүй зээ хүүг шахах. Ноён нь хүнээ авах дуртай бол ялыг нь гүйцээж өгч автугай. Ялаа эс гүйцээвээс тойнд халуун амийг нь малтай нь цөм барьж өгье.

ССХСVII зүйл. Хэн хүн гүжрээр яллаж ямар амьтныг алваас тэр хүнийг өөрийн нь яг тэр ялаар яллаж байх.

ХИВ БҮЛЭГ. АРХИ УУХЫГ ХОРИГЛОХ ТУХАЙ ХУУЛЬД ОРУУЛСАН НЭМЭЛТ

ССХСVIII зүйл. Гэлэн хүн архи ууваас гурван мориор баалъя. Гэцэл хүн ууваас хоёр морь, банди ууваас нэг морь, хиа лам нар, хаалгачин ууваас хоёр мориор баалаад цөмийг хар болгож отогт нь гаргая.

ССХСIX зүйл. Албан хэргээр явагч хар хүн архи ууваас нэг мориор баалъя. Эдэнгийн бааны морийг гэрчилж гаргасан хүнд өгье.

ССС зүйл. Архи уугчийг хэн хүн дарваас нэг мориор баалъя.

СССИ зүйл. Эдэнд хэн хүн архи өгвөөс нэг мориор баалъя. Эдэнгийн бааны морийг санд тавья.

ДҮГНЭЛТ

Манжийн ноёрхлын үед Монголчуудын хувьд тусгаар тогтнол бүрэн эрхт байдлаа хэвээр хадгалан, улс төрийн хувьд нэгдмэл байхыг эрхэмлэсэн, тухайн үеийн Монгол орны дотоод амьдралын харилцааг түгээмлээр зохицуулахад чиглэж, өмнөх хуулиудаар бүрэн зохицуулагдаагүй олон харилцааг зохицуулсан “Халх журам” хуулийн хэм хэмжээнүүд нь хойч үеийн хууль цаазын түүхэн эх сурвалжуудын нэг билээ.

Ном зүй:

1. Монгол улсын Хууль зүйн яам, 1995 он, Халх журам, УБ хот, Үнэт цаас хэвлэлийн газар
2. Ц.Жамсранов, И.А. Турунов “Халх журам”, 1923 он
3. В.А.Рязановский, 2000 он, Монголчуудын хууль цаазын дурсгал бичгүүдийн түүхэн тойм, Их засаг хууль, УБ хот
4. Н.Лүндэндорж, 2002 он, Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага, УБ хот, Адмон
5. С.Жалан-Аажав, 1958 он, Халх журам бол Монголын хууль цаазын дурсгалт бичиг мөн, УБ хот, Цэргийн хэвлэх үйлдвэр
6. Н.Ням –Осор, 2010 он, Эзэн Чингис хааны Их засаг хууль, УБ хот, Арвай бурхан хэвлэлийн газар
7. Л.Жамсран, Д. Цэвээндорж, Монгол Улсын түүх. Дөтгөөр боть (XVII-XX зууны эхэн), 2003 он, УБ хот, Адмон
8. Б.Содовсүрэн, 1989 он, Хувьсгалын өмнөх Монголын төр ба хууль цааз, 1911-1920, УБ хот.
9. БНХАУ-ын судлаач Дорнотив, Халх журам, 1989 он, ӨМӨЗО.

ЛЕГАС ХХК НИЙГМИЙН ХАРИУЦЛАГАА ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА

Легас компани нь нийгмийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагынхаа хүрээнд илүү өргөн далайцтай үйл ажиллагаа явуулахыг зорин ажиллаж байна.

Өнгөрсөн сард "Хүүхэд асран хүмүүжүүлэх төвийн цэцэрлэг"-ээр айлчилсан сэтгэгдлээ уншигч тантай хуваалцахыг хүслээ. Юуны өмнө, энхрий бяцхан үрсийг эрүүл энх өсгөж бойжуулах, хүмүүжүүлэх, боловсрол олгоход бүхий л хичээл зүтгэл, хүч хөдөлмөрөө шингээн ажиллаж буй тус төвийн багш, сурган хүмүүжүүлэгч, ажилтан нартаа чин сэтгэлийн талархал илэрхийлэе. Ачлал энэрэлд нь өсч торниж буй хүүхдүүдийг хараад сайхан сэтгэлтэй, цагаан гартай энэ л хүмүүсээр улам их бахархах сэтгэл төрж байлаа.



Энэ удаад бид Худалдаа хөгжлийн банкинд 495061652 тоот хандивын данс нээж, анхны хандивыг байршуулсан бөгөөд уг дансаар цугларсан хандивыг тус төвийн хүүхдүүдийн хэрэгцээт зүйлсэд зориулах юм. Уншигч та буяны энэ үйлсэд нэгдэхийг хүсвэл бидэнтэй 324587 дугаарын утсаар холбогдох буюу donation@legas.mn хаягаар хандаарай. Бид хамтдаа илүү ихийг бүтээж чадна. Халуун сэтгэлт хандивлагч та бүхэнд хандивын дансны орлого зарлагын тайланг бид өөрийн вэбсайт болон "Эрх зүйн хөтөч" гарын авлагаараа дамжуулан сар бүр тайлагнаж байх болно.

Цаашдаа манай хамт олон улсын төсвөөр тэр бүр аваад байх боломж дутмаг зүйлс, тэр дундаа дархлаа сайжруулах витамин, төрөл бүрийн сүү цагаан идээ, жимс жимсгэнэ, түүнчлэн сонирхолтой, хэрэгцээт ном, сурах бичиг, хичээлийн хэрэгсэл зэргээр байнгын дэмжлэг туслалцаа үзүүлэх болно.

Элэг нэгт Монгол ахан дүүсээ, хүүхэд багачууддаа инээд баясал бэлэглэж, магнай тэнүүн амьдарцгаая.

ЭРХ ЗҮЙН САЛБАР ДАХЬ АЖЛЫН БАЙР

Эрх зүйн салбарт ажилд авна

Эрх зүй судлаач - Эрх зүйн чиглэлээр дээд боловсрол, мэргэжил эзэмшсэн, мэргэжлээрээ хоёроос дээш жил ажилласан туршлагатай, эрх зүйн судалгаа хийх туршлага, сонирхолтой, мэргэжлийн өндөр үр чадвартай, англи хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй, монгол хэлийг мэргэжлийн түвшинд эзэмшсэн, хэл бичгийн өндөр соёлтой, мэдээлэл зохион байгуулах, боловсруулах чадвартай, хувийн зохион байгуулалт сайтай, харилцааны соёлтой, бизнесийн ёс зүйн төлөвшил өндөртэй, багаар ажиллах чадвартай, офисын хэрэглээний програм, тоног төхөөрөмж, интернэтийг хэрэглээний түвшинд бүрэн ашиглах чадвартай, арбитр, эвлэрүүлэлт, үнэт цаасны эрх зүйгээр дагнан ажиллах хүсэл сонирхолтой эрх зүй судлаач. Хаяг: УБ, СБД, 3-р хороо, Усны гудамж, 11-р цогцолбор, Лонг Бизнес төв, Бадмаараг офис, "Legas" ХХК, humanresources@legas.mn, 324587, 91999129.

Ахлах хуульч - Компаниас бусад байгууллага, иргэдтэй байгуулах гэрээ хэлцлийн хууль эрх зүйн үндэслэлийг хянаж санал өгөх, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих, олон улс хоорондын гэрээ хэлцэл хийх, компанийн удирдлага, ажиллагсдыг хууль эрх зүйн мэдээллээр хангах, хуулийн хүрээнд компанийн үйл ажиллагааг явуулахад анхаарч ажиллах, нэр хүнд, эрх ашгийг хамгаалах, хэрэг маргааныг шийдвэрлүүлэх, олон улсын эрх зүй болон бусад хуулийн чиглэлээр бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй, компанийн эрх зүйн чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай, олон улсын болон байгууллага хоорондын гэрээ хэлцэлд ажиллаж байсан туршлагатай, албан бичгийн төсөл боловсруулах, гэрээ хэлцэл байгуулах, компанийн үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд хуулийн зөвлөгөө өгөх чадвартай, англи хэлний бичгийн болон ярианы өндөр түвшний мэдлэгтэй ахлах хуульч. Хаяг: УБ, СБД, Ерөнхий сайд Амарын гудамж-7, Петровис компанийн байр, "Петровис" ХХК, hr@petrovic.net, 99902626.

Хуулийн зөвлөх - МУИС-ийн Хууль зүйн сургууль төгссөн, мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан ажлын туршлагатай, англи хэлний өндөр мэдлэгтэй, багаар ажиллах чадвартай, хариуцлагатай, хувийн зохион байгуулалт сайтай хуулийн зөвлөх. УБ, ХУД, Капитал хаусын 3 давхарт 314 тоот, "Шунхлай" ХХК, ariunaa@shunkhlai.mn, 91918660.

Хуульч - Тухайн мэргэжлийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, мэргэжлээрээ ажиллаж байсан туршлагатай, англи хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй, харилцааны соёлтой, харилцагчид хандах өндөр үр чадвартай, бүтээлч сэтгэлгээтэй, ажлын ачаалал даах чадвартай хуульч. Хаяг: УБ, СБД, 3-р хороо, Усны гудамж-1, Үндэсний хөрөнгө оруулалтын банк, info@nibank.mn, 321995, 75757070.

Захиргаа, хүний нөөцийн ажилтан - Хүний нөөц, бизнесийн удирдлага болон хууль, эрх зүйн чиглэлээр суралцаж төгссөн, компьютерийн хэрэглээний программ, интернэтийн орчин, дотоод сүлжээний программууд дээр ажиллах чадвартай, багаар ажиллах чадвартай, харилцааны өндөр соёлтой, албан бичиг баримт төлөвлөх, боловсруулах, хөтлөх чадвартай, өмнө нь хүний нөөцийн ажил эрхэлж байсан туршлагатай, ажлын ачаалал даах, хувийн зохион байгуулалт сайн, хурдан шаламгай хөдөлдөг хүний нөөцийн ажилтан. Хаяг: УБ, ХУД, 3-р хороо, үйлчилгээний төвийн ард Уран ган компанийн байр 5 тоот, "Cherry Creek" LLC, cherry@cherrycreek.mn, 89050570.

Хуульч, эрх зүйч - Хууль, эрх зүйн мэргэжилтэй, мэргэжлээрээ ажилласан ажлын туршлагата, компанийн эрх зүйн чиглэлээр 2-оос дээш жил ажиллаж байсан бол давуу тал болно, гадаад хэлний зохих түвшний мэдлэгтэй, бичиг хэрэг төлөвлөх, монгол хэлний найруулга сайтай байх, компьютерийн хэрэглээний программууд дээр ажиллах чадвартай, байгууллага хоорондын гэрээ хэлцэл, шүүх хоорондын маргаан, тендерийн чиглэлээр ажиллаж байсан туршлагатай бол сайн, цаашид тогтвор суурьшилтай ажиллах чин эрмэлзэлтэй байх, 35 хүртэлх насны хуульч эрх зүйч. Хаяг: БЗД, 25-р хороо, 39А/1 байр, "Гангар Инвест" ХХК, gangan_invest@yahoo.com, 95953370.

Хуулийн мэргэжилтэн - Хууль, эрх зүйн мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай, англи хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй, албан бичиг төлөвлөх, бичиг баримт боловсруулах өндөр чадвартай, ажлын ачаалал даах, шийдвэр гаргах чадвартай хуулийн мэргэжилтэн. Хаяг: УБ хот, СБД, 1-р хороо, Олимпийн гудамж- 8 (хуучнаар Болгар улсын элчин сайдын яамны байр), "Алтайн Хүдэр" ХХК, hr@altainkhuder.mn, 70117991, 324930.

Эрх зүйн салбарт ажил хайж байна

д/д	Нэр	Сонирхож буй ажлын байр	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Холбогдох утас
1	О.Баярбаясгалан	Хуулийн зөвлөх	МУИС-ХЗС	Эрх зүйч	89006106
2	Х.Ихбаяр	Эрх зүй судлаач	ИЗИС	Эрх зүйч	95123183 88833183
3	Ц.Шагдарсүрэн	Хуульч	МУИС-ХЗС	Эрх зүйч	95129610
4	Б.Буянжаргал	Хуульч, Хүний нөөц	ИЗИС	Эрх зүйч	96262741
5	Д.Тэмүүлэн	Эрх зүйч	МУИС-ХЗС	Бизнесийн эрх зүйч	99603181
6	Б.Гэрэл	Хуульч	Өвөр Монголын их сургуулийн хууль зүйн ухааны сургууль	Олон улсын эрх зүйч	99026241
7	Ц.Сайханжаргал	Хуулийн зөвлөх	МУИС-ХЗС	Эрх зүйч	88665099
8	Д.Ренчиндорж	Захиргааны эрх зүйч	МУИС-ХЗС	Эрх зүйч	89017707
9	А.Онон	Хуульч	МУИС-ХЗС	Эрх зүйч	99071397
10	Х.Оюунбаяр	Эрх зүй судлаач	Шихихутуг ХЗДС	Эрх зүйч	99664186

СЭТГҮҮЛИЙГ ЭРХЛЭН ГАРГАГЧ: ЛЕГАС ХХК

Редакцын бүрэлдэхүүн: Г.Батцогт, Ц.Жаргалмаа, Д.Мөнхчимэг, Э.Наранчимэг, Д.Өэлүн-Үжин, Ц.Санжаалхам, Ц.Хишигтогтох, Г.Эрхэмбаяр

Сэтгүүлийн эх бэлтгэлийг: Г.Батцогт

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, Усны гудамж-11

Утас: 976-11-324587

Вэбсайт: www.legas.mn

Цахим шуудангийн хаяг: office@legas.mn

Уншигч та бүхэн "Таны эрх зүйн хөтөч" гарын авлагыг сар бүр, цахим хэлбэрээр захиалахыг хүсвэл legas@mongol.net хаягаар хандана уу.

© Энэхүү хэвлэл нь Легас ХХК-ийн оюуны өмчийн эрхээр хамгаалагдсан бөгөөд Легас ХХК-ийн нэрийг эш татаж дурдалгүйгээр бүхлээр нь болон хэсэгчлэн хуулбарлахыг хориглоно.

ХАРИУЦЛАГААС ЧӨЛӨӨЛӨГДӨХ ТУХАЙ МЭДЭГДЭЛ

"Таны эрх зүйн хөтөч" гарын авлага нь Легас ХХК-ийн эрх зүйн албанаас эрхлэн гаргаж буй компанийн хамт олны бүтээл юм. Гарын авлага дахь нийтлэл, мэдээллийн агуулгыг бодит баримтын хувьд үнэн, зөв, оновчтой, бүрэн гүйцэд байлгахад зүй ёсны хүчин чармайлт гаргасан хэдий ч Легас ХХК эсхүл редакцын гишүүдийн хэн нь ч агуулгын төлөө үүрэг, хариуцлага хүлээхгүй бөгөөд гарын авлагад орсон мэдээллийг хэрэглэсэн эсхүл түүнд түшиглэсэн, эш татсанаас шууд эсхүл шууд бусаар учирч болох аливаа гэм хор, алдагдал, хохирлыг хариуцахгүй болно.

Энэхүү гарын авлага нь уншигч тус бүрийн нөхцөл байдалд нийцсэн мэргэжлийн зөвлөгөө бус, харин ерөнхий мэдээлэл, лавлагаа өгөх зорилготой болохыг уншигч та бүхэн анхаарах нь зүйтэй.





Манай компанийн Эрх зүйн алба нь үндэсний болон олон улсын гэрээ хэлцэл боловсруулах, эрх зүйн дүгнэлт өгөх, эрх зүйн орчны судалгаа шинжилгээ хийх, хууль зүйн тодорхой чиглэлээр зөвлөгөө өгөх үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд чанартай, найдвартай гүйцэтгэдэг. Мэргэжилтнүүд маань аливаа захиалга бүрт өөрсдийн ур чадвар, нягт нямбай чанарыг бүрэн дайчилж, мэргэжлийн ёс зүйг баримтлан, үйлчлүүлэгчийнхээ нууцыг чандлан хадгалах үүргээ үргэлж сахин биелүүлдэг бөгөөд энэ нь бидний ажлын гол арга билээ.

Дор дурдсан салбаруудаар дагнан мэргэшсэн хуульч, эрх зүйчид маань та бүхний энгийн болон яаралтай аливаа захиалгад эрх зүйн нэгдсэн мэдээллийн сан, эрх зүйн мэргэшүүлэх сургалтын алба, хууль зүй, техникийн орчуулгын албадынхаа туршлага, нөөц бололцоонд түшиглэн, ашиг сонирхолд тань нийцсэн эрх зүйн үйлчилгээг хүргэх болно. Үүнд:

- Уул уурхай, ашигт малтмалын эрх зүй буюу ашиглалтын эрх зүй;
- Өв залгамжлалын эрх зүй
- Үнэт цаасны эрх зүй
- Компани, хөрөнгө оруулалтын эрх зүй
- Татварын эрх зүй
- Гэрээний эрх зүй
- Арбитр
- Эвлэрүүлэлт
- Эрсдэлийн менежмент.

Манай эрх зүйн үйлчилгээг сонгон үйлчлүүлснээр та дараах урамшууллыг эдлэх боломжтой болно. Үүнд:

- Эрх зүйн судалгааны албаар нэг жил тогтмол 10%-ийн хөнгөлөлттэй үйлчлүүлэх
- Хууль зүй, техникийн орчуулгын албаар нэг удаа 10%-ийн хөнгөлөлттэй үйлчлүүлэх
- Эрх зүйн мэдээллийн сан дахь хуулийн орчуулгаас өөрийн сонгосон хуулийг 20%-ийн, өөрийн сонирхсон салбарын хууль тогтоомж, дүрэм, журмын багцыг 15%-ийн хөнгөлөлттэй үнээр худалдан авах
- Эрх зүйн мэргэшүүлэх сургалтын албаны ээлжит сургалтад 15%-ийн хөнгөлөлттэй үнээр хамрагдах.

Бид Тантай хамтран ажиллахдаа үргэлж баяртай байх болно.



Улаанбаатар хот, СБД, 3-р хороо
Усны гудамж, 11-р цогцолбор
Лонг бизнес төв, Бадмаараг офис



+ 976 11 324587



office@legas.mn, legas@mongol.net
www.legas.mn

ТАНЫ СУРТАЛЧИЛГААНЫ ОРОН ЗАЙ

ЭРХЭМ ТАНД

Хамтран ажиллах урилга

Сайн байна уу? Сайхан намаржиж байна уу?

2003 оноос эхлэн эрх зүйн судалгаа, зөвлөгөө болон хууль зүй, санхүү, техникийн орчуулгын чиглэлээр үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж, ажил үйлчилгээнийхээ чанараар гадаад, дотоодын харилцагч, үйлчлүүлэгчдийнхээ итгэл, хүндэтгэлийг хүлээсээр ирсэн манай компани нь бизнес эрхлэгч хэн бүхний хамгийн үнэнч анд нь байх эрх зүйн хөтөч бий болгож, чанартай, шинэ, бодит мэдээллээр хангах зорилтынхоо хүрээнд сар тутмын "Таны эрх зүйн хөтөч" гарын авлага гаргаж эхлээд, өдгөө хоёр дахь дугаараа толилуулж байна.

Бид "Таны эрх зүйн хөтөч" гарын авлагынхаа дугаар бүрийг Монгол улс дахь нэг сая орчим хэрэглэгчдэд цахим хэлбэрээр үнэ төлбөргүй түгээдэг.

Та бүхнийг өргөн хүрээтэй шинэлэг мэдээ мэдээлэл бүхий энэхүү гарын авлагад маань өөрийн байгууллага болон үйл ажиллагааныхаа сурталчилгааг байршуулж, харилцан ашигтай хамтран ажиллахыг урьж байна.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл office@legas.mn хаягаар эсхүл 70110664 дугаарын утсаар бидэнд хандаарай.

Таны ажил үйлсэд өндөр амжилт хүсье.

Легас ХХК-ийн хамт олон

